



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



ЖИЛИЙН  
ТАЙЛАН | **2020**

Хэвлэлийн эх бэлтгэл, дизайныг А.Чинбат

Хавтасны дизайныг А.Чинбат, Д.Балжид

Хавтасны зургийг Б.Тэмүүжин

Тайланд орсон үйл ажиллагааны зургуудыг Б.Мөнхгэрэл, Э.Сайнтүвшин



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



# Ковид-19 цар тахлын үед  
АЖЛАА ГЭРЭЭСЭЭ...

ЖИЛИЙН  
ТАЙЛАН

2020

# ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ	3
ӨМНӨХ ҮГ	4
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ</b>	
Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх нь	8
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох нь	14
Төсвийн хариуцлагыг сайжруулах	22
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих нь	35
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ</b>	
Хүний эрх	48
Эрүүгийн эрх зүйн шинэчлэл	54
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	61
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	68
<b>БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО</b>	
Тэгш хамруулах боловсрол	72
Залуучуудын дундах хүчирхийлэл дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх	77
<b>ЦАР ТАХЛЫН ХАРИУ ҮЙЛДЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>82</b>
<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>	<b>90</b>

# ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АШУҮИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОС	Байгаль орчны сан
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЁЗХ	Ёс зүйн хороо
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХХ	Монголын хуульчдын холбоо
МУБИС	Монгол Улсын Багшийн Их Сургууль
МУҮХ	Монгол Улсын Үндсэн хууль
НДС	Нийгмийн даатгалын сан
МҮОНТ	Монголын Үндэсний олон нийтийн телевиз
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НЭМС	Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОНХАГ	Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХС	Сүм хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

# ӨМНӨХ ҮГ

Дэлхий нийтийг хамарсан хүнд сорилтын үед бид бүтэн жилийн гуравны нэгтэй тэнцэх хугацаанд үйл ажиллагаагаа алсын зайнаас гүйцэтгэн шинэ нөхцөл байдал манай улсын засаглал, боловсрол, хүний эрхийн зэрэг тулгамдаж буй асуудлаар ажиглалт мониторинг, судалгаа шинжилгээ хийж, оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг

өрнүүлэн олон нийт болон бодлого боловсруулагчдыг чанартай, бодитой мэдээллээр хангахад хувь нэмэр оруулахыг зорьж ажиллалаа. Ийнхүү урьд өмнө төдийлөн туршиж хэвшээгүй, өөр нөхцөл байдал хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг уламжлал ёсоор нэгтгэн уншигч Та бүхэндээ үүгээр тоймлон танилцуулж байгаадаа баяртай байна.

Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоо нэн чухал бөгөөд энэхүү оролцоог хангахад чиглэсэн хуулиуд батлагдан хэрэгжиж байна. ННФ-ын зүгээс Нийтийн сонсголын тухай болон Захиргааны ерөнхий хуулиуд, түүнчлэн иргэний нийгмийн зүгээс нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг нээсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор баруун 5 аймагт сургалт зохион байгууллаа. Уг сургалтад төрийн болон төрийн бус байгууллагыг төлөөлж 100 гаруй хүн оролцсон ба орон нутгийн төрийн бус 10 байгууллагад энэ чиглэлээр ажиллах тэтгэлэг олгоод байна.



# ОНЦГОЙ НӨХЦӨЛ, ШИНЭ ОРЧИН

Ковид-19 цар тахлын үед УИХ-ын ээлжит сонгуулийг тасралтгүй, халдвар хамгаалал хангасан нөхцөлд явуулах нь чухал байв. Энэ нөхцөл байдалд бид олон улсын туршлагыг нутагшуулах, холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах зэрэг чиглэлээр тодорхой санал, санаачилга гаргаж ажиллалаа. Тухайлбал, 2019 оны 12 дугаар сард

батлагдсан Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд тусгагдсан сонгуулийн санхүүжилтийг ил тод болгоход чиглэсэн нааштай зохицуулалтын хэрэгжилтийг хангах, хяналт тавихад иргэний нийгмийн болон төрийн холбогдох байгууллага, судлаачдад дэмжлэг үзүүлж хамтарч ажиллалаа. Мөн сонгуулийн санхүүжилтэд хяналт тавихад гол үүрэг хүлээх Төрийн Аудитын байгууллагад нам, нэр дэвшигчдээс зардлын тайлан хүлээн авах маягтууд, дагалдах заавар, аргачлалыг бусад улсын сайн туршлага, жишээг ашиглан боловсруулах, техникийн түслалцаа үзүүлэхэд Оюуны Инноваци ТББ-тай хамтарч ажиллалаа. Санал хураах өдрөөс өмнө олон нийтэд ил болгосон нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын болон тэдэнтэй холбоотой бусад мэдээллийг [www.opendatalab.mn](http://www.opendatalab.mn) цахим хуудаснаа байршуулав.

ННФ-ын санаачилгаар анх 2007 байгуулагдсан “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн байгууллагуудтай хамтран шударга сонгуулийн гол зарчим болох өрсөлдөөний тэгш гарааг хэрхэн хангаж буйд хэд хэдэн чиглэлээр

мониторинг хийлээ. Үүнд, Глоб Интернэшнл ТББ Хэвлэл мэдээллийн сурталчилгаанд, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв Нийгмийн сүлжээн дэх сонгуулийн сурталчилгаанд, МИДАС ТББ Сонгуулийн автоматжуулсан системийн болон Сонгогчдын нэрийн жагсаалтад тус тус мониторинг хийлээ. Мөн сонгуулийн өдөр Нийслэлийн 99 хэсгийн хороо; Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Хэнтий, Төв зэрэг таван аймгийн 13 хэсгийн хороодод ажиллан санал авах, тоолох, дүнг дамжуулах, хяналтын тооллого хийх хороодыг сонгох, хяналтын тооллого гүйцэтгэх зэрэг үйл ажиллагаанд Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд, Бодлогод залуусын хяналт ТББ-ууд хамтран сайн дурын 203 ажиглагчийг оролцуулан сонгуулийн ажиглалт зохион байгууллаа.

Бид улсын төсвийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд бие даасан судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээ, хяналт мониторингийг тогтмол хийж ирлээ. 2020 оны хувьд төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд нь Төсвийн тухай хууль дахь төлөвлөлтийн шаардлагыг хангаж буй эсэх, дуусаагүй барилгуудыг төсөвт тусгасан эсэхэд зарим дүн шинжилгээ хийж, анхаарах асуудлуудыг хөндсөнөөс гадна төрийн аудитын байгууллагаас улсын төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтад хийсэн хяналт шалгалтын мэдээллийг нийтэд энгийнээр хүргэх, төсөвт туссан үр ашиг муутай хөрөнгө оруулалтын баримт мэдээллийг багцлан дахин шинжилж, үр дүнг олон нийтэд танилцуулах чиглэлээр тодорхой ажлууд хийлээ. Тэрчлэн иргэний нийгмийн зүгээс төсвийн хариуцлага нэхэх, түүнд нутгийн иргэдтэй хамтрах үйл ажиллагааг өргөтгөх, иргэдийн оролцооны шинэ механизм болох “Төсвийн хяналтын сонсгол”-ыг тогтмолжуулах, төрийн аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллав. Тухайлбал, 10 гаруй аймаг, нийслэлийн нийт 19 ТББ-ын төслийг дэмжиж ажилласнаар орон нутгийн төсвийн болон зарим тусгай сангийн зарлага, худалдан авалтын мэдээллийн иргэдэд хүрэх урсгал нэмэгдсэнээс гадна ТББ-ууд болон

Иргэдийн төлөөлөгчдийн хурал хамтран зохион байгуулсан төсвийн сонголлуудад төсвийн холбогдох асуудлуудаар иргэд мэдээлэлтэйгээр оролцсон байна.

Манай улсын хувьд Үндсэн хуульд шинээр туссан байгалийн баялаг ашиглахтай холбогдох зарчмуудыг хэрэгжүүлэхдээ урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлого баримтлан, өнөө болон ирээдүй үеийн эрх ашгийг хөндөхгүйгээр, байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар хариуцлагатай ашиглаж, иргэн бүрт үр шимийг тэгш, шударга хүртээх нь нэн чухал зорилт болоод байна. Салбарын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нь энэхүү зорилтыг хэрэгжүүлэх урьдач нөхцөл юм. Сүүлийн 10 гаруй жил хэрэгжиж байгаа ОУИТБС-ыг хуульчлах ажлын хүрээнд Засгийн газраас “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, холбогдох талуудын саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн боллоо. ННФ нь УУХҮЯ, ОУИТБС-ын Ажлын албатай хамтран уг хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах цуврал хэлэлцүүлэг зохион байгуулахаас гадна хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг шаардлагатай судалгаануудыг хариуцан гүйцэтгэх зэргээр хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулахад хувь нэмэр оруулж ажиллалаа. Иргэний нийгмийн байгууллагуудын олон жилийн судалгаа, мониторинг, нийтийн эрх ашгийн өмгөөлөл, нөлөөллийн үр дүнд уг хуулийн төсөлд ил тод байдлыг төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэхээс эхлээд олон улсад шинээр тавигдаж буй шаардлага болох гэрээний болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах зохицуулалтууд тусгалаа олсныг тэмдэглэхэд таатай байна.

2019 онд нээгдсэн гэрээний болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангахад ач холбогдол бүхий Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан (<http://iltodgeree.mn>)-д байршсан 1000 гаруй гэрээнээс сонгон авсан 200 гаруй гэрээ, газрын

тосны эрлийн 22 гэрээний хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд хяналт мониторинг, дүн шинжилгээ хийж холбогдох зөвлөмж гарган авлига, ашиг сонирхлын болзошгүй зөрчлийг илрүүлэн холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлээ. Уул уурхайн салбарын тоон мэдээллийг эргэлтэд оруулах, дүн шинжилгээ хийх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Уул уурхайг өгөгдлөөр урлахуй” сэдэвт цахим Хакатон зохион байгуулсан нь үр дүнгээ өгч энэ салбарын тоон мэдээллийг боловсруулах залуучуудын сонирхлыг өдөөсөн шинэлэг арга хэмжээ болов.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл сэдвийн хүрээнд бид сүүлийн жилүүдэд өрнөсөн шинэчлэлийн үйл явцыг үнэлэхэд үйл ажиллагаагаа түлхүү чиглүүллээ. Үүнд, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, өршөөлийн хуулиудын дүн шинжилгээ, нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт зэрэг сэдвээр арваад судалгаа гүйцэтгэж, үр дүнг мэргэжлийн байгууллага болон олон нийтэд хүргэлээ. Эрх зүйн шинэчлэлийн үнэлгээгээр хуульч, хууль сахиулагчдын хууль тогтоомжийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй дутмаг байгааг тодорхойлсны дүнд МХХ, ХЗДХЯ-тай хамтран шинэ эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх ажлыг эхлүүлээ. Уг сургалтыг танхимаас гадна цахимд шилжүүлэх бэлтгэлийг хангаж, хамгийн түгээмэл зөрчигдөж байгаа эрх зүйн асуудлаар цуврал видео контент бэлтгээд байна.

“Ковид–19”-ийн халдвар дотоодод тархсаны улмаас 2020 оны 11 сараас хөл хорио тогтоосонтой холбогдуулан гамшгаас сэргийлэх өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн нөхцөлд хууль сахиулах байгууллагын мөрдөх дүрэм, журмыг авч үзэх шаардлага үүсэж, энэ чиглэлээр судалгаа хийлээ. Мөн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй хөл хорионы дэглэмд хууль сахиулах ажиллагаатай холбоотой гомдол цөөнгүй гарч байгааг харгалзан цагдаагийн

албаны үйл ажиллагаанд мониторинг хийх тэтгэлгийг Монголын эмнести интернэйшнл ТББ-д олгоод байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хөөрхөн зүрхнүүд ТББ-ын үйл ажиллагааг дэмжлээ.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хүний эрхийг зохистойгоор хязгаарлах сорилт Монгол Улсыг ч тойрсонгүй. Цар тахалтай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл явцад “Хүний эрхийн форум” идэвхийлэн оролцож, хүний эрхийг хязгаарлах тодорхой шалгуур үзүүлэлтүүд холбогдох хууль тогтоомжид тусгалаа олоход чухал нөлөө үзүүллээ. Тэрчлэн ХЭҮК-ын гишүүн, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг сонгон шалгаруулах Ажлын хэсэгт тус Форумын төлөөлөл багтаж ажиллав. Үүний зэрэгцээ Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөр хэлэлцэх үйл явцыг тайлбар, орчуулгатайгаар орон даяар цахимаар дамжуулсан нь Монголын хүний эрхийн нөхцөл байдлыг төрийн байгууллагууд хэрхэн үнэлж байгааг дэлхийн бусад улс хэрхэн дүгнэж байгаатай харьцуулах боломжийг олон нийтэд олгосон жил байлаа.

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх сэдвийн хүрээнд 2020 онд шүүхийн тухай хууль тогтоомжийн шинэтгэлийг шударга ёсонд нийцүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээ, нөлөөллийн үйл ажиллагааг өргөжүүлж, шүүх эрх мэдлийн хүрээний судалгааны арга зүйг сайжруулах зорилт дэвшүүлж ажиллалаа. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгагдсан Шүүхийн тухай хуулийн төслийг олон нийтэд танилцуулах, тэдний саналыг авах, судлаач-мэргэжилтнүүдтэй хамтран санал зөвлөмж боловсруулах, иргэний нийгмийн байгууллагуудаас гаргасан санал зөвлөмжийг бодлого боловсруулагчдад хүргэх зэрэг нөлөөллийн ажлыг Оюуны Инноваци, Бодлогод залуусын хяналт



ТББ-уудтай хамтран үр нөлөөтэй хийж гүйцэтгэлээ. Уг нөлөөллийн ажлын цуврал уулзалт хэлэлцүүлэг цахим орчинд явагдсанаараа онцлогтой байв.

2017 оноос эхэлсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх санаачилгын хүрээнд нийт 15 сэдвийг хамарсан 4 эмхэтгэл хэвлэн гаргаснаас гадна 2020 онд шинээр 7 сэдвийн хүрээнд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх гэрээг судлаачидтай байгууллаа.

Тэрчлэн Засгийн газраас 2018 онд баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, тэр дундаа эрх зүйн цахим болон биет хөтчийн тогтолцоог бий болгож, үндэсний хэмжээнд нэвтрүүлэх бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлж ирлээ. ХЗДХЯ, ХЗҮХ-тэй хамтран бүтээсэн [www.e-khutuch.mn](http://www.e-khutuch.mn) цахим хөтчийн нээлт 2020 оны 1 дүгээр сард болж, түүнд нэн түрүүнд иргэнд хэрэг болох хууль зүйн анхан шатны мэдээллийг 58 сэдвийн хүрээнд боловсруулан байршууллаа.

Боловсролын хөтөлбөрийн хүрээнд бид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах эрх зүйн шинэ орчныг бэхжүүлэх, талуудын оролцоо, хамтын ажиллагаа, чадавхыг дээшлүүлэх, бодлогын хэрэгжилтийн түвшний зарим түршлагыг баримтжуулж, түгээн дэлгэрүүлэхэд гол анхаарлаа хандуулж ажиллалаа. Үүний үр дүнд иргэний нийгмийн судлаач, эцэг эхчүүд зангилаа зарим асуудлаар зөвлөмж боловсруулан бодлого боловсруулагчдад хүргэх, хэлэлцүүлэгт оролцон санал дүгнэлтээ хуваалцах зэргээр бодлогын үйл явцад идэвхтэй оролцдог болж байна. Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээний гишүүн байгууллагууд тохирох хэрэглэгдэхүүн, хүртээмжтэй сургалтын орчин, анги танхим дахь ганцаарчилсан дэмжлэг зэрэг асуудлаар БШУЯ-ны Ажлын хэсэгт орох, мөн хөндлөнгийн байр сууринаас зөвлөх, санал өгөх, агуулгын дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй

эцэг эхчүүдийн байгууллагууд тодорхой хөгжлийн бэрхшээлийн хүрээнд тэгш хамруулан сургах арга зүйг боловсруулан, ЕБС-ийн багш нарт хүргэлээ. 2020 оны хувьд иргэний нийгмийн байгууллагууд хүний эрхэд суурилсан нөлөөллийн ажлын зэрэгцээ бодлогын хэрэгжилтийг чанаржуулахад анхаарч, хамтын ажиллагаагаа өргөтгөн БСШУЯ, БМДИ, МУБИС-тэй идэвхтэй хамтран ажиллалаа.

Бид залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлогын орчныг бүрдүүлэхэд, энэ чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийг чадавхжуулахад дэмжлэг туслалцаа үзүүлж ажилладаг билээ. 2020 онд 4 их сургуулийн хөтөлбөрт үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгад төвлөрсөн 2-3 кредитийн хичээл бий болсноос гадна шинээр нэг их сургуулийн хөтөлбөрийн шинэчлэл эхэллээ. Мөн уг сэдвээр эх хэлээр гарсан эх сурвалж нэмэгдсээр байна. Тухайлбал, 3 сурах бичиг, дипломын болон магистрын түвшний судалгааны 23 ажил, эрдэм шинжилгээний 52 өгүүлэл, нийтлэл гарчээ. Мөн үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгыг судалсан их дээд сургууль, хороо, эмнэлгийн болон нийгмийн ажилтнууд төгсөж, ажил амьдрал дээр гарч байгаа нь сайн хэрэг юм.

Бидний үйл ажиллагааны ихэнх хэсэг цахимаар явагдсан нөхцөл байдалд үргэлжлүүлэн хамтран ажиллаж, үр бүтээлтэй санал зөвлөмж гарган түүнийгээ хууль эрх зүйн шинэчлэлд ажил хэрэгчээр тусгах бодитой нөлөөллийн стратеги баримталж ажилласан төрийн болон төрийн бус байгууллагууд, судлаачид, мэргэжилтнүүддээ гүн талархал илэрхийлье. Мөн манай үйл ажиллагааг сонирхон оролцож мэдлэг, түршлага, үзэл бодлоо хуваалцдаг хүмүүст талархал илэрхийлье.

Бидний үйл ажиллагаа болон тайлантай холбоотой асуулт, санал байх аваас манай байгууллагын [osf@forum.mn](mailto:osf@forum.mn) хаягаар ирүүлээрэй.



# АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

## ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Ардчилсан сайн засаглалыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд бид төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах гол хуулиудын хэрэгжилтэд анхаарч ажиллах стратеги баримталж байна. Энэ хүрээнд 2015-2016 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн төрийн шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, оролцоотой болгох процессыг хуульчилсан Захиргааны ерөнхий хууль болон Нийтийн сонсголын тухай хууль, түүнчлэн иргэний нийгмийн зүгээс нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг нээсэн Захиргааны хэрэг шүүхэд хяналт шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд голлон анхаарч ажиллаж ирлээ.

Дээрх зорилтуудтай холбоотой 2020 онд болсон нэг онцлох үйл явдал нь Хүний эрхий Үндэсний комиссын гишүүдийг анх удаа олон нийтийн оролцоотой томилгооны сонсгол зохион байгуулах замаар нээлттэй сонгон шалгаруулсан явдал байв. Цар тахлын нөхцөл байдлаас үүдэн Комиссын гишүүдийн томилгооны сонсголыг 2020 оны 6 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан ба 31 иргэн ажиглагчаар, 55 иргэн оролцогчоор бүртгүүлж, нэр дэвшигчдээс асуулт асуух эрхтэйгээр оролцжээ. ННФ-ын зүгээс Нээлттэй сонсголын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш анх удаа болсон томилгооны сонсголын үйл явцыг цаашид сайн туршлага

болж, нийтийн албан тушаалтны томилгоог улс төрөөс ангид, иргэдийн оролцоотой, тэдний эрх ашигт нийцүүлэн ил тод явуулах жишиг тогтоох ач холбогдолтойг нь үнэлэн холбогдох журмыг боловсруулах үйл явцад техникийн туслалцаа үзүүлж, зохион байгуулалтыг дэмжиж ажиллалаа.

Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологи хурдацтай хөгжих хэрээр мэдээлэл солилцох боломж, хэлбэр, хурд эрс нэмэгдэж, үүний үр дүнд төрийн ил тод байдлыг сайжруулах, улмаар авлига, ашиг сонирхлын зөрчил болон сайн засаглалд саад болох бусад сөрөг үзэгдэлтэй тэмцэхэд нээлттэй өгөгдөл зэрэг арга хэрэгслийг ашиглах боломж нэмэгдэж байна. ННФ-ын дэмжлэгтэйгээр 2019 оны 11 дүгээр сараас эхлэн олон нийтийн хүртээл болсон [www.opendatalab.mn](http://www.opendatalab.mn) нээлттэй өгөгдлийн бааз 2020 онд шинэ мэдээллээр баяжиж одоогийн байдлаар нийт 198,265 байгууллага, тэдгээрт хамааралтай 505,401 хувь хүний мэдээлэл бүртгэгдээд байна. Уг өгөгдлийн санд одоогоор дараах мэдээллүүд бүртгэгдээд байна. Үүнд:

- 2012-2019 оны хооронд мэдүүлсэн 110,626 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг
- Сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлэг
- Улсын өмчийн захиалагч 1,797 байгууллагын 15,595 тендэрт оролцсон 8,662 оролцогч байгууллагын 43,993 тендерийн мэдээлэл

- 2013-2019 оны хооронд бүртгэсэн Орон нутгийн хөгжлийн сангийн 32,315 төсөвт ажлын 61,508 санхүүжилтийн мэдээлэл
- 3,356 уул уурхайн лицензийн болон эзэмшигчдийн мэдээлэл нэг дор хайлт хийх боломжтой байдлаар тавигдаад байна.

2020 онд тус сайтад 100,000 гаруй хандалт бүртгэгдсэн ба авлигын асуудлаар шүүмжилж бичдэг нийгмийн сүлжээнд идэвхтэй зарим сэтгүүлчийн хувьд байнга ашигладаг эх үүсвэр нь болжээ. Тус өгөгдлийн санг цаашид хөгжүүлэхэд Бодлогод Залуусын Хяналт ТББ-д дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Дээр дурдсанчлан цахим технологийн хөгжил нийгэмд олон талаар ашиг тусаа өгч байгаа нь маргаангүй боловч нөгөө талаар, хувь хүний нууц буюу хувийн орон зайн халдашгүй байдлыг хамгаалах асуудлыг нэн төвөгтэй болгож байна. Сүүлийн жилүүдэд төр, хувийн хэвшлийн аль аль нь хурууны хээ гэх мэт хувь хүний өгөгдлийг цуглуулж, янз бүрийн зорилгоор ашиглаж буй боловч хэрхэн хадгалж хамгаалж байгаа нь тодорхой биш байна. Үүнтэй холбоотойгоор 2020 онд хүний хувийн мэдээлэл, халдашгүй байдлыг хэрхэн тодорхойлж хамгаалах талаар бодлогын яриа мэтгэлцээн өрнүүлж, энэ асуудлаар шаардлагатай судалгаа шинжилгээ хийлээ. Энэхүү үйл ажиллагаанд Номин энд Адвокатс ХХН, Секьюрити солюшн сервис консалтинг байгууллагуудтай хамтран ажиллаж, хувь хүний нууцын асуудлаарх өнөөгийн байдлыг судалж, үр дүн боловсруулагчид болон олон нийтэд хүргэлээ.

Дээрх судалгаанаас гадна Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах, шинээр батлагдсан хууль тогтоомжийн үр нөлөө, хэрэгжилтийг судлах, дагалдан гарсан дүрэм журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байдлыг үнэлэх, хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, бодлогын тулгамдаж буй асуудлыг тодорхойлох ерөнхий зорилгын

хүрээнд Захиргааны ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд дүн шинжилгээ хийж үр дүнг бодлого боловсруулагчид, олон нийтэд хүргэлээ. Энэхүү судалгааны ажлаар ХЗДХЯ-аас боловсруулж 2020 оны 8 дугаар сард цахим хуудсандаа нийтэлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэхээр төлөвлөж буй бусад хууль (жишээ нь ЗХШХШтХууль) -ийн үзэл баримтлал, боловсруулах үйл явц нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэх, хуулийн төслийн агуулга үзэл баримтлалтайгаа тохирч буй эсэх, ЗЕХ-ийн үндсэн зорилго, бүтэцтэй уялдаж буй эсэх, нэмэлт өөрчлөлт хийх гарцаагүй шаардлага үүссэн тухай практик болон бусад хэрэгцээ, нөхцөл бүрдсэн эсэхийг судалж, зөвлөмж боловсруулав.

Тэрчлэн 2019 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Ерөнхийлөгчийн институцид олгосон үндсэн бүрэн эрхийн хүрээнд салбарын хуулиудаар олгогдсон тодорхой эрхүүд хэрхэн нийцэж буйг ҮАБЗ-ын жишээнд үндэслэн дүн шинжилгээ хийх ажлыг бие даасан судлаачидтай хамтран гүйцэтгэлээ.

Нийтийн сонсголын тухай болон Захиргааны ерөнхий хуулиуд, 2016 онд шинэчлэн батлагдсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээг таниулах сургалтыг Увс, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгуудад зохион байгуулж төр, иргэний нийгмийн төлөөлөл 120 хүнийг хамруулав. Түүнчлэн төрийн ил тод байдал, хариуцлагатай холбоотой хуулиудын хэрэгжилтийг хангахад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжих зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн ТББ-д дэмжлэг үзүүлж хамтран ажиллав. Тухайлбал:

- Завхан аймагт Өрнөх хөгжил ТББ аймгийнхаа ИТХ-тай хамтран 2020 оны 9 дүгээр сарын 16-нд “Хэрэглэгч аймгаас үйлдвэрлэгч аймаг” жижиг дунд үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилт сэдвээр нийтийн сонсгол зохион байгуулжээ.



Төрийн хариуцлагыг сайжруулахад иргэний нийгмийн оролцооны хуульчлагдсан механизмуудыг хэрхэн үр дүнтэй сургалтын явц: Зүүн гар талаас ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

- Багануур дүүргийн Залуу манлайлал төв ТББ Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт орон нутагт ямар байдалтай байгааг тодруулах зорилгоор 2018-2020 онд ИТХ, ЗДТГ-аас гаргасан шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн талуудыг хэрхэн сонгож шийдвэр гаргах үйл явцад оролцуулсан, оролцогч талуудаас гаргасан саналыг шийдвэрт хэрхэн тусгасан болон шийдвэрийн төслийг олон нийтэд ямар арга хэлбэрээр хүргэсэн зэргийг тодруулан, цаашид ЗЕХ-ийн хэрэгжилтийг орон нутагт сайжруулахад чиглэсэн зөвлөмж гарган нөлөөллийн үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.
- Булганы мэдээ сонин аймгийнхаа ИТХ-ын үйл ажиллагааны нээлттэй байдалд мониторинг хийхэд, төлөөлөгчдийн хуралдааныг орон нутгийн телевизээр шууд дамжуулдаг ч хурлын тэмдэглэл олон нийтэд нээлттэй тавигддаггүй ба харин маш товч зөвхөн мэдээ маягаар гардаг нь ажиглагджээ. Хуралдаанаас гарч байгаа тогтоол шийдвэрүүдийн талаарх мэдээллийг зөвхөн Булган аймгийн ИТХ-ын фейсбүүк хуудаснаас үзэх боломжтой. Тэргүүлэгчдийн хуралд хэлэлцэх асуудлын

талаар бусад төлөөлөгч мэдээлэлгүй байх тохиолдол гардаг. Хурлын төсөв, төлөвлөгөө нь ил тод, мэдээлэл нь сар бүр шинэчлэгддэг сайн талтай ч хурлын даргын захирамж болон нарийн бичгийн даргын тушаал нээлттэй байдаггүйг шүүмжлэн ил тод байдлыг сайжруулах асуудлаар санал зөвлөмж гарган ажиллаж байна.

- Өмнөговь аймагт НДЭХ-ий салбар зөвлөл “Ил тод мэдээлэл” төслийн хүрээнд Даланзадгад, Цогт-цэций сумдын 120 иргэнийг оролцуулан төрийн байгууллагаас иргэд хүссэн мэдээллээ авч чаддаг эсэх, мэдээлэл авахад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох зорилгоор судалгаа хийлээ. Уг судалгаагаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуулиудын хэрэгжилт иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад хэрхэн тусаж хэрэгжиж буй талаар дүн шинжилгээ хийж байна.

ННФ-аас Нийтийн эрх ашгийн өмгөөллийг дэмжих чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны хүрээнд 2020 онд буруутай шийдвэр, эс үйлдэхүй нь нийтийн эрх ашгийг хохироосон төрийн



ашиглах асуудлаар 2020 оны 9 дүгээр сард Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай аймгуудад зохион байгуулсан Б.Хишигсайхан, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг нар.

байгууллага, албан тушаалтнуудыг хариуцагчаар татсан хэд хэдэн хэрэг нааштай шийдэгдээд байна. Тухайлбал, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ нь Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид учирсан эрүүл мэндийн хохирол, эмчилгээний зардлыг гаргуулах өмгөөлөл хийж, хохирогчдод нийт 230 орчим сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулж чаджээ. Амьд хууль ТББ-ын хууль бус шийдвэр гаргасан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх нэхэмжлэл 3 шатны шүүхээр шийдвэрлэгдэж, төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халах шийдвэр гаргасан Баянхонгор аймгийн Засаг даргад Захиргааны ерөнхий хуулийн дагуу арга хэмжээ авахыг Монгол Улсын Ерөнхий сайдад даалгах шийдвэр хүчин төгөлдөр болжээ. Түүнчлэн Амьд хууль ТББ нь төрийн өмчийн барилгыг хууль бусаар төрийн өмчлөлөөс хассан Баянхонгор аймгийн ИТХ-ын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай шийдвэрийг захиргааны хэргийн шүүхээс гаргуулаад байна.

ННФ-аас 2019-2020 онд Глоб Интернэшнл ТББ-д дэмжлэг үзүүлэн иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, нийгмийн сүлжээний зохистой хэрэглээ, зохицуулалтыг дэмжих зорилго бүхий “Хэвлэл мэдээлэл ардчиллын төлөө” төсөл хэрэгжүүлэхэд хамтарч

ажиллалаа. Энэхүү төсөл нь (i) Сэтгүүлчдийн ажил үүргээ хараат бусаар гүйцэтгэхэд нь эрх зүй, мэргэжлийн дэмжлэг үзүүлж, аюулгүй байдлыг хамгаалах, (ii) нийгмийн сүлжээнд эерэг хандлага, зан үйл хэвшүүлэхэд нөлөө үзүүлэх гэсэн хоёр зорилтын хүрээнд хэрэгжив. Цахим технологид суурилсан мэдээллийн эрин үед нийгмийн сүлжээний гүйцэтгэж буй үүрэг уламжлалт хэвлэл мэдээлэлтэй өрсөлдөх хэмжээнд хүрч үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл шуурхай авах болон түгээх нэн нөлөөтэй хэрэгсэл нэгэнт болоод буй билээ. Гэвч нөгөө талаас, нийгмийн сүлжээ нь худал мэдээлэл тараах, үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлэх зэрэг сөрөг үзэгдлийн талбар бас болж байна. Эдгээр үзэгдэлтэй зэрэгцэн төрийн зүгээс нийгмийн сүлжээг хэтрүүлэн зохицуулах оролдлого, санал санаачилгууд мөн гарч эхэллээ. Төслийн хүрээнд Глоб Интернэшнл ТББ-аас энэхүү нөхцөл байдалд иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах, ингэхдээ хувь хүний халдашгүй байдлыг хамгаалахад чиглэсэн зохистой эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийгмийн сүлжээнд ёс зүйтэй оролцох асуудлаар мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсний зэрэгцээ цахим аян болон цуврал хэлэлцүүлэг, сургалт, вебинар зэрэг арга хэмжээг зохион байгуулжээ (“Төслийн үр дүнгээс хэсгийг харна уу).

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГЭЭС

- Төсөл хэрэгжих хугацаанд нийт 42 сэтгүүлчид эрх зүйн зөвлөгөө өгч, өмгөөллийн үйлчилгээг үзүүлэв.
- Олон нийтэд өөрсдийнх нь эрх ашигт үйлчилдэг хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалахын ач холбогдлыг ойлгуулах, мөн сэтгүүлчдэд тулгарч буй саад бэрхшээлийн тухай мэдээллийг ойлгуулах зорилгоор 8 удаагийн хэвлэлийн бага хурал, дэмжлэгийн акц, цахим аян зэрэг нөлөөллийн ажлуудыг зохион байгуулав.
- Сэтгүүлчдийн мэргэжлийн үр чадварыг дэмжих зорилгоор сургалт, вэбинар зохион байгуулж нийт 181 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүл зүйн ангийн оюутнуудыг хамруулав. Мөн сэтгүүл зүйн мэргэжлийн шинжээчидтэй хамтран сэтгүүлчдийн гаргадаг нийтлэг алдаанд тулгуурлан зургаан төрлийн сэдвээр зөвлөмж боловсруулж цахимаар түгээв.
- Нийгмийн хэвлэл мэдээллийн эрх зүй болон өөрийн шилдэг туршлагын судалгаа хийн хууль тогтоогч, шийдвэр гаргагч, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн боловсролын байгууллага, мэдээлэл харилцааны зуучлагч байгууллагуудын 60 гаруй төлөөллийг оролцуулан нөлөөллийн уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар нийгмийн хэвлэл мэдээллийн төрийн бодлогын зарчмууд, тулгамдсан асуудлаар зөвлөлдөв.
- Төслийн хүрээнд "Нийгмийн хэвлэл мэдээллийг мэдлэгийн талбар болгоё!" уриатай "Эхлээд Бод!" цахим аян зохион байгуулав. Ингэснээр нийгмийн хэвлэл мэдээллийн сүвгүүдын хэрэглэгч олон нийт, нийгмийн бүлгүүд үзэл бодлоо илэрхийлэхэд тавигдах онцгой үүрэг, хариуцлага, хязгаарлалтын мөн чанар, зарчмын тухай мэдлэг ойлголттой болоход нөлөө үзүүлэв. Аяны хүрээнд зургаан Е-Санамж, 30 зурагт мэдээллийг цахимаар түгээсэн байна. Эдгээр контент нийт 13,649 хүнд хүрч 480 хандалт (*likereaction*)-ыг цуглуулжээ.

### ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ТООН ҮЗҮҮЛЭЛТЭЭР...



**10**  
сургалт,  
нөлөөлөл



**10593**  
Оролцогч  
тал



**42**  
Хууль, эрх  
зүйн зөвлөгөө



**18**  
Видео зөвлөмж,  
санамж



**8**  
Хурал,  
семинар



**38**  
Судлаач,  
мэргэжилтэн

Дээрхээс гадна Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг бэхжүүлэхтэй холбоотой Монголын олон нийтийн медиа контент ТББ-тай хамтран олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн ач холбогдол, ардчилсан

нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар богино хэмжээний цуврал видео бэлтгэх ажлыг 2020 онд эхлүүлж олон нийтийн хүртээл болгохоор ажиллаж байна.



### ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ДАГАЛДАН БОЛОВСРУУЛСАН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДЭД ӨГӨХ САНАЛ, ДҮГНЭЛТ

ХЗДХЯ-аас 2020 оны 8 дугаар сард Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох баримт бичгийн хамт танилцуулж, олон нийтийн санал авсан билээ. Уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулсан эсэх, хуулийн төсөл нь үзэл баримтлал, Захиргааны ерөнхий хуулийн үндсэн зорилго, бүтэцтэй уялдаж буй эсэх, нэмэлт, өөрчлөлт хийх гарцаагүй хэрэгцээ, шаардлага үүссэн эсэх зэргийг энэхүү судалгаагаар гаргаж ирэхийг зорьсон болно.

Судалгааны ерөнхий дүгнэлтээс дурдвал, “2020 оноос хойших хугацаанд Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлагдаагүй, түүнчлэн УИХ-аас баталсан бусад бодлогын баримт бичигт Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах талаар заагаагүй байгаа тул энэхүү хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл бүрдээгүй байна” гэжээ (дэлгэрэнгүй тайланг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ХУВЬ ХҮНИЙ НУУЦ: ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН ПРАКТИКИЙН СУДАЛГАА

Технологийн хөгжлийн тусламжтайгаар хувь хүний мэдээллийг илгээх, цуглуулах ажиллагааг алсын зайнаас, шуурхай хийх боломжтой болсон нь нэг талаас, бизнесийн үйл ажиллагаанд шинэ боломж үүсгэж байгаа ч нөгөө талаас, хувь хүний нууц мэдээлэл болон хувийн мэдээлэлд бусад этгээд халдах, алдагдах эрсдэлийг бий болгож байна. Олон улсад хувь хүний нууц мэдээллээс гадна хувийн мэдээллийг хуульд тодорхойлж, түүнийг цуглуулах, хадгалах, ашиглахтай холбоотой харилцаагаар нарийвчлан зохицуулдаг. Хувийн мэдээлэл гэх ойлголт нь хувь хүний нууц мэдээллээс ялгаатай ба тухайн хүнийг тодорхойлж болохуйц үндсэн шинж чанартай, харьцангуй өргөн цар хүрээтэй ойлголт.

Хувь хүний нэр, хаяг, регистрийн дугаар зэргийг хувийн хэвшлийн байгууллагууд өргөнөөр цуглуулж, ашигладаг. Энэхүү судалгааны хүрээнд уг цуглуулсан мэдээллийг хэрхэн ашиглаж буй талаар зарим хувийн хэвшлийн байгууллагаас санал асуулга авч шинжлэхэд хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, хамгаалах асуудалд харилцан адилгүй хандаж байв. Жишээлбэл, хэрэглэгчийн мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах тохиолдолд зарим байгууллага урьдчилан зөвшөөрөл авдаг бол зарим нь бүртгүүлэх үед энэ талаар сануулж, зөвшөөрөл авдаг тул дахин зөвшөөрөл авдаггүй гэжээ. Гэтэл манай улсад уг зөвшөөрөл ямар хэлбэрээр байхыг зохицуулсан хууль үгүй тул хэдий зөвшөөрөл авсан ч зөвшөөрч буй этгээдийн хувьд ойлгомжтой, тодорхой илэрхийлэгдсэн эсэхийг тогтоох боломжгүй байна. Иймд хувийн мэдээллийг тодорхойлж, хамгаалах журмыг хуульчилж, одоогийн хууль тогтоомжийн хүрээнд орхигдоод буй харилцааг зохицуулах нэн шаардлагатай (дэлгэрэнгүй тайланг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

## СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦ, УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

2020 оны онцлох үйл явдлын нэг нь Улсын Их Хурал (УИХ)-ын найм дахь удаагийн ээлжит сонгууль байв. Энэ удаагийн сонгууль нь Ковид-19 халдварын тархалт дэлхий нийтийг түгшээн хүн амын эрүүл мэндээс гадна нийгэм, улс төр, эдийн засагт хүчтэй нөлөөлсөн онцгой нөхцөл байдалд болж өнгөрснөөрөө онцлог байлаа.

Монгол Улсын хувьд КОВИД-19-ийн халдварын тохиолдол хамгийн цөөн бүртгэгдсэн, дотооддоо халдварласан тохиолдол болоод нас баралт хараахан бүртгэгдээгүй цөөн улсын нэг боловч БНХАУ-тай 4709 км газар нутгаар хиллэдэг, цар тахлын анхны голомтод газар зүйн хувьд хамгийн ойр буюу халдвар тархах эрсдэл тэр хэмжээгээр өндөр улсад зүй ёсоор тооцогдож байв. Ийм онцгой нөхцөлд сонгуулийн санал хураах болон бусад үйл явцыг хэрхэн эрүүл аюулгүй орчинд, маргаан зөрчлөөс ангид зохион байгуулах нь нэн тэргүүнд анхаарах асуудал болсон билээ. ННФ-ын зүгээс үүнд чиглэсэн тодорхой шийдэл, арга хэмжээ төлөвлөхөд мэдээлэл болгох үүднээс Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнтэй хамтран ажиллаж хүнд нөхцөлд парламентын сонгуулиа амжилттай явуулсан Бүгд Найрамдах Солонгос Улсын түршлагыг Монгол Улсын эрх зүйн орчинтой харьцуулан дүн шинжилгээ хийснээ 2020 оны 5 дугаар сард бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэв.

Энэ удаагийн УИХ-ын ээлжит сонгууль 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдөр болж, сонгогчдын ирц 73.4 хувьтай байсан нь Монгол Улсын хувьд Азидаа цар тахлын нөхцөлд үндэсний хэмжээний томоохон сонгууль амжилттай зохион байгуулсан хоёр дахь ардчилсан улс болсныг онцлох нь зүйтэй. Сонгуульд нийт 13 нам, 4 эвсэл, 606 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 121 нь бие даан нэр дэвшсэн нь өмнөх сонгуулиудтай

харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болов. Судлаачдын зүгээс өмнөх сонгуультай харьцуулахад бараг хоёр дахин олон бие даагч сонгуульд нэр дэвшиж өрсөлдсөн шалтгааныг улс төрийн намын төлөвшил муу, дотоод ардчилал хангалтгүй, намуудад итгэх иргэдийн итгэл суларсан байдал болон сонгуулийн санхүүжилтийн асуудалтай холбон тайлбарлаж байлаа.

ННФ-ын зүгээс улс төрийн санхүүжилт, түүний нэг бүрэлдэхүүн хэсэг болох сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахын тулд сүүлийн жилүүдэд нэлээд ажил санаачлан хэрэгжүүлж ирсэн билээ. Энэ хүрээнд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхааран гадаад, дотоодын судлаачид, иргэний нийгэм болон бусад талыг оролцуулан шүргүү ажиллалаа. Улмаар 2019 оны 12 дугаар сарын 20-нд УИХ-аас баталсан Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад чиглэсэн чамлахааргүй өөрчлөлтүүд туссан билээ. Үүнд тухайлбал, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах хүрээнд нам, нэр дэвшигчдийн санхүүжилттэй холбоотой мэдээллийг сонгуулийн өдрөөс өмнө ил болгох, зардлын тайланд тавих шаардлага болон тайланг хянахтай холбоотой Төрийн аудитын эрх үүрэг, оролцоог тодорхой болгоход чиглэсэн чухал өөрчлөлтүүд хуульд багтсан юм.

Бидний зүгээс хуульд туссан дээрх нааштай зохицуулалтын хэрэгжилтийг хангах, хяналт тавихад иргэний нийгмийн байгууллагууд, судлаачид болон төрийн холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Юуны өмнө сонгуулийн санхүүжилтэд хяналт тавихад гол үүрэгтэй Төрийн Аудитын байгууллагад нам, нэр дэвшигчдээс зардлын тайлан хүлээн авах маягтууд, дагалдах



заавар, аргачлалыг бусад улсын сайн түршлага, жишээг ашиглан боловсруулах, техникийн туслалцаа үзүүлэх ажлыг Оюуны Инноваци ТББ-тай хамтран зохион байгуулав. Түүнчлэн сонгуулийн үеэр хуулийн хэрэгжилтийг цаг тухайд нь хянаж олон нийтэд шуурхай мэдээлэл хүргэхэд Бодлогод Залуусын Хяналт ТББ-д дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Сонгуулийн санал хураах өдрөөс өмнө олон нийтэд ил болгосон нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдээллийг, нэр дэвшигчидтэй холбоотой бусад мэдээллийн хамт [www.opendatalab.mn](http://www.opendatalab.mn) цахим хуудаснаа байршуулсан ба энэ мэдээллийг түс мэдээллийн бааз дахь хуулийн этгээдийн бүртгэл, уул уурхайн лиценз, тендерийн мэдээлэлтэй харьцуулан хайлт хийх боломжтой болгосон нь шинэлэг ажил болов. Сонгогчдын хувьд өөрсдийг нь төлөөлөх парламентын гишүүддээ зохих хяналт тавьж хариуцлага шаардахын тулд ямар эх үүсвэрээс санхүүжиж буйг мэдэх эрхтэй бөгөөд энэ

удаагийн сонгуулиар анх удаа нэр дэвшигчдийн санхүүжилттэй холбоотой мэдээлэл санал хураах өдрөөс өмнө ийнхүү нийтэд ил болсон нь бүс нутагтаа сайн жишээ болохуйц чухал дэвшил боллоо. Сонгуульд мэдээлэлтэй оролцож саналаа өгөхөд сонгогчдод дэмжлэг болох үүднээс 2020 оны ээлжит сонгуулийг угтан сонгуульд өрсөлдөгч талууд, нэр дэвшигчдийн намтарт *fact checking* буюу баримт, нотолгооны магадалгаа хийж, цуврал байдлаар олон нийтэд хүргэн хяналт тавих, хариуцлага шаардах арга хэрэгсэл болгох төслийг хэрэгжүүлэхэд Ил Тод Байдал Сан ТББ-д мөн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Дээрхээс гадна сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах, сонгуулийн үр дүнд эргэлзэх аливаа хардлага, бүдлиан зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хяналт тавих, бодитой, төвийг сахисан мэдээллээр олон нийтийг хангах зорилгын хүрээнд 2007 онд ННФ-ын санаачилгаар байгуулагдсан “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт”



Санал тоолох үйл явцын ажиглалт, 2020 оын 6 сарын 24.

сүлжээний гишүүн байгууллагуудтай сонгуулийн үйл явцад хэд хэдэн чиглэлээр мониторинг, ажиглалт хийх ажлыг хамтран зохион байгуулав.

Иргэний нийгмийн зүгээс сонгуулийн үйл явцад тавих хяналт нь цогц бөгөөд өөр хоорондоо уялдсан байдаг. Тухайлбал, шударга сонгуулийн гол зарчим болох өрсөлдөөний тэгш гараа хэрхэн хангагдаж буйд хяналт тавихад Сүлжээний гишүүн Глоб Интернэшнл “Хэвлэл мэдээллийн мониторинг,” Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв “Нийгмийн сүлжээн дэх сонгуулийн сурталчилгааны мониторинг”-ийг тус тус хийж гүйцэтгэлээ. Мөн санал хураахтай холбоотой аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонгууль тэгш байх зарчим буюу нэг сонгогч-нэг санал өгөх зарчмыг хангах байдалд хяналт тавихад МИДАС ТББ “Сонгуулийн автоматжуулсан системийн мониторинг,” “Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг”-ийг хариуцан ажиллав (“Сонгуулийн

автоматжуулсан системийн ажиглалтын тайлангаас” хэсгийг харна уу).

Тэрчлэн сонгуулийн өдөр Нийслэлийн 99 хэсгийн хороо; Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Хэнтий, Төв зэрэг таван аймгийн 13 хэсгийн хороон дээр ажиллаж санал авах, тоолох, дүнг дамжуулах, хяналтын тооллого хийх хороодыг сонгох, хяналтын тооллого гүйцэтгэх үйл ажиллагаанд ажиглалт хийх ажлыг Өөрчлөлтийн төлөө эмэгтэйчүүд, Бодлогод залуусын хяналт ТББ-үүд хамтран сайн дурын 203 ажиглагчийг оролцуулан зохион байгууллаа. Тус байгууллагуудын хувьд иргэний нийгмийн ажиглагчид сонгуульд ажиглагчаар оролцох эрх нь хуулиар баталгаажсан цагаас хойш буюу 2012 оны УИХ-ын сонгуулиас эхлэн тав дахь удаагаа сонгуулийн ажиглалтыг ийнхүү зохион байгуулсан ба өнөөг хүртэл давхардсан тоогоор 700 гаруй залууст ажиглагч хийн сонгуулийн боловсролоо нэмэх бололцоог нээж өгсөн байна.



2020 оны УИХ-ын сонгуулиар 99 хэсгийн хороонд ажиглалт мониторинг хийсэн ажиглагчид, 2020 оны 6 дугаар сар.

МИДАС ТББ сонгуулийн автоматжуулсан системийн мониторингийн хүрээнд санал тоолох төхөөрөмжийн тестийг хийхдээ СЕХ-ны гэрчилгээжүүлж, хэсгийн хороодод хүргүүлэхээр бэлтгэсэн төхөөрөмжөөс санамсаргүй байдлаар сонголт хийн 20 саналын хуудас авч дараах тестүүдийг хийж үзлээ. Үүнд:

- Санал огт тэмдэглэгдээгүй хуудас уншиж байгаа эсэх;
- Нэр дэвшигч тус бүрт өгсөн саналыг бүрэн уншиж байгаа эсэх;
- Холимог байдлаар уншуулах тестлэх;
- Мандатын тооноос дутуу санал бөглөсөн хуудас тестлэх;

- Мандатын тооноос илүү санал бөглөсөн хуудас тестлэх;
- Өөр тойргийн саналын хуудас тестлэх;
- Хүчингүй болгосон (зүүн дээд, баруун доод) саналын хуудсуудыг уншиж байгаа эсэх;
- Цагийг өөрчилж “Цагийн бөмбөг” шалгахад;
- Толгой цэвэрлэх хуудас уншуулсны дараа тестлэх;
- Цахилгаан тасарсан үед аккумулятораар ажиллаж буй эсэхийг тестлэх.

Мөн мэдээлэл дамжуулах, серверийн дүн, CF картад бичигдсэн зургийн файлуудыг тулгах шалгалтуудыг хийж туршиж үзэхэд хүлээгдэж байсан үр дүнтэй нийлж тестийг бүрэн давсан болно.

Энэ удаагийн УИХ-ын ээлжит сонгуулийн хувьд КОВИД-19-ын цар тахлын улмаас олон улсын ажиглагчдын оролцох боломжгүй онцлогтой сонгууль болсонтой холбоотой сонгуульд хөндлөнгийн хяналт хийсэн олон жилийн туршлагатай, зохих аргачлалыг эзэмшсэн, олон нийтэд бие даасан байдлаараа хүлээн зөвшөөрөгдөж танигдсан дотоодын иргэний нийгмийн байгууллагуудын хяналт оролцоо өмнөх сонгуулиудаас илүү ач холбогдолтой байсныг онцлох нь зүйтэй.

Өмнөх хэд хэдэн удаагийн сонгуулиар сонгогчдыг таних гол хэрэгсэл болох био өгөгдлийн давхардал, хуурамч хаяг дээрх бүртгэл, хаяг дээр оршин суудаггүй олон хүнийг бүртгэсэн байх гэх мэт асуудлууд гарсныг янз бүрийн эх сурвалжууд мэдээлсэн. Сонгуулийн хууль тогтоомжид тусгаснаар сонгогчдын нэрийн жагсаалтын хуулбарыг нам, эвсэлд цахим хэлбэрээр олгодог ч сонгуульд хөндлөнгийн хяналт тавьж буй иргэний нийгмийн байгууллагуудад зөвхөн цаасан хувилбартай танилцах боломж олгохоор зохицуулсан байдаг. Үүнтэй холбоотойгоор иргэний нийгмийн зүгээс сонгогчдын нэрийн жагсаалтад өргөн хүрээнд хяналт тавих бололцоо хязгаарлагдмал байж ирсэн юм.

Нам, эвслүүдийн хувьд хуулиар олгогдсон боломжийг ашиглан сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавьсан удаа байхгүй. Иймд иргэний нийгмийн зүгээс нөөц бололцоогоо дайчлан тодорхой хүрээнд хяналт тавих нь зүйтэй гэж үзэн хамгийн олон сонгогчтой Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 12 хороонд байршилтай 32 сонгуулийн хэсгийн хороог түүвэрлэн мониторингод хамруулсан. Эдгээр хэсгийн хороонд бүртгэлтэй 67,820 сонгогчийн нэрсээс тодорхой аргачлалын дагуу 900 гаруй сонгогчийн бүртгэлийг түүвэрлэн авч хаягаар нь очиж тулгалт хийхэд бүртгэлтэй хаяг дээрээ янз бүрийн шалтгаанаар байгаагүй 404 нэр илэрсэн. Цаашид сонгогчдын нэрийн жагсаалтай холбоотой аливаа эргэлзээг тайлах, зөрчлөөс сэргийлэх, улмаар сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавих боломжийг бие даасан иргэний нийгмийн байгууллагуудад олгох нь чухал байгааг энэ дашрамд онцлох нь зүйтэй.

Мөн энэ удаагийн сонгуулиар анх удаа иргэний нийгмийн зүгээс нийгмийн сүлжээгээр дамжин түгээх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьлаа. Ингэснээр цаашид цар хүрээ нь улам тэлэх хандлагатай байгаа цахим сурталчилгааг хэрхэн

зөв зүйтэй зохицуулж сонгуулийн тэгш өрсөлдөөний нөхцөлийг хангаж болох талаар тодорхой зөвлөмж гарган бодлого боловсруулагчдад хүргээд байна.

Сонгууль нь тэгш өрсөлдөөний зарчмаар шударга явагдахын сацуу үзэл бодол, үнэт зүйл, бодлогын өрсөлдөөн байх ёстой талаар сүүлийн жилүүдэд нэлээд шүүмжлэл өрнөх болсон. Хэвлэл мэдээллийн мониторингийн хүрээнд энэ жил анх удаа нэр дэвшигч, нам эвсэл, бие даагчдын шууд болон шууд бус эх сурвалжаас нэвтрүүлсэн мэдээллийг агуулгын хувьд 12 ерөнхий төрөлд ангилан шинжилсэн ба сурталчилгааны агуулгыг ийнхүү шинжилж үзэх нь цаашид сонгуулийн сурталчилгааны мөн чанартай холбоотой бодлогын мэтгэлцээн өрнөхөд ач холбогдолтой гэж үзэж байна.

Хэвлэл мэдээллийн мониторингоор Глоб Интернэшнл ТББ нь МҮОНТ тэргүүтэй орон даяар нэвтрүүлгээ цацдаг таван телевизийн нийт 1813 цаг 14 минут 41 секундийн хөтөлбөрт ажиглалт хийж, үүнээс 294 цаг 32 минут 15 секундийг сонгуультай холбоотой мэдээлэлд зарцуулсныг шүүн авч нарийвчилсан аргачлалын дагуу дүн шинжилгээ хийлээ. Үүнд сонгуулийн тэгш өрсөлдөөний зарчмыг хангахтай холбоотой хуулийн заалтуудын хэрэгжилт, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, далд сурталчилгаа, редакцын хараат бус байдлыг ханган, сэтгүүл зүйн мэргэжлийн зарчим, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж байгаа байдалд үнэлгээ өгсөн байхаас гадна агуулгын хувьд дараах сэдвүүд хэрхэн хөндөгдсөнийг тооцоолж дүгнэсэн байна.



2020 оны УИХ-ын сонгуулийн санал тооллогын үйл ажиллагаа

## УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Сонгуультай холбоотой дээрх үйл ажиллагаанаас гадна улс төрийн намын тухай хуулийн шинэчлэл, түүний дотор улс төрийн санхүүжилтийг зохицуулж буй харилцааг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа шинжилгээ хийхэд ШУТИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн эрдэмтэн, багш нар хамтран ажиллав. Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал 2012 оноос хойш яригдаж, таван удаа ажлын хэсэг байгуулагдаж, хоёр ч парламент дамнан хэлэлцэгдсэн боловч өнөөг хүртэл хийгдээгүй байна. Харин 2019 оны 11 дүгээр сард УИХ-аас баталсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд улс төрийн намын ардчилсан улс төрийн системд гүйцэтгэх үүргийг тодорхой болгож, энэхүү үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангах үүднээс төрөөс санхүүжүүлэх, улмаар санхүүгийн мэдээлэл нь ил тод, үйл ажиллагаа нь хариуцлагатай байх шаардлагыг тус тус хуульчилсан. Дээр дурдсан судалгаа нь ҮХНӨ-д багтсан өөрчлөлтүүдэд нийцүүлэн хуулийг шинэчлэх ажилд хувь нэмэр оруулах зорилгоор хуульд тусгах зарим өөрчлөлтийн маргаан үүсгэж буй асуудлуудаар судалгаа хийн оновчтой шийдлүүд санал болгох зорилготой байв.

2020 оны 12 сарын байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 36 нам байна. Гэвч эдгээр намуудын ихэнхэд санхүүгийн бэрхшээл тулгардаг тул цөөн хэд нь байнгын үйл ажиллагаатай, орон нутагт шаталсан бүтэцтэй ажиллаж байна.

Судалгааны хүрээнд улс төрийн намын төлөвшилд нөлөөлөх нэг гол хүчин зүйл болох төрийн санхүүжилт, түүний хяналт, зарцуулалтын асуудлыг авч үзэж, бусад орны туршлагуудыг харьцуулж үзжээ. Судалгааны үр дүнгээс үзэхэд, төрийн санхүүжилтийг иргэд төдийлөн дэмжихгүй байгаа бол судлаачид, экспертүүд, намын ажилтнууд гэх мэт оролцогчдын дийлэнх нь дэмжиж, хүлээн зөвшөөрч байсан аж. Ингэхдээ төрөөс олгох санхүүжилтийг намын ардчилсан тогтолцоонд хүлээвэл зохих үүрэгтэй уялдуулж чиглүүлэх замаар өнөөгийн улс төрийн намуудын төлөвшилд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх саналууд нийтлэг илэрхийлэгдсэн байх аж. Тухайлбал, намын улс төрийн бодлого, хөтөлбөрөө боловсруулах, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, улс төрийн алба хаах, мэргэшсэн улс төрчдийг бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд санхүүжилтийн хувийг илүү хуваарилах нь зөв гэснийг судалгааны тайланд дурджээ.

ННФ-ын зүгээс цаашид улс төрийн намын хуулийг шинэчлэх асуудалд эрдэмтэд, иргэний нийгмийнхний идэвхтэй оролцоог ханган хэлэлцүүлэг өрнүүлж, маргаан дагуулсан асуудлаар оновчтой шийдлүүд боловсруулах, зөвшилцөл бий болгоход хувь нэмэр оруулах ажлыг шат дараалалтай зохион байгуулахаар төлөвлөж байна.



### СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН БУСАД АНХААРАЛ ТАТСАН АСУУДАЛ

Энэ удаагийн сонгуулийг томсгосон тойргууд бүхий мажоритар тогтолцоогоор зохион байгуулсан ба тогтолцооны онцлогоос шалтгаалж нийт хүчинтэй саналын 44.9 хувийг МАН авсан бол нийт хүчинтэй саналын 55.1 хувийг авсан АН нийт суудлын 24.5 хувийг авсан нь бусад намын зүгээс сонгуулийн дараа нэлээд маргаан өрнүүлж, улс төрийн зарим хүчин сонгуулийн дүнд эргэлзсэн мэдэгдэл гаргахад хүрсэн (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна үү).

### КОВИД-19 ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫН ҮЕД СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

Өмнөд Солонгос Улс Ковид-19 халдварын тархалтын үед сонгуулиа эрсдэлгүй зохион байгуулсан туршлагыг энэхүү нийтлэлд орчуулан гаргав. Адил нөхцөлд УИХ-ын ээлжит сонгуулиа зохион байгуулах гэж байгаа манай улсын хувьд энэхүү сайн туршлагаас хуваалцсан нь цар тахлын үеийн сонгуулийг эрсдэлгүй зохион байгуулах дүрэм журмыг боловсруулахад бас нэгэн эх сурвалж болсон юм (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) вэб сайтаас үзнэ үү).



### УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Энэ судалгаагаар “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын зарим заалтыг сонгож, иргэд болон бусад оролцогч талын байр суурь, хандлагыг тодруулав. Тоон судалгаагаар иргэдийн улс төрийн намын талаарх ойлголт, үнэлэмж, хандлагыг тодорхойлохыг зорьсон бол чанарын судалгаагаар хэлэлцэгдэж буй хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд оролцогчдын байр суурь, нийтлэг болон ялгаатай хандлагыг тодрууллаа (дэлгэрэнгүй тайланг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### САНАЛ АВАХ, ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТ

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд, Бодлогод залуусын хяналт ТББ-ууд хамтран уг мониторингийг хийж гүйцэтгэсэн ба нийслэлийн 9 дүүргийн 99 хэсгийн хороо болон Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Төв, Хэнтий гэсэн таван аймгийн 13 хэсгийн хороог хамруулав (дэлгэрэнгүй тайланг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### НИЙГМИЙН СҮЛЖЭЭН ДЭХ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ АЖИГЛАЛТ

Нийгмийн сүлжээн дэх сонгуулийн мониторинг анх удаа хийгдсэнээр онцлогтой байсан бөгөөд ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” байгууллагын ажилтнууд хийж гүйцэтгэлээ. Энэ удаагийн ээлжит сонгуулиар төрийн холбогдох байгууллагууд анх удаа “Фэйсбүүк” компанитай нийгмийн сүлжээн дэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр хамтран ажилласан ба Ковид-19-ийн цар тахалтай цаг үед УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд нэр дэвшигчид фэйсбүүк талбарыг маш өргөнөөр ашиглав (дэлгэрэнгүй тайланг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ АЖИГЛАЛТ

Глоб интернэшнл ТББ-аас 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр MYONT, TV9 телевиз (I суваг), MN25 суваг телевиз (I суваг), UBS (I суваг), NTV телевиз (I суваг) зэрэг 5 телевизийг хамруулан эдгээр телевизийн мэдээллийн агуулгад мониторинг хийж, үр дүнг товчлон энэхүү тайланд оруулсан болно. Ямар төрлийн мэдээлэл түлхүү нэвтрүүлж байсныг [www.forum.mn](http://www.forum.mn) вэб сайтад байрлуулсан Мониторингийн дүнгээс харна уу.



### СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

2020 оны УИХ-ын сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад МИДАС ТББ Сонгинохайрхан болон Баянзүрх дүүргийн сонгуулийн тойргуудын хил залгаа байрлалтай хороодыг сонгон авч, тухайн хороонд байгуулагдсан бүх сонгуулийн хэсгийн хороодын сонгогчдын нэрийн жагсаалтад мониторинг хийлээ. Сонгогчдын нэрийн жагсаалтаас авсан 970 сонгогчийн мэдээллийг хаягаар нь очиж нягталж үзэхэд 404 нь бүртгэлтэй хаяг дээрээ янз бүрийн шалтгаанаар байгаагүй аж (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

## ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ

Монгол Улсын төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг сүүлийн жилүүдийн төсвийн үйл явц харуулж буй. Засгийн газар жилээс жилд төсвийн алдагдлыг өсгөхөөс гадна хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт удааширч, төсвийг зүй бусаар зарцуулах зэрэг сахилгын зөрчлүүд байнга давтагдсаар байгаа нь олон нийтэд ил болсон. 2020 онд гэхэд улсын төсвийн алдагдал 2.1 их наяд төгрөг байхаар нэгдсэн төсвийг баталсан. Мөн төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, дуусаагүй барилгуудад хийсэн төрийн аудитаар олон зөрчил илэрлээ.

Манай улсын төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд төсвийн мэдээллээ ил тод болгож, иргэдийн оролцоогоо нэмэгдүүлэхийг олон улсын шинжээчид зөвлөдөг билээ. Манай улс Шилэн дансны тухай хуулийг 2015 оноос хэрэгжүүлж эхэлснээр төсвийн мэдээллийн ил тод байдал эрс дээшилсэн хэдий ч хангалттай түвшинд хүрэхгүй байгаа нь иргэний нийгмийн байгууллагуудаас тогтмол давтамжтай хийдэг ажиглалт, мониторингийн дүнгээс тодорхой харагддаг.

ННФ-аас 2015-2017 онд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд орон даяар тасралтгүй хяналт тавьж, дүнг төр засаг, олон нийтийн анхааралд оруулж ажилласан нь уг хууль хэрэгжихэд чухал түлхэц болсон гэж бид үздэг. Ийнхүү ил болсон төсвийн мэдээллийг иргэд, иргэний нийгэм ашиглан санал шүүмжээ илэрхийлж, хариуцлага нэхдэг байх нь төсвийн хөрөнгийн үр ашигтай, хариуцлагатай зарцуулалтыг нэмэгдүүлэх юм. Энэхүү үйл ажиллагааг өргөжүүлэн 2018 оноос Шилэн дансанд ил болсон төсвийн мэдээллийг нийтэд хүргэх замаар төсөвт иргэдийн хяналт, оролцоог орон даяар бүрдүүлэхийг зорьж

орон нутагт төсөл хэрэгжүүлэх ТББ-уудын үйл ажиллагааг дэмжиж эхэлснээр “Төсвийн хяналтын сонсгол”-ыг орон нутагт нэлээд зохион байгуулах болсон. Иргэдийн оролцооны шинэ механизм болох “Төсвийн хяналтын сонсгол” ийнхүү орон нутагт хөгжиж байна.

Тэрчлэн бид төсвийн мэдээллийн нээлттэй байдлыг олон улсын стандартад нийцүүлэн улам сайжруулахад нөлөөлөл үзүүлэх зорилгоор олон улсын үнэлгээн дэх Монгол Улсын судалгааг хийж ирлээ. Улс, орон нутгийн төсвийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөлт, тусгай сангуудын төсөв зэрэг тодорхой асуудлуудаар судалгаа шинжилгээ хийн үр дүнг нийтэд танилцуулж, бодлого боловсруулагчдад хүргүүллээ. Төсвийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын нэг болох төрийн аудитын байгууллагаас төсөв захирагчдын төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт зэрэгт аудит хийж, дүгнэлт зөвлөмж өгдөг боловч энэхүү зөвлөмжүүд жил бүр давтагдах хандлагатай байгаа нь ажиглагдав. Иймд аудитын зөвлөмж, түүний хэрэгжилтийн мэдээллийг нийтэд хүргэх, хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх чиглэлээрх иргэний нийгмийн үйл ажиллагааг ННФ дэмжин ажиллаж байна. Төрийн аудитын байгууллага хяналт шалгалтын үр дүнгээ цахим хуудсандаа байрлуулдаг авч ашиглаж болохуйц энгийн хялбар биш байдаг. Иймээс бид Үндэсний аудитын газартай хамтран аудитын дүнгийн мэдээллийг олон нийтэд хүргэх урсгалыг нэмэгдүүлэх, мэдээллийг энгийн ойлгомжтой болгох чиглэлээр ажиллаж байна.

Улс, орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд, иргэний нийгмийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бид 2020 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



## ТӨСВИЙН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Улсын төсөвтэй холбогдох судалгаа, шинжилгээ

Төсвийн хэлэлцүүлэгт иргэний нийгмийн идэвхтэй, үр нөлөөтэй оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсвийн холбогдох хууль, тогтоомжийг УИХ-аар хэлэлцэх явцад тэдгээрт анхаарах асуудлуудыг хөндөн, санал боловсруулан төрийн байгууллагуудад хүргүүлж, төсвийн асуудлаар хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд мэдээлэл хүргэж ажиллалаа. Түүнчлэн төсвийн дүн шинжилгээнүүд хийж түүнд тулгуурлан дээрх санал, зөвлөмжийг боловсруулахаас гадна иргэд, иргэний нийгмийнхнийг чанартай мэдээллээр хангах чиглэлд анхаарч ажиллалаа. Тухайлбал, 2020 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт болон 2021 оны төсвийн төслийг шинжлэх; улсын төсвийн хөрөнгө оруулалт, 2021 оны төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудлаар бодлогын асуудал дэвшүүлсэн нийтлэл боловсруулах ажлыг зохион байгууллаа. Мөн Нийгмийн даатгалын сангийн төсөв, удирдлагыг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийв. Цаашилбал, “2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл болон Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал боловсруулан хүргүүлэв. “Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа”-д нийтлэгдсэн Монгол Улсын дүнг нийтэд танилцууллаа.

УИХ-аар төсөв хэлэлцэх явцад зарим хөрөнгө оруулалтын төслийг нэмж оруулах явдал ажиглагддаг. Иймд 2020 онд төсвөөс санхүүжүүлэхээр УИХ-аас баталсан хөрөнгө оруулалтын төслүүдийн жагсаалтыг өргөн барьсан төсөлтэй харьцуулан судалж үзлээ. Энэхүү судалгаагаар УИХ-аас төсөв батлахдаа

хөрөнгө оруулалтын нийт 349 төсөл, арга хэмжээг шинээр нэмсэн нь ажиглагдав. Эдгээр төслийн нэлээдэд тухайн жилд олгох санхүүжилтийн дүн нийт өртгийнх нь маш бага хувьтай тэнцэж байв. Энэ нь он дамжин дуусаагүй орхигдох барилгын тоог нэмэх эрсдэл дагуулж байгаа талаар дээрх судалгаанд дүгнэжээ. Судалгааны дүнг аймаг, нийслэлийн дүүрэг тус бүрээр бэлтгэн нийтэд хүргэв (“Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгийг харна уу).

Мөн улсын төсвийн санхүүжилтээр шинээр эхлэх зарим төслийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийлээ. Энэхүү судалгаанд шинээр эхлэх нийт 900 гаруй төслийг хамруулав. Судалгаагаар 150 төслийн эхний санхүүжилт бага буюу төсөвт өртгийнх нь 30 болон түүнээс доош хувийг санхүүжүүлэхээр төлөвлөгдсөнөөс гадна зарим төслийн төсөвт өртөг ихээхэн өсөж батлагдсан нь харагдав. Мөн өндөр төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжүүд худалдан авахаар төлөвлөжээ (“Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгийг харна уу).

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлж өнөөг хүртэл дуусаагүй байгаа барилга улсын хэмжээнд олон байгаа нь Үндэсний Аудитын Газрын 2018 оны хяналт шалгалтаар тогтоогдсон. Эдгээр барилгыг дуусгах зөвлөмжийг УАГ-аас төсөв захирагчдад хүргүүлсэн байдаг. Иймээс бид Монгол Улсын 2020 оны төсөвт дээрх хяналт шалгалтаар илэрсэн дуусаагүй орхигдсон 46 барилга туссан эсэхийг судалж үзэхэд 28 нь төсөвт тусаагүй байгаа нь харагдав. Эдгээрийн дийлэнх нь БСШУС-ын болон БХБ-ын сайдын багцад байсан болно (“Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгийг харна уу).

Цаашилбал, улсын төсвийн хөрөнгө оруулалт, 2021 оны төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудлаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд анхаарах асуудал” нийтлэлийг ННФ-ын “Бодлогын асуудал” цувралынхаа 32 дугаараар олон нийтэд хүргэлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн ч он дамжин удааширч төсвийн хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй болж байгаа талаар, өнөөг хүртэл дуусаагүй энэхүү барилгуудыг дуусгах чиглэлээр ҮАГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт нь хангалтгүй байгааг үг нийтлэлээр дамжуулан нийтэд хүргэхийг зорилоо. Тухайлбал, 2021 оны төсөвт 10 жилийн өмнө эхэлсэн барилга ч туссан байсныг судлаач дүгнэн дурдсан болно. Нийтлэлийн төгсгөлд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, журмын дагуу хийж гүйцэтгэх, хөрөнгө оруулалтын төслийн мэдээллийн маягтыг сайжруулах чиглэлээрх санал, зөвлөмжийг мөн багтаав (“Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгийг харна уу).

2020 оны улсын төсөв өмнөх онд батлагдсанаас хойш эдийн засгийн нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдөж, дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас хөл хорио тогтоон хил хаасан нь эдийн засагт хүнд нөхцөл байдал үүсгэсэн. Энэхүү нөхцөл байдалтай уялдуулан улсын төсөвт тодотгол хийж, хөрөнгө оруулалтын төслүүдийг эргэн авч үзэх,

заримыг нь хойшлуулах шаардлагатай байгаа талаар иргэний нийгмийн зүгээс санал гаргасан боловч УИХ-ын сонгуулийг дуустал Засгийн газар төсөвт тодотгол хийгээгүй. 2020 оны эхний хагас жилд эдийн засаг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.7 хувиар агшиж, 1990-ээд оны шилжилтийн үеэс хойших эдийн засгийн хамгийн огцом уналт болсон. Энэ нь төсвийн орлого төлөвлөснөөс буурахаас гадна төлөвлөгдөөгүй зардлыг нэмэгдүүлсэн.

Засгийн газраас 2020 оны 8 дугаар сард төсөвт тодотгол хийсэн нь оройтсон үйлдэл болох талаар иргэний нийгмийн зүгээс санал бодлоо илэрхийлж байв. Зүй нь оны эхнээс төсөвт тодотгол хийж, нэн шаардлагагүй хөрөнгө оруулалтын төслүүдийг хойшлуулах хэрэгтэй байв. Ийнхүү төсвийн тодотголыг хэлэлцэх явцад хуульд анхаарах асуудлуудыг хөндөн, санал боловсруулан УИХ-д хүргүүлж, төсвийн асуудлаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөв. Саналд төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтийг сайжруулах, Төсвийн тухай хуульд нийцүүлэх, худалдан авах ажиллагаа хийгдээгүй байгаа барилга, байгууламжийн төслүүдийн санхүүжилтийг эргэн авч үзэх, хуульд оруулахаар санал болгосон өөрчлөлтүүд, нэмэгдсэн, хасагдсан төслүүдийн жагсаалтыг нийтэд ил тод болгох зэрэг асуудлуудыг тусгав.



Улсын төсвийн төлөвлөлтийн асуудлаар ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам *Eagle* болон *Bloomberg* телевизүүдэд ярилцлага өгч буй нь

2020 оны төсвийн тодотголоор хийгдсэн өөрчлөлтүүд болон 2021 оны төсвийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах үүднээс бид 2020 оны батлагдсан төсөв, төсвийн тодотгол, 2021 оны төсвийн төсөлд судлаачидтай хамтран дүн шинжилгээ хийв. Судалгааны дүгнэлтээс товч дурдвал, 2020 оны төсвийн төслийг 2019 онд боловсруулахдаа өнгөрсөн жилийнх нь баталсан төсвөөс нэлээд өсөлттэй байхаар баталсан ба 2020, 2021 онуудын төсвийн төсөлд орлогыг өөдрөг төсөөлсөн болохыг судлаачдын тооцоолсон төсвийн төсөөлөл ч мөн харууллаа (“Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгийг харна уу).

### Нийгмийн даатгалын сангийн судалгаа

Монгол Улсын төсвөөс Нийгмийн даатгалын сан (НДС)-д олгох татаас сүүлийн жилүүдэд өсөж байгаа, УИХ-аар Хувийн тэтгэврийн тухай хуулийг хэлэлцэж эхэлсэнтэй холбогдуулан ННФ-ын зүгээс уг сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын байдлыг судлахаас гадна Нийгмийн даатгалын тогтолцооны олон улсын түршлагыг судлах нь зүйтэй гэж үзсэн юм. 2019 онд гэхэд л нийт 605 тэрбум төгрөгийн татаасыг төсвөөс НДС-д өгчээ. Хэрэв өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоо хэвээр үргэлжилбэл тэтгэвэр авагчдын тоо нь санд шимтгэл төлөгчдийн тооноос хэтэрч НДС хөрөнгийн дутагдалд орохоор байгааг судлаачид онцолдог. Манай улсын тэтгэврийн даатгалын тогтолцоо нь хуваарилалтын зарчимд суурилсан цалинд жишсэн баталгаат тэтгэврийн тогтолцоо юм. Судалгаагаар НДС-гийн 2012-2020 оны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад дүн шинжилгээ хийн сангийн удирдлагыг боловсронгуй болгох талаар санал зөвлөмж боловсруулахыг зорьсон

### УИХ-ын сонгуульд оролцож буй нам, эвслүүдийн мөрийн хөтөлбөрийн судалгаа

УИХ-ын сонгуульд намууд өрсөлдөхдөө төсвийн тооцоо, судалгаа муутай амлалтуудыг иргэдэд өгч үр дүнд нь энэхүү амлалтаа биелүүлэхийн тулд

Төсвийн хариуцлагыг хангахад төрийн хяналтын байгууллагуудын тавих хяналт нэн чухал юм. Иймээс бид хөтөлбөрийн хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн шинэчлэлд мөн хувь нэмэр оруулахыг зорьж ажиллалаа. Үүнд, 2020 оны 3 дугаар сард УИХ-д өргөн барьсан дээрх хуулийн төсөлд санал зөвлөмж боловсруулж хүргүүлээ. Уг санал зөвлөмжид төрийн аудитын байгууллагаас хийх хяналт шалгалтын төлөвлөлт, Ерөнхий аудитор нь УИХ болон Засгийн газартай харилцах хэлбэр, төрийн аудитын хууль зүйн баталгаа, хяналт шалгалтын үр дүнд гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн тухай асуудлуудыг багтаасан болно (“Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгийг харна уу).

болно. Судалгааны гол үр дүнгээс товч дурдвал, НДС-гийн орлогын хамгийн том хэсгийг шимтгэлийн орлого бүрдүүлдэг бол зарлагын хамгийн их жинг тэтгэврийн даатгалын сангийн зарлага, тэр дундаа өндөр насны тэтгэвэр эзэлж байна. Олон улсын түршлагаас харахад, баталгаат тэтгэврийн тогтолцооноос гадна хуримтлалын тогтолцоо эрчтэй хөгжиж, НДС-гийн хөрөнгийн удирдлагыг хамтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, даатгалын компани зэрэг мэргэжлийн санхүүгийн байгууллагууд хариуцаж байна. Судалгааны хүрээнд манай улс нийгмийн даатгалын тогтолцоогоо нэн даруй олон давхаргат тогтолцоонд шилжүүлэхийг зөвлөмж болгов. Энэхүү судалгаа нь нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмэр оруулна хэмээн үзэж буй (“Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгийг харна уу).

төсвийн зохистой удирдлагад сөргөөр нөлөөлөх шийдвэрүүдийг гаргаж байгаа нь нууц биш юм. Иймээс ННФ 2020 оны УИХ-ын сонгуульд оролцож

буй УИХ-д суудалтай 2 нам, 4 эвслийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт нь төсвийн тогтвортой байдалд нийцэж буй эсэх, мөрийн хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээ нь хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэж буй эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорилоо. Нам, эвслийн хөтөлбөрүүдэд багтсан зорилт, арга хэмжээнүүд нь хэрэгжих хугацаа, үр дүнгийн шалгуур үзүүлэлт

## Төсвийн нээлттэй байдлын судалгаа

АНУ-д төвтэй Олон улсын төсвийн түншлэл ([www.internationalbudget.org](http://www.internationalbudget.org)) байгууллагаас санхүүжүүлж, зохион байгуулдаг “Төсвийн нээлттэй байдал” судалгааг ННФ-ын судлаачид хоёр жил тутамд хийж, үр дүнг бодлого боловсруулагчид, олон нийтийн анхааралд оруулж ажилласаар ирлээ. Энэхүү судалгааг бид улсын төсвийн нээлттэй байдал, төсвийн үйл явцад иргэд оролцох боломж, төрийн хяналтын институциудын зүгээс төсөвт тавих хяналтыг сайжруулахад нөлөөлөх зорилгоор хийдэг билээ. Сангийн яамнаас 2018 оноос хойш жил бүр ирэх оны төсвийн төсөл, батлагдсан төсвийн иргэнд зориулсан хялбаршуулсан хувилбарыг гаргаж байгаа нь ахиц дэвшил юм. Бид 2019 оны ээлжит судалгааны дүнг 2020 оны 8 дугаар сард олон нийтэд танилцууллаа.

Төсвийн нээлттэй байдлын 2019 оны судалгааны дүнгээс харахад манай улсын төсвийн ил тод байдалд ахиц гарч нийт авбал зохих 100 онооноос 56 оноо авчээ. Энэ нь өмнөх судалгаанаас 10 оноогоор дээгүүр үзүүлэлт юм. Уг судалгаа нь Засгийн газрын төсвийн нээлттэй байдлын түвшнийг дэлхийн 100 гаруй оронтой харьцуулах, иргэний нийгмийн зүгээс улсын төсвийн ил тод байдлыг нотлох баримтад үндэслэн шаардах боломжийг олгодог. Тэрчлэн Олон

буюу тоо хэмжээ тодорхой заагдаагүй байгаагаас тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нарийвчлан тооцоолоход бэрхшээл учирсан тул судалгааны дүн бүрэн гарах боломжгүй болсон юм. Хэдий тийм боловч энэхүү оролдлого нь сонгуулийн мөрийн хөтөлбөрт тавих шаардлагыг эргэн авч үзэх шаардлагатай байгааг харуулав.

улсын төсвийн түншлэл байгууллагаас уг судалгааны дүнг дэлхий даяар танилцуулснаар төр засгийн зүгээс төсвийн ил тод байдлын асуудалд анхаарал хандуулах шалтгаан болдгоороо давуу талтай.

Сангийн яамнаас төсвийн эмхэтгэлийг хэвлэмэл хэлбэрээр түгээхээс гадна цахимаар танилцах боломжийг бүрдүүлэх, олон улсад баримталдаг зарчим, стандартуудыг нэвтрүүлж, хэвшүүлэхээр ажиллаж байгаа нь сайшаалтай. Дээрх судалгаагаар төсвийн ил тод байдлаас гадна мөн төсөв дэх иргэдийн оролцоо, УИХ, төрийн аудитын байгууллагын зүгээс тавьж буй хяналтыг олон улсын стандартын дагуу үнэлж, тухайн чиглэлийн асуудлыг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гаргадгаараа ач холбогдолтой (“Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгааны хүрээнд гаргасан зөвлөмж”-өөс хэсгийг харна уу). Манай улс төсвийн үйл явц дахь иргэдийн оролцооны үзүүлэлтээр дөнгөж 15 оноо авсан нь энэ чиглэлээр цаашид ажиллах шаардлагатайг харууллаа. Энэ үеэр бид Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас зохион байгуулсан цахим уулзалтуудад оролцон Сангийн яамны төлөөлөлд анхаарах асуудлуудын талаар саналаа илэрхийлж ажиллалаа.

### ТӨСӨВТ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ЗӨВЛӨМЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД: Олон нийтийн, эсвэл иргэний нийгмийн байгууллагын аливаа төлөөлөгч төсөв батлагдахаас өмнөх хэлэлцүүлгийн үеэр болон аудитын тайлангийн хэлэлцүүлгийн үеэр сонголд оролцож мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх.



САНГИЙН ЯАМАНД: Төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлж эхлэх. Эмзэг болон төлөөлөл багатай бүлгийг шүүд, эсвэл тэдгээрийг төлөөлдөг иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан төсвийн хэлэлцүүлэгт идэвхтэй татан оролцуулах.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ: Холбогдох аудитын шалгалт хийх үйл явцад олон нийт хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бий болгох.

### ТӨСВИЙН ХЯНАЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ЗӨВЛӨМЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД: Хууль тогтоох байгууллагын байнгын хорооноос төсвийн гүйцэтгэлийн жилийн явцын тайланг хэлэлцэж, гарсан дүгнэлтийг цахимаар нийтэлж байх. Төсвийн жилийн дундуур төсвийн хөрөнгийн хуваарилалтыг захиргааны нэгжүүдийн хооронд шилжүүлэх тохиолдолд хууль тогтоох байгууллагатай зайлшгүй зөвшилцдөг байх.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ: Аудит хийх үйл явцыг хөндлөнгийн байгууллагаар нягтлуулах.

## ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Төсвийн зарцуулалтын чиглэлээр хийсэн үйл ажиллагаа

Шилэн дансны тухай хууль хэрэгжсэнээр төсвийн мэдээллийн ил тод байдал тодорхой хэмжээнд сайжраад байгаа билээ. Ийнхүү ил болсон төсвийн мэдээллийг иргэд ашиглан төсвийн хариуцлагыг нэхэх нь чухал юм. Иймд төсвийн зарлага, худалдан авалтын ил болсон мэдээллийг ашиглан иргэний нийгмийнхний хариуцлага нэхэх үйл ажиллагааг өргөтгөх, нутгийн иргэдтэй хамтрах үйл ажиллагааг

дэмжихээр 10 гаруй аймаг, нийслэлийн нийт 19 байгууллагын төслийг дэмжиж ажиллав (хэрэгжүүлсэн төслийн жагсаалтыг дэлгэрүүлж харна уу). Эдгээр төслийн хүрээнд ТББ-уудын хийсэн мониторингийн үр дүнг олон нийтэд болон холбогдох нутгийн захиргааны байгууллагуудад хүргэж ажиллах нь чухал үр дүнтэй байдаг.

2020 онд төсвийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх чиглэлээр 11 аймаг,  
нийслэлд ажилласан төрийн бус байгууллагууд

№	Аймаг/хот	Байгууллагын нэр	Төслийн нэр
1	Архангай	Даацтай хөгжлийн ирээдүй ТББ	Орон нутгийн хөгжлийн сан-Иргэдийн төсөв
2	Булган	Булганы өнгө ТББ	Булган аймгийн төсөв, тусгай сангийн зарцуулалтын харьцуулалтын байдлыг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь
3	Булган	ЛЭОСангийн Булган аймаг дахь салбар зөвлөл	Булган сумын 2019 оны ОНХС-ийн Төсвийн хяналтын сонсгол
4	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн Иргэний нийгмийн нэгдсэн зөвлөл	"Орон нутгийн төсөвт иргэд, ИНБ-ын оролцоо, хяналт" төсөл
5	Дархан-Уул	МҮХАҮТ-ын Дархан-Уул аймаг дахь салбар танхим	Дархан-Уул аймгийн Сүм хөгжүүлэх сангийн 2019 оны төсвийн хэрэгжилт, үр дүнд мониторинг хийх
6	Дорнод	Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ	"Дорнод аймгийн төсвийн сангуудын зарцуулалт" мониторингийн төсөл
7	Дорнод	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо ТББ	"Шилэн дансны мэдээллийг иргэдэд хүргэх нь" мониторингийн төсөл
8	Орхон	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл ТББ	Төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн худалдан авалт, ажил үйлчилгээ, аймагт хэрэгжиж буй ЗГ-ын Тусгай сангуудын зарцуулалтад мониторинг хийх нь
9	Өвөрхангай	ЛЭОСангийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл	"Иргэдийн оролцоотой төсвийн хяналт" төсөл
10	Өвөрхангай	Эх нутаг хөгжил төв ТББ	Сүм хөгжүүлэх сангийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх нь
11	Өвөрхангай	Түмний түчээ ТББ	Хариуцлагатай тендер
12	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	"Орон нутгийн төлөөллийн байгууллагын төсвийн хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой чадавхжуулах нь"
13	Төв	Энэрэнгүй хүсэл ТББ	Шилэн данс ашиглаж төсвийн зарцуулалтад хяналт тавих, мэдээлэл түгээх "Нээлттэй төсөв-Иргэдийн оролцоо" төсөл
14	Ховд	Жавхлант гэрэлт ирээдүй ТББ	Ховд аймагт 2020 онд хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын үр дүнг сайжруулахад нутгийн иргэдтэй хамтран нөлөөллийн ажил хийх
15	Увс	Баруун бус нутгийн хөгжлийг дэмжих "Сайнтус" төв ТББ	Увс аймгийн БХС-ийн сүүлийн 5 жилийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, худалдан авалтад хийх мониторинг
16	УБ	Зургаан буудлын оршин суугчдын эрх ашгийг хамгаалах холбоо ТББ	Төсвийн хариуцлага нэхэх, төсвийн хяналтын сонсгол
17	УБ	ЛЭОС-ийн Багануур дүүргийн салбар зөвлөл	Төсөвт иргэдийн хяналт
18	УБ	Залуус манлайлал төв ТББ	"ХЭДС-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийн хяналт мониторинг
19	УБ	Тэгш хүртээмж бие даан амьдрах төв ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байр бий болгох төсөлд мониторинг хийх

Шилэн дансанд нийтлэгдсэн зарлага, худалдан авалтын мэдээлэл, уг мэдээлэл болон орон нутгийн төсөвт шинжилгээ хийсэн зарим дүгнэлт, түсгай сангуудын зарцуулалтын мэдээллийг нийтэд хүргэлээ. Мөн ИТХ-тай хамтран төсвийн сонсгол зохион байгуулан иргэдийг өргөнөөр оролцуулах чиглэлээр төслийн дэмжлэг авсан ТББ-ууд цөөнгүй үйл ажиллагаа хэрэгжүүлж, тодорхой түвшинд нааштай үр дүнгүүд гарав (Дэлгэрэнгүй мэдээллийг “Мониторингийн төслийн хүрээнд зохион байгуулагдсан үйл ажиллагаа” сэдвээс харна уу). Тухайлбал, Архангай аймгийн “Даацтай хөгжлийн ирээдүй” ТББ-аас аймгийн 19 сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалтад шинжилгээ, мониторинг хийж, үр дүнг нийтэд хүргэн орон нутгийн төсвийн зарцуулалтын талаарх иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллалаа.

Цаашилбал “Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн” ТББ-аас Дорнод аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан (ЖДҮХС), Байгаль орчны сан (БОС)-гийн төсвийн зарцуулалтад мониторинг, дүн шинжилгээ хийн зарим төсөлтэй газар дээр нь танилцлаа. Мониторингоор ажиглагдсан зарим анхаарах асуудлаас дурдвал, ЖДҮХС-гийн төслийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй, тайлан мэдээлэл ойлгомжтой бус, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зүгээс ЖДҮХС-гийн төсөлд сонгон шалгарсан иргэн, ААН-тэй гэрээ байгуулдаг боловч хяналтыг хэрэгжүүлдэггүй байна. ЖДҮХС, Сум хөгжүүлэх сан (СХС)-гаас олгох төслийн талаарх мэдээлэл иргэдэд ил тод нээлттэй бус, хэзээ хэрхэн хаана зарлагдах нь тодорхой биш байдаг аж. Мониторингийн дүгнэлт, зөвлөмжүүдээс дурдвал, Сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайланг нийтэд болон багийн ИНХ-д танилцуулж хэвших, БОС-гийн төсөв зарцуулалт, тендер шалгаруулалтад тавих хяналтыг дээшлүүлэх, СХС-гийн журам болон ЖДҮХС-гаас зээл олгох төсөл сонгон шалгаруулах

журамд зээл авагч зээлээ зориулалтын дагуу зарцуулаагүй тохиолдолд хүлээх хариуцлагыг боловсронгуй болгох шаардлагатай гэжээ.

Мөн Баруун бүс нутгийн хөгжлийг дэмжих “Сайн тус” төв ТББ-аас Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, худалдан авалтад мониторинг хийн дүгнэлт, зөвлөмжөө аймгийн ИТХ, аймгийн болон 19 сумын засаг дарга, аймгийн БОАЖГ-т хүргүүлснээс гадна үр дүнг иргэдэд танилцуулжээ. Төслийн хүрээнд төр болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн амжилттай хамтран ажилласан байна. Цаашилбал, Өвөрхангай аймгийн зарим сумын 2019, 2020 оны ОНХС-гийн төсвийн хяналтын сонсголүүдыг сумдын ИТХ, ЛЭОС-ийн Өвөрхангай аймаг дахь салбар хамтран зохион байгуулсан бол Багануур дүүргийн ИТХ, Багануур залуус манлайлал төв ТББ хамтран Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн зарцуулалтаар төсвийн хяналтын сонсгол хийж, төсвийн сонсголыг тогтмолжуулахад хувь нэмэр орууллаа.

Төсвийн зарцуулалтын мониторингоос гадна эрүүл мэндийн байгууллагуудын төсөвт мөн мониторинг хийлээ. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авалтын мэдээллийг жилийн туршид нийтэд хүргэх ажлыг Захиргааны Шинэ Санаачилга ТББ хийж гүйцэтгэлээ. Энэхүү мониторинг нь 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн эрүүл мэндийн төв; нэг, хоёрдугаар шатлалын эмнэлгүүдийн худалдан авалтын мэдээллийг хамарч ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийгдсэн юм. Эдгээр байгууллагын худалдан авалтын мэдээллийг тус байгууллага 2020 онд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэлээ. Төслийн дүнд аймгуудын нэгдсэн эмнэлгийн худалдан авалтын мэдээллийн ил тод байдал дээшилснээс гадна анхаарах асуудлуудыг Үндэсний аудитын газарт хүргүүлэв. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөлд мэдээлэл хүргэх уулзалтыг зохион байгуулж, тогтмол мэдээлэл түгээж ажиллав.

МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН  
БАЙГУУЛАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СОНСГОЛ

Өвөрхангай аймгийн Төгрөг, Сант, Богд сумдын 2019, 2020 оны ОНХС-гийн төсвийн хяналтын сонсголыг сумдын ИТХ, ЛЭОС-гийн салбар хамтран 2020 оны 9 дүгээр сард зохион байгуулав.

Төгрөг суманд



Богд суманд



Сант суманд




Багануур дүүргийн ИТХ, Багануур залуус манлайлал төв ТББ хамтран Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн зарцуулалтаар төсвийн хяналтын сонсголыг 2020 оны 10 дугаар сард хийв.

Багануур





ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН МЭДЭЭЛЭЛ



Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авалтын чиглэлээр Захиргааны Шинэ Санаачилга ТББ-аас нийтэд хүргэсэн мэдээллээс

“Үнэн хатамж” ТББ-ын гүйцэтгэх захирал Ж.Сайнзаяа ХМХ-ээр мониторингийн дүнгээ танилцуулж буй нь

ТӨРИЙН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР



Төрийн аудитын байгууллагын зүгээс хийсэн хяналт, шалгалтын дүнд төсвийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр төсөв захирагчдад өгсөн Зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийх төслийг хэрэгжүүлж буй Үнэн хатамж ТББ-ын үйл ажиллагааг бид үргэлжлүүлэн дэмжиж ажиллалаа. Тус төрийн бус байгууллага аудитын албан шаардлага, Зөвлөмжийн биелэлтийн мэдээлэлд дүгнэлт хийн иргэний нийгэм, иргэд, бодлого боловсруулагчдад <http://www.sainaudit.mn> цахим хуудас

болон нийгмийн сүлжээ ([twitter.com/SainAudit](https://twitter.com/SainAudit)), хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл өгч ажиллалаа. Мөн “Үнэн хатамж” ТББ төсвийн асуудлаар тогтмол идэвхтэй ажиллаж, төсвийн анхаарал татсан асуудлуудыг хөндсөн мэдээллүүдийг бэлтгэн нийтэд хүргэв.



Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээллийн <http://www.sainaudit.mn> цахим хуудас, <https://twitter.com/SainAudit> хуудсыг “Үнэн хатамж” ТББ-аас эрхлэн ажиллуулж байна.

## СЭДВИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН




### МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДААГҮЙ БОЛОВЧ УЛСЫН ИХ ХУРЛААС НЭМЖ БАТАЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

2020 оны төсвийн төсөлд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын зарим төслийг УИХ-аар төсөв хэлэлцэх явцад нэмж оруулсан байдлыг өргөн барьсан төсөлтэй нь харьцуулж энэхүү багц инфографикаар харуулав (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).

### МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЖАГСААЛТАД БАГТААГҮЙ ДУУСААГҮЙ БАРИЛГУУД

Үндэсний Аудитын Газрын 2018 оны хяналт шалгалтаар төсвийн хөрөнгө оруулалттай олон барилга өнөөг хүртэл дуусаагүй байгаа нь тогтоогдсон. Эдгээр барилга 2020 оны улсын төсөвт туссан эсэхийг судалж энэхүү багц инфографикт харуулав (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).



### 2020 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ШИНЭ ТӨСЛҮҮД

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр эхлэх нийт 919 төслийг уг судалгаанд хамруулж тэдгээрийн эхний санхүүжилт нь хэдэн хувиар улсын төсөвт тусгагдсаныг тодруулахад 150 төслийн эхний санхүүжилт төсөвт өртгийнх нь 30 болон түүнээс доош хувиар тусгагдсан байв (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).



## ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨД АНХААРАХ АСУУДАЛ

2021 оны төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудлыг “Бодлогын асуудал”-ын энэхүү дугаарт хэвлэн нийтэлсэн ба төсвийн хөрөнгөөр эхлүүлсэн ч он дамжин удааширч, төсвийн зарцуулалт үр ашиггүй болж байгаа шалтгаан, эдгээр ажлыг дуусгах чиглэлээр УАГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт ямар байгаа зэргийг энэхүү нийтлэлд оруулав (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).



## 2020 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОДОТГОЛ, 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны гол дүгнэлтээс дурдвал, 2019 онд 2020 оны төсвийн төслийг өмнөх жилийн баталсан төсвөөс нэлээд өсөлттэй байхаар баталснаас гадна 2020, 2021 оны төсөлд төсвийн орлогыг өөдрөгөөр төсөөлсөн болохыг судлаачдын тооцоолол харуулав (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ: САНГИЙН УДИРДЛАГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААРХ САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгаагаар Нийгмийн даатгалын сангийн 2012-2020 оны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад дүн шинжилгээ хийн сангийн удирдлагыг боловсронгуй болгох талаар санал зөвлөмж боловсруулав (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).



## ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СУДАЛГАА-2019

Энэхүү судалгаа хоёр жил тутамд хийгддэг бөгөөд 2019 оны судалгаанд манай улс авбал зохих 100 онооноос 56 оноо авчээ. Энэ үзүүлэлт өмнөх судалгааны дүнгээс 10 оноогоор дээгүүр үзүүлэлт юм. Уг судалгаа нь Засгийн газрын төсвийн нээлттэй байдлын түвшнийг дэлхийн 100 гаруй оронтой харьцуулах, иргэний нийгмийн зүгээс улсын төсвийн ил тод байдлыг нотлох баримтад үндэслэн шаардах боломжийг олгодог (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).



## МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС

Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийг бодитой тооцоолж тусгаагүйгээс Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг батлахдаа өмнө баталсан төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилжээ. 2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ баталснаас 5 сар гаруйн дараа Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувиас бусад бүх үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан байв (дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).


# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ НЬ

Улиран одогч 2020 он нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хувьд дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед улс оронд тулгарсан эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулахын тулд тасралтгүй, бүр магадгүй улам шаргуу ажиллах хариуцлагатай цаг үе байлаа. Оны эхний хагаст манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бараг 40 орчим хувиар, ДНБ 9.7 хувь буурсан нь хөл хорионоос хамааран Гашуунсүхайтын боомтоор гарах нүүрс, зэсийн баяжмалын тээвэр эрс цөөрсөнтэй холбоотой байв. Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч хорио цээрийн үед уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг шуурхай бөгөөд аюулгүй зохион байгуулах “Ногоон гарц” түр журмыг Хятад Улстай хамтран хэрэгжүүлж чадсанаар 10 дугаар сар гэхэд экспорт дахин нэмэгдэж өмнөх оны хэмжээнд хүртэл өсжээ. Харин 11 дүгээр сард дотоодод тархсан цар тахлын халдвараас үүдэн “Ногоон гарц” түр журам цуцлагдаж, хилээр гарах машины тоо дахин буурсан нь цаашид уурхайн бүтээгдэхүүний экспортыг дэмжих дэд бүтцээ сайжруулах шаардлагатайг бидэнд ахин нэг санууллаа. Улсын төсвийн орлогын томоохон хувийг бүрдүүлэгч, Улаанбаатар хот, 21 аймгийг түлш, эрчим хүчээр хангахад голлох үүрэгтэй энэ салбарын хувьд 11 сараас эхэлсэн хатуу хөл хорионы үед ч халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан зогсолтгүй ажилласаар шинэ онтой залгалаа.

Нөгөөтэйгүүр, өнгөрсөн онд эрдэс баялгийн салбарын цаашдын бодлого, хөгжилд нөлөөлөх олон үйл явдлууд өрнөв. 2020 оны УИХ-ын сонгуулийг угтсан элдэв амлалт, гэнэтийн шийдвэрүүд энэ салбарыг тойрсонгүй. Хариуцлага нэрийн дор түсгэй зөвшөөрлүүдийг олноор нь үндэслэлгүйгээр цуцалж, ашиглаж эхлээгүй Салхитын мөнгөний ордоос ирээдүйд бий болох эсэх нь ч тодорхойгүй орлогыг барьцаалж 700 гаруй тэрбум төгрөгөөр

ахмадуудын тэтгэврийн зээлийг тэглэв. Энэхүү үйл явдал нь энэ салбарт хариуцлага, хууль ёсыг чангатгах, нөгөө талаас нийтийн өмчийн байгалийн баялгийг улс төрийн ашиг сонирхол, эрх мэдэл, байр сууриа хамгаалахад зориулж дураараа, үр ашиггүй зарцуулах боломжийг хаах шаардлага тулгамдсаныг тодхон харууллаа.

Үүнээс үүдэн, 2020 оны сонгуулийн дүнд байгуулагдсан шинэ Засгийн газрын нэн тэргүүний үүрэг, бас сорилт нь Үндсэн хуульд шинээр туссан зарчмуудыг хэрэгжүүлж, урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогод тулгуурлан өнөө болон ирээдүй үеийн эрх ашгийг хөндөхгүйгээр байгалийн баялгийг



[www.miningwatch.mn](http://www.miningwatch.mn) уул уурхайн зөрчил, мэдээллийн цахим бүртгэл: Иргэд энэхүү цахим хуудсаар дамжуулан орон нутагтаа явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан зөрчлийг холбогдох байгууллагуудад мэдээлэх боломжтой юм.

хариуцлагатай, байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар ашиглаж, иргэн бүрт үр шимийг нь тэгш, шударга хүртээхэд чиглэх явдал болж байна. Тэрчлэн тусгай зөвшөөрөл олголтыг нээлттэй, ил тод болгох; геологи хайгуулд хөрөнгө оруулалт татан эрчимжүүлэх; боловсруулах, баяжуулах үйлдвэрийг хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зэрэг нь түлгэмдсэн асуудал хэвээр байна. Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж, олон жил маргаан дагуулсан Оюу толгойн төслөөс хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх яриа хэлэлцээрийг амжилттай шийдвэрлэж чадах эсэх нь энэ салбарын цаашдын ирээдүйд гол нөлөөг үзүүлнэ.

ННФ-ын Эрдэс баялгийн салбарын хөтөлбөрийн хувьд ч өнгөрөгч 2020 он өмнөх стратегийн хэрэгжилт, үр дүнг баталгаажуулахын сацуу 2021-2024 онд стратегийн шинэ зорилгоо хэрэгжүүлэх үндэс суурийг тавих чухал цаг үе болж байв.

2017-2020 онд хэрэгжүүлсэн стратегийн хүрээнд эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг

гүнзгийрүүлэх, энэ чиглэлийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ямар нэг ухралт гарахаас сэргийлэхэд онцгойлон анхаарал хандуулж ирсэн билээ. Цаашдаа төрийн үйл ажиллагааны шударга, хариуцлагатай байдлыг хангахад илүүтэй анхаарч, нийтийн өмчийн байгалийн баялгийн зарцуулалтад авлига, ашиг сонирхлын зөрчил, үр ашиггүй байдлыг арилгахад илүүтэй төвлөрч ажиллах зорилго тавьж байна.

Иймээс 2020 онд гэрээ, эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хуульчлан баталгаажуулах, судалгаа шинжилгээ, хэлэлцүүлэг нөлөөлөл, нийтийн эрх ашгийн өмгөөллөөр дамжуулан хариуцлагыг нэмэгдүүлэх, шударга ёсыг шаардан нэхэмжлэх иргэний нийгмийн суурь бүтцийг бэхжүүлэхийг зорьж ирлээ. Тэрчлэн Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх, ил тод байдлаар дамжуулан олон нийтийн хяналтыг бий болгож, хариуцлагыг бэхжүүлэх, авлигаас сэргийлэх хяналтын тогтолцоог сайжруулах, орон нутагт хууль, хүний эрхийн зөрчлийг бууруулах зэрэг стратегийн шинэ зорилтуудаа хэрэгжүүлэх суурь үндсийг тавихыг эрмэлзэж ажиллалаа.



Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд иргэний нийгмийн санал шүүмж авах хэлэлцүүлэг. 2020 оны 10 сарын 28-ны өдөр

## ИЛ ТОД БАЙДЛЫГ ГҮНЗГИЙРҮҮЛЭХ: ОУИТБС-ЫГ ХУУЛЬЧЛАХ, ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ, ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН БҮРТГЭЛ

Сүүлийн жилүүдэд тогтонги байдалд ороод байгаа ил тод тайлагналыг эрчимжүүлэх, ялангуяа төрийн байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлэхэд Монгол Улсад 2006 оноос эхлэн хэрэгжиж байгаа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг хуульчлах явдал чухал юм. Иймд “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төсөл боловсруулах үйл явцад идэвхийлэн оролцлоо. УИХ-ын сонгуулийн дараа Засгийн газар өөрчлөн байгуулагдсанаар хуулийн төслийн Үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, холбогдох талуудын саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна. Ийнхүү хуулийн төсөл боловсруулах ажилд идэвхтэй оролцсоноор ил тод байдлыг төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэн хэрэгжүүлэх зэрэг олон улсад шинээр тавигдаж байгаа шаардлагыг хэрэгжүүлэх, гэрээ болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах зохицуулалтыг хуулийн төсөлд түсгүүлаад байна.

Энэ хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), ОУИТБС-ын Ажлын албатай хамтран хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа. Мөн Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, Зардлын тооцоо зэрэг шаардлагатай судалгаануудыг хариуцан хийж, УУХҮЯ-нд хүлээлгэн өгөөд байна.

Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг гүнзгийрүүлэх чиглэлээр хийж ирсэн нэг гол ажил бол энэ салбарт байгуулагдсан гэрээнүүдийг нийтэд ил тод болгох явдал юм. 2019 онд нээлтээ хийсэн Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг (<http://iltodgerее.mn>) энэ онд улам баяжуулснаар нийт 1000 гаруй гэрээ байршлаа. Төрийн өмчит компаниудын худалдан авалтын гэрээг ил тод болгох нь авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулахад

онцгой ач холбогдолтой. Тиймээс төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагаанд ил тод байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчин, хэрэгжилтийг үнэлэх судалгааны ажлыг эхлүүлээд байна. Мөн гэрээний мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах, гэрээнд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг бэхжүүлэх зорилгоор мониторинг, судалгааны төсөл зарлаж, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ (ОНХАГ) болон Газрын тосны Эрлийн гэрээний чиглэлээр судалгаа хийлээ.

ОНХАГ-ний судалгаагаар гэрээний мэдээллийн санд байршсан 200 гаруй гэрээнд дүн шинжилгээ хийн эрх зүйн орчин, гэрээний хэрэгжилт, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг боловсрууллаа. Тэрчлэн дээр дурдсан Газрын тосны эрлийн гэрээний дүн шинжилгээгээр мэдээллийн санд байршсан 22 гэрээг хамран судалж, авлига, ашиг сонирхлын зөрчил бодитой байгааг илрүүлэн гэрээний зохицуулалт, хяналтыг сайжруулахтай холбоотой дүгнэлт, зөвлөмж гаргалаа. Цаашид дээрх судалгааны дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд танилцуулах хэлэлцүүлэг өрнөх болно.

Орон нутгийн хөгжилд өгөөжтэй, хамгийн гол нь хэрэгжих боломжтой “сайн” гэрээ байгуулахад орон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллага, иргэний нийгмийн чадавхыг дээшлүүлэх нь юу юунаас чухал. Үүнд хувь нэмэр оруулах зорилгоор “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ: Бэлтгэх, хэлэлцэн тохирох, хэрэгжилтийг хангах нь” цахим гарын авлагыг боловсруулан гаргаж нийтийн хүртээл болголоо.

Мөн 12 сард зохион байгуулсан уул уурхайн тоон мэдээллийг ашиглах цахим уралдаанд оролцсон 10 баг гэрээний мэдээллийн санг ашиглан дүн шинжилгээ хийснээс 5 бүтээл нь тэмцээний сүүлийн



Ховдын толь ТББ-аас Ховд аймгийн ИТХ-тай хамтран зохион байгуулсан "Хөшөөтийн гэрээний хариуцлагыг шинжлэхүй" Нийтийн сонгогчийн цахим хуралдаан. 2021 оны 1 сарын 6-ны өдөр.

шатанд шалгарсан юм. Эдгээр бүтээл нь ОНХАГ-ний эргэн тойронд яригддаг хандив дэмжлэг, түүний зарцуулалт, хяналт, үр өгөөжийг тоон мэдээлэлд түлгүүрлэн хөндөж гаргасан нь энэ чиглэлээр олон нийтийн хяналтыг сайжруулах, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэхэд ач холбогдолтой юм.

Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бас нэг ажил нь төрийн бус байгууллагуудад өөрийн орон нутагт байгуулагдсан гэрээний хэрэгжилтийг үнэлэхэд дэмжлэг үзүүлсэн явдал байв. Энэ хүрээнд Дархан-Уул, Орхон, Төв, Дундговь, Сэлэнгэ, Булган, Ховд аймгуудад 8 ТББ бичил уурхай болон усан сан бүхий газарт явагдаж буй уул уурхайн үйл ажиллагааны нөхөн сэргээлтийн гэрээ, ОНХАГ-ний хэрэгжилтийг үнэлэх ажил хийж байна. Цар тахлын хорио цээрээс улбаалан мэдээлэл цуглуулахад бэрхшээл учирч байгаа боловч ТББ-ууд амжилттай ажиллаж тодорхой үр дүнгүүд гарч эхэлжээ. Тухайлбал, Ховд аймаг



Ховдын толь ТББ-ын тэргүүн Г.Төрмөнх мониторингийн үр дүнг танилцуулж буй нь

болон Хөшөөтийн нүүрсний уурхайг ажиллуулж буй МонЭнКо компанийн хооронд байгуулагдсан Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг үнэлсэн Ховдын толь ТББ нь мониторингийн үр дүнг



танилцуулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн ИТХ-тай хамтран нийтийн сонголыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгууллаа.

Ингэснээр ТББ-ын гаргасан зөвлөмж аймгийн ИТХ-ын шийдвэрээр баталгаажиж, гэрээ болон Хөшөөт хөгжил сангийн үйл ажиллагааны журмыг сайжруулахад хувь нэмэр оруулах болжээ. Түүнчлэн Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Байгаль орчныг хамгаалах нөхөрлөл, бүлгүүдийн холбооны Булган салбар зөвлөл нь бичил уурхайн нөхөрлөлөөс орон нутгийн захиргаатай байгуулдаг гэрээний хэрэгжилтийг үнэлэх төсөл хэрэгжүүлсэн юм. Төслийн үр дүнд гэрээт талбайд өөр аж ахуйн нэгж эсхүл нөхөрлөлийн гишүүн бус хүнийг ажиллуулах, тогтоосон шаардлагаас илүү хүчин чадал бүхий техник ашиглах, байгаль орчныг хамгаалах зардлыг бодитой тогтоохгүй байх зэрэг нийтлэг зөрчлүүд гарсаар байгааг тогтоосноос гадна Засгийн газрын тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журмыг цаашид сайжруулах шаардлагыг тодорхойлжээ.

Анх зөвхөн уул уурхайн салбарт яригдаж байсан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэлжүүлэн нийтэд мэдээлэх ажил өнгөрсөн онд улам өргөжин

Монгол Улсад бүртгэлтэй бүх хуулийн этгээдийг хамарсан шаардлага болон хэрэгжиж байна. Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ), Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) зэрэг байгууллагуудтай хамтран эцсийн өмчлөгчийн бүртгэлийн маягтыг боловсронгуй болгох, түүнийг бөглөх хялбарчилсан заавар боловсруулах ажлуудыг хийлээ. Хэдийгээр эцсийн өмчлөгчийн мэдээллийг УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар хариуцан бүртгэж байгаа боловч Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын хувьд энэхүү бүртгэл орхигдсон байсан юм. СЗХ-той хамтран ажилласны дүнд нээлттэй хувьцаат компаниудын эцсийн өмчлөгчийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэх ажлыг эхлүүлээ. Мөн “Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд-2020” хэлэлцүүлгийг СЗХ-той хамтран зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлгийн үеэр мэдээллийн ил тод байдал, эцсийн өмчлөгчийг нээлттэй болгох шаардлагын талаар хэлэлцүүлэгт оролцсон 140 гаруй аж ахуйн нэгжүүдэд танилцуулав. Мөн энэ үеэр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалтын үнэлгээ”-ний тайланг хэлэлцүүлж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон юм.



Монголын бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбоо ТББ-ын төслийн баг Сэлэнгэ аймгийн Ерөө суманд бичил уурхайчидтай уулзаж байгаа нь. 2020 оны 7 сар.



“Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд-2020” хэлэлцүүлэг: Баруун гар талын зурагт хэлэлцүүлэгт оролцогчид, зүүн гар талын зурагт хэлэлцүүлгийн үеэр судлаач Д.Тэгшбаяр эцсийн өмчлөгчийн ил тод байдлын асуудлаар мэдээлэл хийж буй нь. 2020 оны 9 сарын 17-ны өдөр

## НИЙТИЙН ЭРХ АШГИЙН ӨМГӨӨЛӨЛ

Сүүлийн жилүүдэд төрийн бус байгууллагууд төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний зүгээс гаргаж буй шударга бус шийдвэрийн улмаас эрх нь зөрчигдсөн хүмүүсийг төлөөлөн хуулийн хэрэгжилт шаардаж, хариуцлага нэхэх нийтийн эрх ашгийн өмгөөллийн ажлыг цөөнгүй явуулж байна. Төрийн үйл ажиллагаанаас үүдсэн нийтийн эрх ашгийн зөрчлийг илрүүлж, нийгэмд шударга ёсыг мэдрүүлэхэд нийтийн өмгөөлөл нэн чухал билээ. 2016 оноос ТББ-уудад хуулиар олгогдсон энэхүү боломжийг үр дүнтэй ашиглах чадавх бий болгоход бид байнга анхаарч сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулан, судалгаа дүн шинжилгээ хийж, ТББ-уудад тэтгэлэг олгож ирлээ. Энэ чиглэлээр 2016 оноос хойш давхардаагүй тоогоор нийт 23 байгууллагад, 36 тэтгэлэг олгоод байгаагаас 4 нь 2020 онд олгогджээ. Эдгээрийн 21 нь уул уурхайн салбар, 15 нь засаглалын бусад салбарт холбогдох төслүүд байгаа бөгөөд 4 байгууллага нийтийн эрх ашгийн өмгөөллөөр дагнан мэргэшиж байна.

Дээрх 36 тэтгэлгийн хүрээнд нийтдээ 42 өмгөөллийн үйл ажиллагаа явагдсанаас одоогийн байдлаар 17 нь шүүх болон бусад байгууллагаар эцэслэн шийдвэрлэгджээ. Үүнээс 14 хэрэгт нэхэмжлэлийн

шаардлагыг бүхэлд нь болон зарим хэсгийг хангах шийдвэр гарсан байна. Үүний зэрэгцээ нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгосон тохиолдлууд ч нэлээд байгаа бөгөөд дийлэнх тохиолдолд нэхэмжлэл гаргасан ТББ нь хуульд заасан шаардлагыг хангаагүй гэх үндэслэлийг шүүх баримталжээ.

Иймд 2019 онд хийж гүйцэтгэсэн “Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик” судалгааны тайланг хуульчдад танилцуулан хэлэлцүүлэг өрнүүллээ. Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороотой хамтран зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт цахимаар нийт 2600 орчим хүн оролцож, санал шүүмж өрнүүллээ. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэхэд “нийтийн ашиг сонирхол” зөрчигдсөн эсэхийг гол шалгуур болгодог олон улсын нийтлэг түршлагыг харгалзан манай улсын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ингэхдээ “нийтийн ашиг сонирхол” гэдгийг хуулиар оновчтой тодорхойлох ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай гэдэг дээр оролцогчид санал нэгдсэн юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 14 хуульд “нийтийн ашиг



“Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик” судалгааны тайлангийн хэлэлцүүлгийн явц, баруун гар талд судлаач Р.Мөнхзул сэтгүүлчдэд мэдээлэл өгч буй нь. 2020 оны 10 сарын 2-ны өдөр

сонирхол”-ыг хамгаалах тухай заалт байдаг боловч түүнийг нэг мөр оновчтой тодорхойлсон зохицуулалт өнөөг хүртэл аль ч хуульд байхгүй байна. Иймд “нийтийн ашиг сонирхол”-ыг хуулиар оновчтой тодорхойлох нь зөвхөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль төдийгүй дээрх хуулиудын хэрэгжилтийг хангахад ч чухал юм. Иймд цаашдаа Захиргааны эрх зүйн хороотой хамтран хуульчдын дунд энэ чиглэлээр бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх болно.

Уул уурхайн чиглэлээр 2020 онд нийтийн эрх ашгийн өмгөөлөлд гарсан амжилтаас дурдвал:


- Их бага Баяншарга ТББ-аас гаргасан Сүхбаатар аймгийн Уулбаян, Түвшинширээ сумдад олгогдсон цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хангах шийдвэр Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс гарав.
- Цагаан шорооны хор хөнөөлөөс ирээдүйгээ аврах хөдөлгөөн ТББ нь Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны сөрөг нөлөөллийг тогтоолгох Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэх нэхэмжлэлийг гаргасан юм. Хариуцагч БОАЖЯ-аас

нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Мөн энэ хэргийн хүрээнд ЭМЯ-аас Эрдэнэт үйлдвэрийн үүсгэсэн цагаан тоосны хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох ажлыг эхэлжээ.

- Эх орон хамтын хүч ТББ нь 2019 оноос эхлэн уул уурхайн боловсруулах, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг хариуцлагуулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох өмгөөлөл хийж байгаа юм. Үүний үр дүнд Дорноговь аймгийн Айраг суманд ажиллаж байсан 6 баяжуулах үйлдвэрээс байгаль орчинд учруулж байгаа нөлөөлөл, хуулийн зөрчлийг тогтоолгон үйл ажиллагааг нь зогсоолгов. Энэ хэргээр тогтоосон жишиг нь Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны журам батлагдан гарахад нөлөөлжээ.

Нийтийн эрх ашгийн өмгөөллөөр мэргэшиж байгаа Хил хязгааргүй алхам ТББ-ын төслийн хүрээнд дараах ахиц дэвшил гараад байна.

- Дорноговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс тус аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын уул уурхайн компанитай байгуулсан Орон нутгийн хамтын ажиллагааны



Нийтийн эрх ашгийн өмгөөллийн нөлөөллийн чадавх бэхжүүлэх цахим сургалт. 2020 оны 9 сарын 14-18-ны өдрүүд

гэрээг Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийгээгүй гэсэн үндэслэлээр илт хууль бусд тооцох шийдвэр гаргасныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэвээр үлдээжээ.

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансны орлого, зарлагын мэдээллийн ил тод байдлыг хангах нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч БОАЖЯ хүлээн зөвшөөрч, захиргааны хэргийн шүүх дээр Эвлэрлийн гэрээ байгуулаад байна.
- ЗТХЯ-аас Өмнөговь аймгийн Цогтцэций, Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Гурвансайхан, Баянжаргалан сумд; Говьсүмбэр аймгийн Шивээговь, Сүмбэр сумдын нутгаар дамжин шороон замаар нүүрс тээвэрлэж буй үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг гаргуулсан байна.
- Уул уурхайн үйл ажиллагааны нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний журам, аргачлал боловсруулах Ажлын хэсгийг ЗГХЭГ-аас байгуулан ажиллаж байна.

Ийнхүү амжилттай явагдсан өмгөөллийн үр дүнг баталгаажуулах, нийтийн ашиг сонирхлыг

хамгаалахад нэн ач холбогдолтой шүүхийн шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, жишиг болгон түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг эрчимтэй явуулах шаардлага үүсээд байна. Учир нь энэ чиглэлээр ажилладаг ТББ-ууд шүүхийн ажиллагаанд илүү анхаарч, гарсан шийдвэрийг сурталчлах, холбогдох талуудад хүргэж жишиг тогтоох асуудлыг орхигдуулах тал ажиглагдаж байна. Иймд нөлөөллийн ажлыг дэмжих чиглэлээр Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ-тай хамтран ажиллаж “Нөлөөллийн чадавх бэхжүүлэх” цахим сургалтыг зохион байгуулав. Сургалтад нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийж байгаа орон нутгийн 15 ТББ хамрагдлаа. Сургалтад оролцсон 8 байгууллагад нөлөөллийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх тэтгэлэг олгон, мэргэжлийн байгууллагатай холбон арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Орон нутагт хяналтыг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилтын хүрээнд ТАН эвсэлтэй хамтран ажиллаж, уул уурхайн салбар дахь хүний эрх, хууль тогтоомжийн зөрчлийг баримтжуулж бүртгэх цахим систем хөгжүүлж байна. *MiningWatch* нэртэй уг цахим систем нь иргэд, олон нийтээс зөрчлийн мэдээллийг хүлээн авч, газрын зурагт суурилан бүртгэлжүүлэх бөгөөд төрийн холбогдох байгууллагуудад уламжлан арга



Нийтийн эрх ашгийн өмгөөллийн амжилт, сургамжийн цуврал нийтлэлийг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас авч үзнэ үү.

хэмжээ авхуулах, хянан шийдвэрлэх ажиллагаанд нь олон нийтээс хяналт тавих боломжийг бүрдүүлэх юм. Тэрчлэн эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн иргэдэд ТАН эвслийн гишүүдийн туршлагад тулгуурлан хууль зүйн болон арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэхэд ашиглагдах юм.

Дээрх ажил нь уул уурхайн үйл ажиллагаа явагддаг орон нутгийн хэмжээнд хяналт, хариуцлагыг сайжруулах тухай 2021-2024 онд хэрэгжүүлэх шинэ стратегийн зорилтыг хангах эхний алхам боллоо. Мөн энэ хүрээнд уул уурхайн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтын тогтолцоо, үр нөлөөг сайжруулах зорилго бүхий судалгааны ажлыг эхлүүлээд байна. Судалгааны урьдчилсан дүн нь уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны нөлөөлөлд хяналт тавих чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүрэг давхардсанаас зарим асуудал хариуцах эзэнгүй орхигдсон, мэргэжлийн хяналтын байгууллагын хүний нөөцийн зохион байгуулалт, санхүүжилт, техникийн хүчин чадлыг сайжруулах, мэргэжлийн хяналтын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг хангуулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай байгааг харуулж байна. Тэрчлэн газрын тосны үйл ажиллагаанд тавих санхүүгийн

хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, санал шүүмж авахаар холбогдох талуудад хүргүүлээд байна. Дээрх судалгааны үр дүнд үндэслэн хяналт, шалгалтын тогтолцоо, цаашлаад орон нутагт хууль бодитой хэрэгждэг болгоход чиглэсэн бодлогын хэлэлцүүлгүүдийг өрнүүлэх юм.

Шинэ стратегийн хүрээнд дэвшүүлсэн бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх замаар Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилтын хүрээнд төрийн нийтийн өмч, түүнийг зөв зохистой удирдах, ялангуяа нийтийн өмчийн байгалийн баялгийг хайх, ашиглах үйл ажиллагаанд баримтлах журам, үр өгөөжийг зөв, оновчтой зарцуулах, тэгш шударга хуваарилах арга, механизмыг тодорхойлоход чиглэсэн судалгааны ажлуудыг хийж байна.

Эрдэс баялгийн салбарт нэгэнт төлөвшсөн ил тод байдлыг бодит хариуцлага бий болгоход үр дүнтэй ашиглах, өгөгдөл шинжилгээнд тулгуурласан бодлогын оновчтой шийдэл гаргах, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж, мэдээлэлд суурилсан хяналт, оролцоог бий болгох зорилгыг ирэх жилүүдэд дэвшүүлсэн билээ.



“Уул уурхайг өгөгдлөөр урлахуй” цахим хакатонд шалгарсан бүтээлийг олон нийтэд цахимаар танилцууллаа. 2020 оны 12 сарын 18.



ОУСК-ын Суурин төлөөлөгч Рүфат Алимарданов нээлтийн үг хэлж буй нь

Энэ хүрээнд 2020 онд Олон Улсын Валютын Сан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран “Уул уурхайг өгөгдлөөр урлахуй” цахим хакатоныг зохион байгуулав. Цар тахлын үед анх удаа цахимаар зохион байгуулагдсан уг уралдаанд нийт 200 гаруй залуус 60 баг болон оролцож, өгөгдлийн дүн шинжилгээ, дата сэтгүүл зүй, програмчлал, график дизайны чиглэлээр үр чадвараа өрсөлдүүлэн уралдлаа. Тэмцээний сүүлийн шатанд 13 бүтээл шалгарсныг цахимаар нийтэд шууд дамжуулж, ялагчдыг тодруулсан юм. Багууд ОУИТБС, байгаль орчны мэдээллийн сан болон тусгай зөвшөөрлийн бүртгэл, эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан, *OpenDataLab* зэрэг төр болон төрийн бус байгууллагуудын мэдээллийн сангийн томоохон өгөгдлүүдийг шинжилж, уул уурхайн тусгай зөвшөөрлийн олголт, орлогын менежмент, алтны салбарын үр өгөөж, байгаль орчны хамгаалалт, бичил уурхай, орон нутгийн гэрээ, хандив тусламж, төрийн өмчит компанийн

худалдан авалтын ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн сонирхолтой бүтээлүүдийг ирүүлсэн юм. ОУИТБС-ын тайлангийн өгөгдлүүдийг цэвэрлэн нээлттэй мэдээлэл (дахин боловсруулж, тооцоо хийж болохуйц) байдлаар бэлтгэн төрийн нээлттэй өгөгдлийн цахим сан ([www.opendata.gov.mn](http://www.opendata.gov.mn))-д байршуулсан нь тэмцээний бас нэгэн онцлох үр дүн байлаа. Уралдаанаас бий болсон салбарын засаглалыг сайжруулахад ач холбогдол бүхий шинэлэг, сонирхолтой бүтээлүүдийг олон нийтэд хүргэж, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлж, залуучуудын манлайлал бүхий дижитал нөлөөллийн ажил хийх юм. Тэрчлэн өгөгдлийн шинжилгээ, дата сэтгүүл зүйн үр чадвар бүхий залуус дундын мэдээлэл боловсруулагч (infomediaries)-ийн үүрэг гүйцэтгэх замаар эрдэс баялгийн салбарын мэдээллийг эргэлтэд оруулж, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.



# Уул уурхайг сансараас тандахуй

"Уул уурхайг өгөгдлөөр урлахуй" хакатон 2020 Team Up баг

TeamUp баг

АРДЧИЛГАН САЙН ЗАСАГЛАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нээлтийн үг хэлж буй нь


Тэмцээнд тэргүүн байр эзэлсэн *Team Up* багийн зүгээс хиймэл оюун ухаан ашиглан нөхөн сэргээлтийн ажлыг хамгийн бага зардлаар хөндлөнгөөс үнэлэх санааг дэвшүүлжээ. Хиймэл дагуулын зургаас тухайн уурхайн олборлолт, нөхөн сэргээлтийн явцыг *deep learning* ашиглан хянаж чадвал зөвхөн нөхөн сэргээлт төдийгүй голын голдирол гэх мэт хориглосон газар, зөвшөөрөлгүй олборлолт явуулахаас сэргийлэх боломж бүрдэх юм.

"Уул уурхайг өгөгдлөөр урлахуй" цахим хакатон 2020 оны 12 сарын 12-18-ны өдрүүдэд зарлагдав.

БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

ЦАР ТАХЛЫН ХАРИУ ҮЙЛДЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# СЭДВИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН



## ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БЭЛТГЭХ, ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ НЬ: ЦАХИМ ГАРЫН АВЛАГА

**ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БЭЛТГЭХ, ХЭЛЭЛЦЭН ТОХИРОЛЦОХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ НЬ**

ЦАХИМ ГАРЫН АВЛАГА


Орон нутгийн хөгжилд өгөөжтэй сайн гэрээ байгуулахад орон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллага, иргэний нийгмийнхэн чадавхтай байх нь маш чухал. Тиймээс орон нутгийн гэрээ бодитоор хэрэгжихэд ямар нөхцөл, шаардлага тавигдаж болох талаарх энгийн ойлголт, мэдээлэл энэхүү цахим гарын авлагад багтсан болно (электрон хувилбарыг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

## АЛТНЫ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДАЛ

ОУИТБС-ын тайланд үндэслэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дийлэнх хувийг эзэлдэг алтны салбарын эдийн засгийн өгөөжийн талаарх тойм мэдээллийг энэхүү хэвлэн нийтлэлд багтаасан болно. Засгийн газраас гаргасан 2018 оны санхүүгийн жилийн мэдээлэл бүхий тайланд үндэслэж энэхүү судалгаанд баримтын шинжилгээг хийжээ (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).




## БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ: ТӨВ, СЭЛЭНГЭ, ДУНДГОВЬ АЙМАГТ



Энэхүү бүтээгдэхүүнд Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо ТББ-аас Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Баянгол, Орхонтүүл сумд, Түнхэл, Хэрх, Бугант тосгон, Дундговь аймгийн Хулд, Өлзийт, Луус, Баянжаргалан сумдад 2017-2020 онд байгуулагдсан бичил уурхайн 27 гэрээг сонгон авч хэрэгжилтэд мониторинг хийсэн дүнг товчлон оруулав (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

## ОЛБОРЛОХ САЛБАР: ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЛИЙН БАГЦ

Олборлох салбарт эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэх шаардлага 2018 оноос эхлэн хэрэгжиж буй. ННФ нь хуулийн энэхүү шаардлагын хэрэгжилтэд АТГ-тай хамтран дүн шинжилгээ хийж, төрийн холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх замаар цаашдын хэрэгжилтийг сайжруулах алхмуудыг тодорхойлсон зөвлөмж бэлтгэснийг энэхүү мэдээллийн багцад багтаасан болно (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).







## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛИЙН 2 ДАХЬ ХЭСГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТОДРУУЛАХ НЬ

Энэхүү судалгааг Б.Гүнбилэг ахлагчтай судалгааны баг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт орсон нэмэлт өөрчлөлтийг заалт, нэр томьёо тус бүрээр нарийвчлан авч үзэж агуулга, утга санааг нь тайлбарлажээ. Уг тайлбарууд нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийг шинэчлэн Үндсэн хуульд нийцүүлэх ажилд чухал ач холбогдолтой байх юм (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨРИЙН НИЙТИЙН ӨМЧ: ГАЗАР БА ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ, ГАЗРЫН ХЭВЛИЙН БАЯЛАГ БА ХУВЬЦАА

Судлаач Н.Баярмаа нь энэхүү судалгаагаараа өмчийн тулгуур онол, хандлагад тулгуурлан нийтийн өмч, тэр дундаа Үндсэн хуулиар тодорхойлсон төрийн нийтийн өмчийн ойлголт, эрх зүйн үндсийг тодорхойлохыг зорьсон. Энэ хүрээнд төрийн нийтийн өмчийн суурь болох газар, газрын хэвлийн баялгийн удирдлага, зохицуулалтыг сайжруулахтай холбоотой саналуудыг дэвшүүлжээ (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ЯПОН УЛСЫН ЖИШЭЭ

Судлаач Г.Даваанямын энэхүү судалгаа нь Япон Улсын төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын туршлагад тулгуурлан манай улсад төрийн өмчийн бүртгэл, хяналт, тайлагналын тогтолцоог сайжруулахад санаа авахуйц шинэ саналуудыг дэвшүүлсэн сонирхолтой бүтээл юм (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Уг судалгаанд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон орон нутгийн өмчит 9 компанийг хамруулан худалдан авалтын ил тод байдлыг нь үнэлжээ. Тэрчлэн худалдан авалтын ил тод байдлыг хангахтай холбоотой хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, худалдан авалтын үйл ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах зөвлөмжийг олон улсын жишиг туршлагад үндэслэн гаргажээ. Судалгааг Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл ТББ гүйцэтгэсэн болно (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).





# ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

## ХҮНИЙ ЭРХ

Монгол Улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах, иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж ННФ энэ чиглэлээр олон жил ажиллаж ирлээ. Энэ онд “Ковид-19” цар тахлын дэгдэлтийн улмаас хүн төрөлхтөн хүнд сорилттой тулгараад буйтай

холбоотойгоор хүний эрхийн хэрэгжилтэд ч цөөнгүй бэрхшээл учраад байна. Тиймээс Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум (Хүний эрхийн форум гэх) нь хүний эрхийн салбарт гарч болзошгүй үхралтаас сэргийлэх, өмнөх ололтоо бататгахыг эрмэлзэн ажиллалаа.

## ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хүний эрхийн форум нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмд Хүний эрхийн үндэсний тогтолцоо, Бодлогын үялдаагүй хөгжил ба хүний эрх, Бүлгийн эрх, Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо сэдвээр хамтарсан илтгэл; Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, Эрүүдэн шүүхээс ангид байх эрх, Бэлгийн хүчирхийлэл, Хүн худалдаалах гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэл, Бэлгийн цөөнх хүмүүсийн эрх зэрэг сэдвээр дангаар илтгэл бэлтгэн хүргүүлсэн билээ. Бид НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илгээсэн тайланд тулгуурлан бэлтгэдэг “Мэдээллийн хуудас”-ыг англи хэл дээр бэлтгэн Монгол Улстай дипломат харилцаатай орны Элчин сайдын яамдад цахимаар илгээхийн зэрэгцээ зарим дипломат ажилтнуудтай биечлэн уулзалт хийлээ.

Тэрчлэн Хүний эрхийн форумын гишүүн байгууллагууд UPR-Info олон улсын ТББ-аас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хурлын өмнө зохион байгуулдаг бэлтгэл хуралдаанд энэ оны 10

дугаар сард цахимаар оролцож, илгээсэн тайлангаа НҮБ дахь улс орнуудын дипломат төлөөлөгчдөд танилцууллаа. Мөн Монголын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцэх НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хурал цар тахлын улмаас 5 дугаар сард хийх боломжгүй болж, 11 дүгээр сарын 4-ний өдөр цахимаар хуралдсан билээ. Тус хуралдааныг олон нийтэд цахимаар хүргэсэн бөгөөд энэхүү шууд дамжуулалтын хандалт ННФ-ын фэйсбүүк хуудсаар гэхэд 17,000 орчимд хүрчээ. Мөн тус хуралдааныг Лайв ТВ-ээр хоёр удаа бүрэн хэмжээгээр цацлаа. Энэ нь монголын хүний эрхийн нөхцөл байдлыг НҮБ-ын гишүүн орнууд хэрхэн дүгнэж байгааг иргэдэд шууд дамжуулан хүргэснээрээ чухал ач холбогдолтой боллоо. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдаанаас нийт 190 зөвлөмж ирүүлснээс Монгол Улсын Засгийн газар 170 зөвлөмжийг хянан үзэж, хүлээн авах эсэх хариултаа Хүний эрхийн зөвлөлийн 46 дугаар хуралдаанаас өмнө хүргүүлэхээр амлалт аваад байна.

Хүний эрхийн салбарт төр, төрийн бус байгууллага тогтмол, үр дүнтэй, жинхэнэ утгаар зөвлөлдөх үйл явцыг бий болгохыг Хүний эрхийн форум зорьсны дүнд тодорхой ахиц гарсныг сүүлийн жилүүдийн зөвлөлдөх үйл явц батлан харуулж байгаа билээ. Зөвхөн UPR механизм төдийгүй өөр бусад асуудлаар зөвлөлдөх санаачилгыг төрөөс гаргах болсон бөгөөд энэ онд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороонд илгээх Засгийн газрын тайлангийн хэлэлцүүлэгт Хүний эрхийн форум оролцож санал шүүмж өглөө.

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэхэд эрх зүйн орчин нэн чухал тул Хүний эрхийн хамгаалагчийн тухай, Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК)-ын тухай хуулийн төслүүд боловсруулах, хууль батлах нөлөөллийн үйл явцад идэвхтэй оролцож ирлээ. Үүний дүнд ХЭҮК-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ энэ

оны нэгдүгээр сард баталж, ХЭҮК-ын гишүүнд нэр дэвших, сонгон шалгаруулах үйл явц олон нийтэд нээлттэй, ил тод явагдах боломжтой болсон. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо ХЭҮК-ын гишүүдийг сонгон шалгаруулах Ажлын хэсэг байгуулахдаа Хүний эрхийн форумаас төлөөлөл оруулахаар тогтоосон нь тус Форумыг хүний эрхийн салбарт нэг гол тоглогч болохыг хүлээн зөвшөөрч буйн илэрхийлэл юм. Сонгон шалгаруулалтын явцад анх удаа Томилгооны сонгол зохион байгуулсан нь бие даасан хараат бус институтийн томилгоонд үлгэр жишээ болохуйц үйл явдал боллоо.

Бид 2017 оноос эхлэн хүний эрх хамгаалагчийн хуультай болохын төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд энэ онд тус хуулийн төслийг УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар санаачилж өргөн барьсан бөгөөд УИХ-ын намрын чуулганаар хуулийн төслийг хэлэлцэх шийдвэр гарлаа. Хүний эрхийн



“НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛД МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ ХУРАЛ”-ыг шууд дамжуулах мэдээллийн үйл ажиллагаа, 2020 оны 11 сарын 4.

форум нь дээрх хуулийн төслүүдэд идэвхтэй оролцож, санал шүүмжээ өгөхийн зэрэгцээ “Ковид-19” цар тахлын улмаас болзошгүй эрсдэлээс сэргийлэх чиглэлээр анхаарал хандуулж ажиллалаа. Тухайлбал, УИХ-аас Гамшгаас хамгаалах тухай болон Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан

сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиудын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, санал шүүмж хүргүүлсний дүнд хүний эрхийн хязгаарлалтад тавигдах шалгуурыг хуульд тодорхой тусгуулж чадлаа. Энэ нь хүний эрхийн эрх зүйн хөгжилд тун чухал ахиц дэвшил юм.

## ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ

ННФ-аас хүний эрхийн боловсрол, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, мөн нийгэмд өрнөж буй хүний эрхийн “халуун” сэдвээр өрнөдөг хэлэлцүүлэг цар тахлын улмаас цахим хэлбэрт шилжлээ. Хэлэлцүүлгийг цахимаар явуулах болсноор танхимын багтаамжаас хамааран 60-аас ихгүй тооны хүмүүс оролцдог байсан хэлэлцүүлэгт 70-1000 хүн шууд оролцож байсан нь үйл ажиллагааны хүрээг өргөтгөсөн юм. Бид цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Цар тахал ба хүний эрх, Хууль сахиулах үйл ажиллагаа ба хүний эрх, Цар тахал ба сонгууль зэрэг сэдвээр ярилцлаа. “Ковид-19” цар тахлын улмаас хэлэлцүүлгүүд тогтмол хугацаанд зохион байгуулагдаж чадаагүй бөгөөд бид

зарим үйл ажиллагааны хэлбэрийг өөрчилсөн болно. Тухайлбал, хүний эрхийн олон нийтийн лекцийг видео ток шоу болон хүндэтгэлийн лекц гэсэн хосолмол хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж анхны ток шоу олон нийтэд хүргээд байна. Харин 2020 оны ихэнх өдрүүдэд хүн олноор цуглахыг хориглосон байсан тул Монголын эмнести интернэшнл ТББ-тай хамтран зохион байгуулдаг Хүний эрхийн кино хэлэлцүүлгийг зохион байгуулаагүй болно. Гэвч хүний эрхийн кино хэлэлцүүлгийг сургалтын хэрэглэгдэхүүн болгох боломжийг хуулийн их, дээд сургуулийн багш нарт зориулан танилцуулах хэлэлцүүлэг зохион байгууллаа.



“Хүний эрхийн тухай ярилцъя” хэлэлцүүлэг “КОВИД-19 БА ХҮНИЙ ЭРХ”, зочноор Монголын Эмнести Интернэшнл ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор О.Мөнхсайхан, ХЭҮК-ын Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцлоо. 2020 оны 4 сарын 16.



“Хүний эрхийн тухай ярилцъя” хэлэлцүүлэг “СОНГУУЛЬ 2020 БА СОНГОХ ЭРХ”, зочноор ХЭҮК-ын ахлах референт З.Өнөржаргал, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-эрдэнэ, Сонгогчдын боловсрол төвийн гүйцэтгэх захирал С.Оюунтуяа нар оролцлоо. 2020 оны 5 сарын 14.



“Хүний эрхийн тухай ярилцъя” хэлэлцүүлэг “ХҮНИЙ ЭРХ ӨЧИГДӨР, ӨНӨӨДӨР, МАРГААШ” сэдвийн хүрээнд ННФ-ын хурлын танхимд 2020 оны 1 дүгээр сарын 16-нд болж, зочноор ГХЯ-ны Хүний эрхийн хэлтсийн дарга, Монгол Улсын Хүний эрхийн зөвлөлийн гишүүн (2016-2018) В.Оюу оролцлоо.

## ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН ТУХАЙ

НҮБ нь “Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн сахих нь бүх нийтийн аюулгүй байдал, энх тайвны үндэс” болохыг тунхаглаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэмээх түүхэн чухал баримт бичгийг 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталснаас хойш жил бүрийн энэ өдрийг “Хүний эрхийн өдөр” хэмээн дэлхий нийтээрээ тэмдэглэдэг уламжлал тогтсон билээ. Хүний эрхийн форум нь 2014 оноос эхлэн хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд тайван жагсаал зохион байгуулж ирсэн туршлагатай. Өнгөрсөн оноос энэ үйл ажиллагааг дотор тэмдэглэж эхэлсэн бол энэ онд цахимаар тэмдэглэн өнгөрүүлээ.

Хүний эрхийн олон улсын өдрийг “Хүний эрхийг дээдэлж, цар тахлыг даван туулья” уриан доор цахимаар тэмдэглэж, 7 хоногийн аян өрнүүлсэн

бөгөөд 69,000 орчим хүн Хүний эрхийн форумын фэйсбүүк эвентийг үзэж сонирхсон байна (цахим аяны хүрээнд гарсан постеруудыг хуудас 52-оос харна уу). Энэ онд Хүний эрхийн форум үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ой тохиож байгаа тул 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан цахим Хэвлэлийн хурлаар өнгөрсөн хугацаанд хийсэн онцлох ажлаа олон нийтэд хүргэлээ. Бид энэ жилийн тухайд ухралт гарч болзошгүй хүний эрхийн талаар олон нийтэд таниулах, энэ чиглэлээр төрийн хүлээх үүргийг сануулах, орхигдсон бүлгийн асуудалд талуудын анхаарлыг хандуулахыг зорьсон болно. Мөн Хүний эрхийн форумаас анхаарал хандуулж, нөлөөлж ирсэн Хүний эрх, хамгаалагчийн тухай хууль, Бизнес, хүний эрхийн төлөвлөгөөг олон нийтэд таниулах ажил үүнд багтсан.

ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМААС “ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛЖ, ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛЪЯ” УРИАН ДОР ӨРНҮҮЛСЭН ЦАХИМ АЯНЫ ХҮРЭЭНД ГАРГАСАН ПОСТЕРУУД




### ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

- Хүний эрхийн Форумын уулзатууд танхимд 3 удаа, цахимаар 6 удаа
- ХЭҮК-ын болон Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Томилгооны сонсгол, 6 дугаар сарын 10-11
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн III циклийн Ажлын хэсгийн хурлын шууд дамжуулалт, 11 дүгээр сарын 4
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн Засгийн газрын тайланд Хүний эрхийн форумын гишүүд санал, шүүм өгөх цахим хэлэлцүүлэг, 11 дүгээр сар
- Хуулийн их, дээд сургуулийн багш нарт зориулан “Хүний эрхийн кино хэлэлцүүлгийг сургалтын хэрэглэгдэхүүн болгох нь” хэлэлцүүлэг, 10 дугаар сард
- “Хүний эрхийг дээдэлж цар тахлыг даван туулья” 7 хоногийн цахим аян
- “Цар тахал ба Хүний эрх”, “Хүний эрхийн тухай ярилцъя” уулзалт
- “Цар тахал ба Сонгууль”, “Хүний эрхийн тухай ярилцъя” уулзалт
- “Цагдаагийн алба ба Хүний эрх”, “Хүний эрхийн тухай ярилцъя” уулзалт
- “Хүний эрхийн хязгаарлалтын зарчим” шторкийг олон нийтэд түгээлээ.

### ОРОЛЦСОН АРГА ХЭМЖЭЭ

- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хурлын өмнөх Бэлтгэл хуралдаанд Хүний эрхийн форумын төлөөлөл цахимаар оролцлоо.
- ХНХЯ-аас зохион байгуулсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн Засгийн газрын тайлангийн хэлэлцүүлэгт 10 дугаар сард оролцлоо.
- ХЗДХЯ- аас зохион байгуулсан Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн Засгийн газрын тайлангийн хэлэлцүүлэгт 11 дүгээр сард оролцлоо.
- “Хандлагаа өөрчилъё” ток шоуны анхны дугаарт Глоб интернэйшнл төв ТББ-ын Тэргүүн Х.Наранжаргал оролцлоо.

## СЭДВИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН



### ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ИЛТГЭЛ (АНГЛИ)

Монгол Улсын Засгийн газар хүний эрхийн нөхцөл байдлаа дээрдүүлэх чиглэлээр 2015 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс авсан үүрэг амлалтаа 2020 оны 5 сард хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан Монголын Хүний эрхийн форумаас сонгож авсан 10 сэдвийн хүрээнд мэдээлэл бэлтгэж гаргалаа. Энэ нь 20 орчим аймаг, орон нутаг, нийслэлийн 1000 гаруй иргэдээр хэлэлцүүлж, хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл төрийн байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулагдсан мэдээлэл юм (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

## ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл сэдвийн хүрээнд Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бие даасан судалгаа, мониторингийн үр дүнгээр хангахын зэрэгцээ, шинэ эрх зүйн орчинд ажиллах эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах шатанд

иргэний нийгмийн санал бодлыг нэгтгэн хүргэхийг зорьж ирсэн. 2020 онд цар тахлын улмаас тулгарч буй сорилтыг даван туулахад эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулахын зэрэгцээ эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг үнэлэхэд гол анхаарлаа хандууллаа.

### Эрх зүйн шинэчлэлийн үйл явцад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хууль сахиулах байгууллагад техникийн туслалцаа үзүүлэх нь

Эрх зүйн шинэ орчныг иргэний нийгэмд таниулах, энэхүү шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд иргэний нийгмийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эхлүүлсэн “Хуулийн хэлэлцүүлэг”-ийг үргэлжлүүлэн зохион байгууллаа. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажил эхлээд байгаа билээ. Энэ хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн найруулж байгаа бөгөөд тус хуулийн төслийн хэлэлцүүлгийг 6 дугаар сард зохион байгуулж, шүүмжийг холбогдох талуудад хүргүүлээд байна. Хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр хууль тогтоогчид тус шүүмжийг анхааран хэлэлцсэн болно. Мөн цаг үеийн нөхцөл

байдалд хариу үзүүлэх хүрээнд Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хэлэлцүүлгийг өргөн хүрээний оролцоотойгоор 12 дугаар сард зохион байгууллаа.

Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд ННФ-ын оруулж буй нэг хувь нэмэр бол бодлогын судалгааг дэмжиж буй явдал билээ. Бид өнгөрсөн онд эхлүүлсэн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, өршөөлийн хуулиудад хийх дүн шинжилгээ, нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, хорихоос суллагдсан этгээдэд тавих захиргааны хяналт, бага насны хүүхдийг алах, хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдал, гэрч хохирогчийн хамгаалалт, хорих ялыг дүйцүүлэн хасах жишиг зэрэг сэдвээр бодлогын



“Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт” судалгааны дүнг танилцуулах хэлэлцүүлэг, зочноор Улсын ерөнхий прокурорын газрын Сургалтын төвийн сургагч багш, прокурор Ц.Мөнхбат оролцлоо. 2020 оны 5 сарын 8.



судалгааг олон нийтийн хүртээл болголоо. Эдгээр судалгаа нь эрх зүйн шинэчлэлийн зарим бодлогыг үнэлж, маргаан бүхий зарим асуултад хариулт өгч, төрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд түлхэц болохуйц үр дүнг олон нийтэд тодорхой арга зүйд тулгуурлан, нотолгоо, дүгнэлттэй танилцуулж байгаагаараа ач холбогдолтой. Нөгөө талаас шинэчлэлийг буруушаах, хуучин зохицуулалтыг шаардах, эсхүл хэрхэн хэрэгжүүлэх арга замаа олоогүй зэрэг хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд зохих үр дүнгээ өгнө хэмээн найдаж байна. Судалгаанд тулгуурлан цуврал хэлэлцүүлэг хийх замаар судалгааны үр дүнг хэрэглээнд оруулж, эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд нөлөөлөхийг зорьж байгаа бөгөөд энэ жил “Хохирлын үндэсний тогтолцоог үнэлэх нь”, “Нийтэд түстэй ажил хийлгэх ялын хэрэгжилт” гэсэн сэдвээр цахим хэлэлцүүлэг зохион байгууллаа.

2020 онд “Халдашгүй байх эрхэнд халдах зөвшөөрлийн тогтолцоо”, “Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг үндэсний статистиктай нийцүүлэх боломж”, “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдалд дүн шинжилгээ хийх нь”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн

ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх”, “Шинэ эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт сумын түвшинд”, “Эрүүгийн хууль дахь шударга ёсны зарчмын хэрэгжилт”, “Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал”, “Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт” зэрэг сэдвээр судалгааны ажил эхлүүлж, зарим судалгааг олон нийтэд хүргээд байна.

2012 оноос эхэлсэн эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн дүнд олон нийт, иргэний нийгмийн байгууллагын зүгээс хохирогчийн эрх зүйн хамгаалалт сайжирч, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор үршгийн барагдуулалт сайжирна хэмээн хүлээж байсан билээ. Тиймээс бид хохирол барагдуулалтын өнөөгийн нөхцөл байдал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэг буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зохицуулалтын хэрэгжилтэд үнэлгээ өгөх ажлыг тус тус эхлүүллээ. Үүний дүнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, практикт тулгарч буй асуудлыг тодруулж, цаашид хийх шаардлагатай ажлыг тодорхой болгох боломж бүрдэх юм.

## Эрх зүйн шинэчлэлийн мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх

Эрх зүйн шинэчлэлийг үнэлэх явцад шинэ хууль тогтоомжийн талаарх хуульч, хууль сахиулагчдын ойлголт мэдлэг хангалтгүй байгаагийн улмаас хүндрэл учирч байгаа нь тодорхой болсон билээ. Тиймээс Монголын Хуульчдын Холбоо, ХЗДХЯ-тай хамтран шинэ эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх ажлыг эхлүүлэв. Энэ хүрээнд МХХ “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн зохицуулалт, онцлог”, “Эрүү шүүлт”, “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагааны онцлог” зэрэг сэдвээр хуульчдад зориулсан сургалтын

хөтөлбөр боловсруулж, сургалтыг эхлүүлээд байна. Харин хууль сахиулагчдад зориулсан сургалтын тухайд ХЗДХЯ-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд хууль сахиулагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургагч багш бэлтгэх ажлыг өнгөрсөн онд зохион байгуулсан билээ. Энэ онд тус сургалтыг орон нутагт зохион байгуулах байсан ч цар тахлын улмаас танхимын үйл ажиллагааг хойшлуулсан тул сургалтыг цахимд шилжүүлэх бэлтгэлийг хангалаа. Энэ хүрээнд хамгийн түгээмэл зөрчигдөж байгаа эрх зүйн асуудлаар 4 цуврал видео контент бэлтгээд байна.

# Мониторинг

Өнгөрсөн онд хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэрэгт дүн шинжилгээ хийх, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, хариуцлага хүлээлгэж буй байдал, нийтийн хэв журмыг сахиулах үйл ажиллагаа, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд


нөлөөлөх сургалтын зохион байгуулалт, хорихоос суллагдсан хүнд тавьж буй захиргааны хяналт, хүүхэд хохирогчтой гэмт хэрэг, зөрчлийн гомдол мэдээллийн шийдвэрлэлт сэдвийн хүрээнд эхлүүлсэн 10 мониторингийн үр дүнг олон нийтэд танилцуулах ажлыг энэ онд хийлээ.

## СЭДВИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН МОНИТОРУУД




### ХЭРЭГСЭХГҮЙ БОЛСОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явагдаж хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийг судалж, дүн шинжилгээ хийх замаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах ажлыг “Төр Иргэн Түншлэл”, “Өнөмөнхийн эгшиглэн”, “Зөв хөгжил, үр дүнт оролцоо” ТББ-ууд хийсэн билээ. Тус мониторингоор Орхон, Төв аймаг, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг хамрагдлаа (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).




### АВЛИГЫН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн ТББ энэхүү мониторингийг хийсэн бөгөөд мониторингийн хүрээнд Авлигатай тэмцэх газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн талаар нэгдсэн тоон мэдээлэл, үзүүлэлтийг тодруулж, тэдгээрийг шийдвэрлэж буй процесст хууль зүйн шинжилгээ хийлээ (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН БУСАД ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээ, хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд Эрх зүйн соёл ТББ мониторинг хийсэн билээ. Мониторингоор [legalinfo.mn](http://legalinfo.mn), ЭМЯ, ХЗДХЯ, ХНХЯ, ЭХЭМҮТ, НЦГ-ын Мэдээлэл дүн шинжилгээний алба, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв зэрэг газрын баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн болно (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## МОНГОЛ УСЛЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөлд санал, шүүмж өгөх хэлэлцүүлгийг энэ оны 5 дугаар сард зохион байгуулж, ерөнхий санал дүгнэлт 9, тусгай санал дүгнэлт 31-ийг гаргаснаа нэгтгэн “Хуулийн шүүмж”-ийн энэ удаагийн дугаарт нийтлэн хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг хүргүүлээ (бүрэн эхээр [www.fogum.mn](http://www.fogum.mn) сайтаас үзнэ үү).

## ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХЭД ХАЛДАХ ЗӨВШӨӨРЛИЙН ТОГТОЛЦОО

Уг судалгаагаар судлаач, хуульч Л.Галбаатар Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан хүний халдашгүй байх эрхэд халдах өнөөгийн тогтолцоо оновчтой эсэх, түүний үндэслэл, зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд нийцэж буй байдал, тэрхүү тогтолцоог хэрхэн өөрчлөх шаардлагатай талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан (бүрэн эхээр [www.fogum.mn](http://www.fogum.mn) сайтаас үзнэ үү).



## НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ

Энэхүү судалгаагаар УЕП-ын газрын Сургалтын төвийн сургагч багш, прокурор Ц.Мөнхбат нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн нийтэд тустай ажил хийлгэх ялын тогтолцоог хууль зүйн шинжлэх ухааны онол, арга зүйн болон шүүхийн практикт үндэслэн судалж, тухайн ялын хэрэгжилтийн өнөөгийн бодит байдал дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашдын чиг хандлагыг тодорхойлж, санал дүгнэлт боловсруулаа (бүрэн эхээр [www.fogum.mn](http://www.fogum.mn) сайтаас үзнэ үү).



АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛДЫГ БЭХЖҮҮЛЭХ

ЭРХ ЗҮЙН ШИНЭТЛЭЛИЙГ ДЭМЖИХ

БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

ЦАР ТАХЛЫН ХАРИУ ҮЙЛДЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



## ЦАГДААГИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХ

Цагдаагын байгууллагын ажиллагааны журам хүний эрхийн стандарт, хууль тогтоомжид хэр нийцэж байгааг үнэлсэн уг судалгаа цагдаагийн албаны дотоод дүрэм, журмыг шинэчлэх, системчлэх, нэгтгэн эмхэтгэх ажил эхэлснээс 10 гаруй жилийн дараа, цагдаагийн албаны тухай хууль 2 удаа шинэчлэн найруулагдаж, мөн шинэ эрүүгийн хууль тогтоомж мөрдөгдөж эхэлсний дараа хийгдсэнээрээ ач холбогдолтой. Судалгааг ДХИС-ийн докторууд (Д.Эрдэнэбаатар, Ю.Бадамханд, Д.Булган) хийж гүйцэтгэв (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧИМД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХ

ДХИС-ийн багш, доктор Д.Эрдэнэбаатар ахлагчтай баг тус судалгааг хийсэн ба цагдаагийн мэргэжлийн албаны чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн хуваарь, албан хаагчийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулав (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ШУДАРГА ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

Уг судалгаа нь *Ne bis in idem* буюу Шударга ёсны зарчмын хэрэгжилтийг тодорхой гэмт хэргийн жишээн дээр тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 болон 12.3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан хэргийн хүрээнд судалж, улмаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох, улмаар энэ асуудалд судлаачдын анхаарлыг хандуулах зорилготой (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## ГЭМТ ХЭРГИЙН ОЛОН УЛСЫН СТАТИСТИКИЙГ ҮНДЭСНИЙ СТАТИСТИКТАЙ НИЙЦҮҮЛЭХ БОЛОМЖ

ННФ-ын захиалгаар ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС сан ТББ-ын судлаачид “Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллыг үндэсний статистиктай нийцүүлэх боломж” сэдвийн хүрээнд Гэмт хэргийн статистикийн олон улсын ангиллын ойлголт, түүний 11 бүлэг үзүүлэлтийн тухай ерөнхий тоймыг танилцуулжээ. Түүний дотор 01-03 дугаар ангилалд хамаарах бүх түвшний ангиллын задаргааг нарийвчлан дурдаж, эдгээр үзүүлэлтийг манай улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлттэй хэрхэн нийцүүлж нөхөх боломжтойг судалж гаргав (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО: ЦУВРАЛ СУДАЛГАА

НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Монгол Улсын Үндсэн хуульд “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх” хуульчлагдсан байдаг. Эдгээр баримт бичигт “төр иргэнийхээ эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээх үүргийг хариуцах” тухай, МУҮХ-ийн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт иргэнд “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг...”, 19-р зүйлд төрийн “хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг” тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гэмт хэргийн хохирлын талаарх уламжлалт ухагдахууныг өөрчилж, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор үршгийг тогтоох, тодорхойлох, мөнгөн дүнгээр илэрхийлж нөхөн төлүүлэх материаллаг болон процессын эрх зүйн шинэ орчин бүрдсэн. Гэвч гэмт хэргийн хохирлыг тогтоох, үнэлэх ажиллагаа одоо ч хуучин арга барилаар явагдаж, хохирол нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг нөхөн сэргээх явдал хангалтгүй байна гэх шүүмжлэл хэргийн оролцогч талуудаас гарсаар байна. Иймд эдгээр материаллаг болон процессын хуулиудад гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан эдийн болон эдийн бус хохирол, хор үршгийг тогтоох, үнэлэх, нөхөн төлүүлэх ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг судлан тогтоох зорилгоор энэхүү цуврал судалгааг хийж гүйцэтгэв (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).





Энэхүү эмхэтгэлд дараах гурван судалгааг нэгтгэж, хэвлэн нийтлэв.

### ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Манай улсад Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлт хэрэгжиж эхлээд хоёр жил гаруй болсон хэдий ч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас аль болох зайлсхийх, улмаар хохирогч, яллагдагч, бусад оролцогчийн эрхийг бүрэн хангахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх хандлагатай байна. Иймд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг зохих ёсоор явуулж, мөрдөн шалгах ажиллагаа шударга явагдах нөхцөлийг бүрдүүлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлох замаар шаардлагатай санал, зөвлөмж боловсруулахыг зорьсон билээ. Тус судалгаанд Монголын Криминологичдын холбооны судлаачид ажилласан болно.

### ХОРИХ ЯЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАСАХ АРГАЧЛАЛЫН ХЭРЭГЛЭЭ

Хорих ялыг дүйцүүлэн, эсхүл нийцүүлэн хасах ойлголт, аргачлалыг нэг мөр тайлбарлаж, практикт жишиг тогтоох санал, шийдэл гаргах замаар бодит ажил хэрэг болгох нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах соёлыг төлөвшүүлэхэд нэн шаардлагатай алхам болохыг Хууль зүйн доктор, математикийн ухааны магистр Б.Мөнхдоржийн хийсэн үг судалгаанаас харж болно.

### ХОРИХООС СУЛЛАГДСАН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ

Судлаач Б.Одонгэрэлийн энэхүү судалгаа нь Монгол Улсад хорихоос суллагдсан этгээдэд хяналт тавих, нийгэмд эргэн нэгтгэх, халамжлах ажиллагаа ямар түвшинд байгааг илрүүлэх, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, өнөөгийн байдлыг олон улсын болон гадаад улсын зохицуулалттай харьцуулан жиших, нөхцөл байдлыг шинжлэн судалсны эцэст эрх зүйн болон практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон.

## ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгын хүрээнд бид 2019 онд бий болсон нөхцөл байдалд дүгнэлт хийхийн сацуу улс төрийн үйл явдлын эрчим, хөдөлгөөнийг харгалзан дараах зорилтуудыг тавьж ажиллалаа. Үүнд:

1. Шүүхийн тухай хууль тогтоомжийн шинэтгэлийг ил тод, шударга ёсонд нийцүүлэхэд чиглэсэн

нөлөөллийн дэмжлэг үзүүлэх;

2. Шүүх эрх мэдлийн хүрээний судалгааны ажлыг үргэлжлүүлж, арга зүйн хувьд бэхжүүлэх;
3. Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллах.

## ШҮҮХИЙН ХУУЛИЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд шүүх эрх мэдлийн хүрээнд оруулсан өөрчлөлтийг “амь оруулж” хэрэгжүүлэхэд шүүхийн тухай хууль тогтоомжийг шинэчлэн батлах явдал чухал юм. 2020 оны 1 дүгээр сарын 31-нд Хууль зүй, дотоод хэргийн яамны боловсруулсан Шүүхийн тухай хуулийн төсөлд олон нийтийн санал авах зорилгоор яамны цахим хуудсанд тавигдсан үеэс ННФ хуульч, судлаачдаас бүрдсэн Зөвлөлдөх

баг ажиллуулж хуулийн төслийг олон талаас нь судлах, санал зөвлөмж боловсруулах, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр ажиллаж ирлээ. Эдгээр ажлын үр дүнг “Хуулийн шүүмж”-ийн 3 дугаар, “Бодлогын асуудал”-ын 2 дугаарт хэвлэн нийтэлснээс гадна бодлогын санал зөвлөмжийг эмхэтгэн хэвлэж бодлого боловсруулагчдын гарт хүргүүлээд байна.



ННФ, МХХ, ШЕЗ-ийн хамтран зохион байгуулсан Шүүхийн тухай хуулийн хэлэлцүүлэг 2020 оны 9 сарын 29



Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх гурав дахь цуврал хэлэлцүүлэг: Шүүхийн хариуцлагын тогтолцоо 2020 оны 5 сарын 7

Түүнчлэн хуулийн төслийн дүн шинжилгээ, бодлогын зөвлөмжөө танилцуулах үүднээс цаг үеийн нөхцөлд нийцүүлэн 4 цуврал цахим хэлэлцүүлэг зохион байгуулах, телевизийн ярилцлага хэлэлцүүлгүүдэд оролцож хараат бус байр суурийг илэрхийлэх зэргээр судлаач, хуульчидтай нягт хамтран ажилласан юм.

2020 оны 10 сард УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос УИХ-ын гишүүн Б.Энхбаяраар ахлуулсан Шүүхийн тухай хуулийн төслийг сайжруулж, батлуулах ажлын хэсгийг томилон хууль санаачлагчид, шүүгчид, судлаачдын өргөн бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг байгуулж дээрх ажлыг хариуцуулах шийдвэр гарсан. Уг ажлын хэсэг Засгийн газраас өргөн барьсан Шүүхийн тухай хуулийн төсөлд 70 гаруй зарчмын зөрүүтэй саналыг тусган УИХ-аар батлуулахаар бэлтгээд байна.

Энэхүү үйл ажиллагаанд ННФ эрх зүйн судалгааны Оюуны-Инноваци болон Бодлогод залуусын хяналт ТББ-уудтай хамтран нөлөөллийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулж олон нийт, тэр дундаа залуучуудын анхаарлыг шүүхийн шинэтгэлийн асуудалд хандуулах, тэдний дүү хоолойг нэмэгдүүлэх

замаар бодлогод нөлөөлөх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлж байна. Бид цар тахлын эрчимжилттэй үед дийлэнх ажлаа цахим орчинд өрнүүлж, нийгмийн сүлжээгээр дамжуулан шүүхийн тухай хуулийн дэвшилттэй заалтуудыг дэмжих шалтгаан хийгээд эргэж харах, анхаарах асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар хүргэхийг зорьж ажиллалаа. Мөн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран УИХ-ын гишүүдэд бодлогын зөвлөмж, саналаа нэгтгэн хүргээд байна.

2012 онд батлагдсан Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай 4 хуулийг нэгтгэсэн Шүүхийн тухай хууль батлагдсанаар 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт амьдралд хэрэгжихэд томоохон алхам болох юм. Хэдий тийм боловч энэхүү чухал хуулийг нэг мөр, Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу хэрэгжүүлэх нь олон талын хамтын ажиллагаа, хичээл зүтгэлийг сорьсон ажил байх болно. ННФ-ын хувьд 2021 оны үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь энэхүү сорилтыг даван туулахад чиглэсэн ажлуудад дэмжлэг үзүүлэхэд оршино.



Шүүхийн тухай хуулийн шинэчлэлийн талаар "Бодлого ярьцаага хуульчдаа!" цахим хэлэлцүүлэг, 2020 оны 1 дүгээр сар



## ШҮҮХИЙН САЛБАРЫН СУДАЛГААГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шүүхийн үйл ажиллагааны хараат бус судалгаа, шинжилгээ, үнэлгээг тогтмол явуулах нь ач холбогдолтой хэвээр байна. 2017 оноос эхлэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх төсөл зарлан уралдаант шалгаруулалтаар судлаачдад тэтгэлэг олгож, энэ хүрээнд одоогийн байдлаар 4 удаагийн эмхэтгэлээр 15 сэдвийн тайланг хэвлэн гаргаад байна. Тэрчлэн байгаль орчны холбогдолтой хэрэг маргааны шүүхийн шийдвэрийн шинжилгээг тусад нь эмхэтгэл болгон гаргалаа. 2020 онд дээрх уралдаант шалгаруулалтыг хоёр удаа зарлаж 11 сэдвийн судалгааг дэмжин тэтгэлэг олгоод байна. Түүнчлэн 2016-2017 онд МУИС-ийн ХЗС-тай хамтран хэрэгжүүлж байсан төслийн үргэлжлэл болгож УДШ-ийн тодорхой нэг шийдвэрт ШЕЗ-өөс баталсан арга зүйн хүрээнд дүн шинжилгээ хийх сонгон шалгаруулалт зарлан нийт 7 сэдвийн дүн шинжилгээг гэрээлэн гүйцэтгэлээ (Шүүхийн шийдвэрийн шинжилгээний сэдэв болон судлаачдын багийн мэдээллийг үзнэ үү.).

Цаашид энэ төрлийн судалгааны чанарыг дээшлүүлэх, арга зүйн хувьд бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх үүднээс Шүүхийн шинжилгээний редакцын зөвлөлийг байгууллаа. Эрх зүйн салбар бүрийн төлөөлөл, практикийн болон академик түршлагатай хуульч, судлаач, багш зэрэг 5 хуульчийн бүрэлдэхүүнтэй тус зөвлөл нь шүүхийн шийдвэрийн шинжилгээний төслийн шалгаруулалтаас эхлээд тайланг хянан тохиолдуулж цуврал хэвлэн нийтлэлийн бүтээгдэхүүн гаргах шийдвэрийг гаргаж ажиллах болно.

Шүүх эрх мэдлийн хүрээний судалгааны бас нэг том төсөл нь Шүүхийн индексийн судалгааны төсөл юм. Энэхүү төслийн цар хүрээг зөвлөлдөх багаар хамтран хэлэлцэж, эцэслэн тогтоох ажлыг Оюуны-Инноваци ТББ-ын судлаачидтай хамтран зохион байгууллаа. Үндэсний хэмжээний томоохон индексийн судалгаа 2021 оноос эхлэн тодорхой давтамжтайгаар хийгдэх болно.

Судалгааны үр дүнг уншигчдад хүргэх, тэдний санал шүүмжийг авах, түүнд дурдагдсан санал зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх ажил хэрэгч хэлэлцүүлгээр дамжуулан судалгаа шинжилгээний үр дүнг нэмэгдүүлэх боломжтой. Энэ зорилгын хүрээнд баруун 3 аймагт шүүгч, шүүхийн ажилтнуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж дээрх судалгаануудын үр дүнг танилцуулав. Оролцогчдын зүгээс эдгээр судалгааны асуудлаар ул суурьтай ярилцах, практикт тулгарч буй бэрхшээлийг судлаачидтай ярилцах, хууль хэрэглээний талаар санал солилцох хэрэгцээ шаардлага байгаагаа илэрхийлж байв.

Түүнчлэн шүүхэд хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаа, тэр дундаа олны анхаарал татсан хэрэг маргааныг шийдвэрлэх шүүх хуралдаанд ажиглалт мониторинг хийх арга зүй боловсруулахад чиглэсэн суурь судалгааны ажлыг судлаач Л.Галбаатар хийж гүйцэтгэв. Ингэснээр энэ төрлийн хэрэг маргааны талаарх нэгдсэн ойлголт, шүүхийн процессын ил тод байдлыг үнэлж, хэрэг маргаан түүвэрлэх обьектив шалгуурыг тодорхойлоод байна.

## СУДАЛГААНЫ БАГИЙН МЭДЭЭЛЭЛ

Судлаач	Сэдэв (2020)
1 А.Түвшинтөгс, Н.Лхамцэрэн, Д.Ганхүрэл, Э.Золзаяа	Монгол Улсад сэтгэл санааны хохирлыг нөхөн төлж буй шүүхийн практик ба онолын харьцуулсан судалгаа
2 Б.Ананд, М.Балжинсүрэн, Л.Анхбаяр	Зээлийн гэрээ цуцалснаас хойш хүү, нэмэгдүүлсэн хүү шаардсан маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн шинжилгээ
3 Б.Амарсанаа, С.Батбаяр	Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал: Иргэний ба Захиргааны хэргийн шүүхийн зөрчилдөөн
4 Хөгжлийн академи ТББ	УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуультай холбоотой хэрэг, маргааныг анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн шийдвэрүүдийн харьцуулсан шинжилгээ
5 Б.Анхзаяа	Цалин хөлстэй холбогдох маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн шинжилгээ
6 Ц.Цэлмэг	Залилан мэхлэх гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийн харьцуулсан шинжилгээ
7 Б.Хонгорзул нарын судлаачдын баг	Бага үнийн дүнтэй иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж буй практик, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам
8 Г.Буян нарын судлаачдын баг	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн төрлийг өөрчлөхтэй холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа хийх нь
9 Д.Ганхүрэл нарын судлаачдын баг	Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг бүртгүүлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг хэрэглэж буй шүүхийн практик, үр дагавар, харьцуулсан судалгаа
10 Б.Баялагмаа нарын судлаачдын баг	Шүүхэд мэдүүлэх эрхийн хэрэгжилт (Иргэний хэргийн шүүх дэх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн жишээн дээр)
11 Б.Ариунзаяа нарын судлаачдын баг	Эдийн бус хохирлыг үнэлэх зарчим, аргачлал (сэтгэл санааны хохирлоос бусад эдийн бус хохирлыг авч үзэх)

Судлаач	Улсын дээд шүүхийн шийдвэрийн шинжилгээ (2020)
1 О.Номинчимэг	Иргэний хуулийн 52-р бүлэг (Гэм хор учруулснаас үүсэх үүрэг)-т хамаарах Эмч, эмнэлгийн ажилтны буруутай үйлдлээс болж гэм хор учирсантай холбогдуулан шийдвэрлэсэн УДШ-ийн 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 001/ХТ2017/00294 дугаартай тогтоолд хийсэн шинжилгээ
2 О.Мөнхцэцэг	Эрүүгийн хуулийн 22-р бүлэг (Авлигын гэмт хэрэг)-т хамаарах УДШ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 407 дугаартай шүүхийн шийдвэрийн шинжилгээ
3 Б.Батзориг	Эрүүгийн хуулийн 22-р бүлэг (Авлигын гэмт хэрэг)-т хамаарах 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн УДШ-ийн шийдвэрт шинжилгээ хийх
4 Л.Банзрагч	Иргэний хуулийн 52-р бүлэг (Гэм хор учруулснаас үүсэх хэрэг)-т хамаарах УДШ-ийн Иргэний танхимын 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 001/ХТ2019/00076 дугаартай тогтоолд шинжилгээ хийх
5 Г.Давааням	Иргэний хуулийн гэрээний эрх чөлөөний зарчмын хүрээнд ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 582 дугаар шийдвэр болон Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 6 дугаар сарын 1077 дугаар магадлалд дүн шинжилгээ хийх
6 Г.Цагаанбаяр	Иргэний хуулийн 51 дүгээр бүлэгт (Хуулийн дагуу үүсэх үүргийн харилцаа) заасан Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотойгоор үүсэх үүргийн харилцаатай холбоотой дээд шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн дугаар 001/ХТ2020/00107 тогтоолд хийсэн шинжилгээ
7 М.Ванчигмаа	Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан ч цагаадсантай холбоотой гэм хор учирснаас үүссэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн УДШ-ийн 001/ХТ2018/00169 дугаар тогтоолд дүн шинжилгээ хийх

## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ РЕДАКЦИН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА



### Дашнямын Золжаргал (LL.M.) Өмгөөллийн DB&GTS ХХН-ийн гишүүн хуульч

Д.Золжаргал нь Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтнүүдийн нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн фирмээ байгуулж ажиллахаасаа өмнө тэрээр Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажилласан туршлагатай. Англи, Орос хэлээр чөлөөтэй харилцах чадвартай.

- 2001 онд МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн бакалаврын зэрэгтэй.
- 2004 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.
- 2018 онд АНУ-ын Харвардын их сургуулийн Хуулийн сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй дүүргэсэн.



### Сүхээгийн Билгүүн (LL.M.) ШЕЗ-ийн Тамгын газрын дарга

С.Билгүүн нь хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг. МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж, "Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь" сэдвээр, Япон Улсын Кьюсюгийн их сургуульд суралцаж "Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь" сэдвээр хууль зүйн магистрын зэрэг түс түс хамгаалсан.

Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.



### Наранчулууны Отгончимэг (LL.M.) УДШ-д судалгааны зөвлөх

Н.Отгончимэг нь Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаач бөгөөд УИХ-ын тамгын газар, Олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх хийх зэргээр мэргэжлээрээ 22 жил ажилласан туршлагатай хуульч юм.

1999 онд МУИС-ын ХЗС-ийг Магистрын зэрэгтэй, 2012 онд Лондоны *Kings college*-ийг Хууль зүйн Магистр зэрэгтэй төгссөн.

Англи, Орос хэлтэй.



### Ганчулууны Оюунболд (LL.M.), бие даасан эксперт

Г.Оюунболд нь криминологи, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн чиглэлээр мэргэшиж судалдаг практикийн болон судалгааны байгууллагад 18 жил ажилласан туршлагатай.

- 2002 онд Цагдаагийн академид эрх зүйч мэргэжлээр төгссөн.
- 2006 онд Цагдаагийн академид "Эрүүгийн байцаан шийтгэх хугацаа" сэдвээр хууль зүйн ухааны магистр зэрэг хамгаалсан.
- 2008 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Менежментийн бакалавр, мэргэжлийн англи хэлний ангид суралцан төгссөн.



### Алтангэрэлийн Бямбажаргал (S.J.D.)

МУИС-ийн ХЗС-д төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, ҮХ-ийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. ХЗС-ийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, "Эрх зүй" улирал тутмын сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг хариуцан ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг дүүргэж, БНСУ-ын Күүкминий сургуульд Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

- Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх сэдэвт сэтгүүлчдийн уулзалт
- Шүүхийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг, 4 цуврал
- Хуульчдын Холбоотой хамтарсан хэлэлцүүлэг
- Баруун аймгуудын шүүхийн шүүгч, ажилтнуудтай хийсэн хэлэлцүүлэг, Ховд, Баян-Өлгий, Увс аймаг

## СЭДВИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭН НИЙЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН: ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭ



### ЭМХЭТГЭЛ 3

Энэхүү эмхэтгэлд Засгийн газар хариуцагчаар оролцсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, Төрийн албанаас халсантай холбоо бүхий маргааныг захиргааны хэргийн шүүхүүд шийдвэрлэсэн байдал, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд хийсэн дүн шинжилгээ, Иргэний хэрэг шүүхэд хянах шийдвэрлэх ажиллагаа: Хэргийн оролцогчийн эрх ба иргэний хэрэг хойшлуулалт сэдэвт судалгааны тайланг багтаалаа (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).




### ЭМХЭТГЭЛ 4

Эмхэтгэл 4-т УДШ-ээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл, Нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээний зардал хуваарилахтай холбоотой шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалтыг шийдвэрлэсэн шүүхийн шинжилгээнүүд багтсан болно (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).




### ЭМХЭТГЭЛ 5

Эмхэтгэл 5-д байгаль орчны холбогдолтой шүүхийн шийдвэрүүдийн дүн шинжилгээг дангаар хэвлэн нийтлэв (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас харна уу).




### ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2019 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн томоохон хэсэг нь шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэсэн гурван заалт бөгөөд энэ өөрчлөлтийн хүрээнд одоо үйлчилж буй Шүүхийн тухай хууль, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг нэгтгэн Шүүхийн тухай хуулийн төсөл боловсруулаад байна. Уг хуулийн үзэл баримтлалын талаар энэ дугаарт нийтлэв (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТОМИЛГОО

ХЗДХЯ-аас Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн 7-12 дугаар бүлэгт хүчинтэй байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зохицуулалтын агуулгыг тусгажээ. “Хуулийн шүүмж”-ийн энэ дугаарт одоо үйлчилж буй хууль болон Шүүхийн тухай хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулан шинжилсэн үр дүнг хэвлэн нийтлэв (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ


Шүүхийн тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалд олон нийтийн санал авч байх үеэр уг төсөлд тусгагдсан ШЕЗ-тэй холбогдох заалтуудад харьцуулсан дүн шинжилгээ хийж санал, зөвлөмж боловсруулан энэхүү “Хуулийн шүүмж”-д хэвлэн нийтлэв. Уг шинжилгээнд ШЕЗ-ийн бүрэлдэхүүн, ШЕЗ-д тавигдах шаардлага, ШЕЗ-ийн дарга, гишүүнд нэр дэвшүүлэх журам, ШЕЗ-ийн дарга гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох асуудлыг тусгасан болно (дэлгэрэнгүйг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

## БОДЛОГЫН АСУУДЛУУД



### ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГА: ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Энэ дугаарт (i) шүүхийн ЁЗХ-ны маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд Нотлох баримт бүрдүүлэх, ЁЗХ-ны ажлын албаны эрх хэмжээ, ЁЗХ-ны гишүүний хараат бус байдал, (ii) шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцооны хүрээнд Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны зохист харьцаа ба ёс зүйн гомдлыг шийдвэрлэх үе шат, (iii) шүүгчийн хариуцлага, түүнтэй холбогдох эрх зүйн орчны хүрээнд ЁЗХ-ны эрх зүйн байдал, ЁЗХ-ны дүрмийн давхардал ба эрэмбэ зэрэг орно.



### УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Улсын дээд шүүх (УДШ)-ээс шүүн таслах үйл ажиллагаанд үл хамаарах буюу захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэх явдлыг өмнөх тогтолцоонд (1925-1990) байснаар хадгалах хандлага байгаа бөгөөд энэхүү шинжилгээгээр дээрх хууч хамаарлыг арилгаж, улмаар ардчилсан шинэ үндсэн хуулийн сүүрч үзэл баримтлалыг дагуу УДШ-ийн чиг үүргийг хуульчлах үндэслэлийг дэвшүүлсэн болно.

## ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа 2016 оноос өнөөг хүртэл хэрэгжиж байгаа бөгөөд 2020 онд өнгөрсөн хугацаанд хийгдсэн


үйл ажиллагааныхаа цаашдын тогтвортой байдлыг хангахад гол анхаарлаа хандуулж ажиллалаа.

### БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ

Монгол Улсын Засгийн газраас 2018 онд батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, тэр дундаа эрх зүйн цахим болон биет хөтчийн тогтолцоог бий болгож, үндэсний хэмжээнд нэвтрүүлэх бэлтгэлийг хангахад ННФ дэмжлэг үзүүлээ.

2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр ХЗДХЯ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хамтран ННФ-ын санхүү болон арга зүйн дэмжлэгтэйгээр [www.e-khutuch.mn](http://www.e-khutuch.mn) цахим хөтөч бүтээж нээлтээ хийлээ. Уг цахим хөтөч буюу портал сайтад иргэнд нэн түрүүн хэрэг болох 58 сэдвийн мэдээллийг хялбаршуулсан боловсруулж байрлуулсан нь хууль зүйн анхан шатны мэдээллийн цахим эх сурвалж болон ашиглагдаж эхэллээ.

Мөн ННФ-ын тэтгэлгээр Хэнтий болон Сэлэнгэ аймгуудын нийт 46 сум суурин газарт эрх зүйн хөтчийн булан байгуулагдаж, 2020 оны 8, 9 дүгээр саруудад ННФ, ХЗҮХ, холбогдох аймгуудын ЗДТГ-ын төлөөлөл бүхий мониторинг үнэлгээний баг зарим суурин газарт очиж эрх зүйн хөтчийн үйл ажиллагаатай танилцлаа. Хэдийгээр цар тахлын улмаас олны хөл хоригдож орон нутаг дахь эрх зүйн булангийн ашиглалт бага байгаа ч ашигласан иргэдийн хувьд олж авсан мэдээлэл нь тэдэнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тус нэмэр болсон, цаашид ашиглах болно гэсэн үнэлгээ өгч байсан юм. Орон нутгийн эрх зүйн хөтөч нартай нүүр тулж уулзсанаар тэдний ажлын үр нөлөөг



нэмэгдүүлэхэд ямар дэмжлэг хэрэгтэй байгааг таньж мэдэхээс гадна мөн тэдэнд шаардлагатай сургалтыг явуулав. Түүнчлэн сумын төвийн болон малчин иргэдтэй хийсэн уулзалтаар тэдэнд тулгамдаж байгаа нийтлэг асуудлыг тодорхойлж, эрх зүйн хөтчөөр дамжуулан тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх арга замыг зааж, сурталчилсан нь энэхүү мониторингийн томилолтын чухал хэсэг нь байв.

Энэхүү томилолтын явцад ажиглагдсан зүйлээс тэмдэглэхэд, орон нутгийн хувьд цахим хэрэглээний түвшин харилцан адилгүй, эмзэг бүлгийн иргэд ухаалаг төхөөрөмж хэрэглэдэггүй, малчин айлуудад интернэтийн хэрэглээ хангалтгүй байгаагаас сумын ЗДТГ-аар үйлчлүүлэх нь нийтлэг байна. Энэ нь эрх

зүйн булангийн үйлчилгээ байршлын хувьд оновчтой болсныг илтгэж байна. Мониторингийн багийн зүгээс боловсруулсан дунд шатны үнэлгээний тайланд эрх зүйн хөтчийн тогтолцоог боловсронгуй болгоход анхаарах асуудал, санал зөвлөмжийг багтаалаа.

ННФ-аас дэмжлэг үзүүлж буй уг хөтөлбөрийн хүрээнд нийт 9 аймагт 600 орчим эрх зүйн хөтөч нарыг бэлтгээд байна. Цаашид энэхүү үйл ажиллагааг өргөжүүлж 21 аймагт эрх зүйн хөтөч нарыг бүрэн сургаж бэлтгэх, жишиг аймгийн туршлага, сургамжийг бусад орон нутагт танилцуулах чиглэлээр Хууль зүйн үндэсний хүрээлэн болон аймгуудын ЗДТГ-т арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах болно.



ННФ, ХЗҮХ-гийн хамтарсан мониторингийн үнэлгээний баг Хэнтий, Сэлэнгэ аймгуудын зарим сумын иргэд, эрх зүйн хөтөч нартай уулзсан нь, 2020 оны 8, 9 дүгээр сар

## ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх үндэсний тогтолцооны нэг чухал зорилт нь алслагдмал, эмзэг бүлгийн иргэдэд шаардлагатай хууль зүйн мэдээлэл, туслалцаа нь бусдын адил тэгш боломжтойгоор хүрэх явдал юм. Өнгөрсөн 30 гаруй жилийн олон улсын туршлагаас харахад тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалж, тэдний дунд үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан энэхүү үйлчилгээ, туслалцааг хүргэх нь үр дүнтэй, хүртээмжтэй байдаг нь харагдаж байна. Иймээс бид 2018-2019 онд эмзэг бүлгүүдтэй ажилладаг байгууллагуудад иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж буй олон улсын сайн туршлагыг танилцуулах зорилгоор 2 удаа сургалт хийсэн юм. 2020 онд сургалтыг

гуравдах удаагаа зохион байгуулж нийт 28 ТББ-ын төлөөллийг хамрууллаа. Сургалтад баруун бүсийн 8 байгууллагын төлөөлөл оролцлоо.

Энэхүү сургалтад өнгөрсөн 2 жилд эрх зүйн хөтчийн хөтөлбөр хэрэгжүүлсэн 7 байгууллага туршлага, ойлголтоо хуваалцсанаараа онцлогтой байлаа. ИНБ-тай ажиллах хамтын ажиллагааны гол хэлбэр нь сургалтад оролцож тодорхой ойлголт авсан байгууллагуудын дунд эрх зүйн хөтчийн хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн уралдаан зарлаж, шалгарсан байгууллагатай бүтэн жил хамтран ажиллах санхүүгийн тэтгэлэг болон арга зүйн туслалцаа үзүүлж, дэмжих явдал юм. 2020 онд дараах гурван байгууллага шинээр эрх зүйн хөтчийн хөтөлбөр эхлүүлэхээр болоод байна.

1	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо	Орон нутгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр, бизнес эрхлэхтэй холбоотой асуудлаар мэргэшсэн эрх зүйн хөтөч нар ажиллуулах
2	Гэрэлт Ирээдүй эвсэл	Баян-Өлгий аймаг дахь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийн гишүүдийг эрх зүйн хөтчөөр бэлтгэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах
3	Тува эмэгтэйчүүдийн Авам холбоо	Баян-Өлгий аймгийн тува иргэдийн дунд эрх зүйн хөтөч бэлтгэж тулгамдаж байгаа асуудлаа шийдэхэд нь шаардлагатай хуулийн мэдээлэл, зөвлөгөө өгөх

Цар тахлын үед ТББ-уудын төлөвлөгөөнд өөрчлөлт орох, хугацаа сунжрах зэрэг бэрхшээл гарахын зэрэгцээ хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа улам бататгах, үрт хугацаанд тогтвортой ажиллахад нь хөшүүрэг хэрэгтэй гэсэн үндэслэлээр Монголын Эмнести Интернэшнл, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хүүхдийн оюуны боловсролыг дэмжих төв, Хөөрхөн зүрхнүүд зэрэг ТББ-уудын тэтгэлгийг сунгаж 2021 онд үргэлжлүүлэн хамтарч ажиллахаар боллоо.

Эрх зүйн хөтчийн үндэсний тогтолцоо нь төрийн болон төрийн бус байгууллагын эрх зүйн бүх хөтөч нарыг хамарч, нэгдсэн тогтолцоо болж хөгжих нь чухал юм. Иймээс ХЗҮХ-ийн зүгээс иргэний нийгмийн 8 байгууллагыг төлөөлөн уг хөтөлбөрт хамрагдах 165 хүнийг эрх зүйн хөтчийн нэгдсэн бүртгэлд бүртгэж батламж олгохоор болсон. Энэ нь "Иргэний нийгмийн эрх зүйн хөтөч" хөтөлбөрийг цаашид олон талаар дэмжиж хамтран ажиллах үүд хаалгыг нээсэн гэж найдаж байна.

### ЭНЭ СЭДВИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭ

1. ХЗДХЯ, ХЗҮХ-тэй хамтран зохион байгуулсан эрх зүйн цахим хөтчийн нээлт, 2020 оны 1 дүгээр сар
2. ИНБ-ынханд зориулсан иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх сургалт, 2020 оны 10 дугаар сар
3. Хэнтий, Сэлэнгэ аймгууд дахь Эрх зүйн хөтчийн үйл ажиллагаатай танилцах уулзалтууд, 2020 оны 8, 9 дүгээр сар
4. Ховд, Баян-Өлгий, Увс аймагт ИНБ-уудад зориулсан мэдээлэл өгөх семинар 2020 оны 9 дүгээр сар



# ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧ" ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС



Иргэдийн эрх зүйн чадавгыг дээшлүүлэх сэдэвт сургалт семинар, 2020 оны 10 дугаар сарын 22-23



Хэнтий, Сэлэнгэ аймгийн сумдад байгуулсан Эрх зүйн хөтчийн булан



# БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

## ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

ННФ нь 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр бүрдэж буй эрх зүйн орчныг бэхжүүлэх, тодорхой орон нутагт бий болж байгаа хэрэгжилтийн түвшний туршлагыг баримтжуулан түгээн дэлгэрүүлэхэд үргэлжлүүлэн анхаарч ажиллав. Энэ хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны туршлагыг гүнзгийрүүлж, судалгаанд суурилсан нөлөөллийн чадавхыг бэхжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах

чиглэлд төр захиргааны байгууллагатай шууд хамтран ажиллахын зэрэгцээ мөн багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Үүний зэрэгцээ тэгш хамруулах боловсролын асуудлыг хөгжлийн бэрхшээлээр хязгаарлахгүй, боловсролын үйлчилгээний гадна үлдэх эрсдэлтэй нийгмийн бусад бүлэгт чиглүүлэх зорилгыг дэвшүүлэн ажиллалаа.

## БОДЛОГЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ОРОЛЦОО, НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

2020 онд боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажил эрчимтэй өрнөсөн бөгөөд үүнд иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцлоо. БШУЯ-аас манлайлан Боловсролын багц хуулийг шинэчлэх өргөн хүрээтэй ажилд иргэний нийгмийн судлаач, эцэг эхчүүд идэвхтэй оролцож байгаа бөгөөд энэ оролцоог мэдлэг, мэдээллээр дэмжих, олон талын саналыг сонсох зорилгоор Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ нь цуврал цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг нэгтгэн хуулийн шинэчилсэн төслийг боловсруулж буй Ажлын хэсэгт хүргүүлэн ажиллаж байна. Цуврал хэлэлцүүлэг нь иргэний нийгмийнхэн, гадаад дотоодын их дээд сургуулийн эрдэмтэн судлаач, оюутан, эцэг эхчүүдэд мэдлэг солилцох, хамтран суралцах, марган мэтгэлцэх талбар болж байна. Энэхүү хэлэлцүүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдийн сурч боловсрох тэгш эрхийн талаар оролцогчид ойлголтоо нэгтгэх, ялгаатай байр сууриа харилцан хүндэтгэлтэй сонсож ярилцах, дуу хоолойгоо бодлого боловсруулагчдад хүргэх орон зай болж, хууль боловсруулахад олон талыг оролцуулан, тэдний илэрхийлсэн саналыг нэгтгэн хүргэх нэг суваг болж байна. Хэлэлцүүлгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Түгээмэл хөгжил төвөөс зохион байгууллаа.

Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ энэ онд хөгжлийн бэрхшээлтэй сурагчид ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах журмуудыг боловсруулахад оролцов. БШУЯ-аас байгуулсан “Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх

журам” боловсруулах Ажлын хэсэгт Сүлжээний төлөөлөл орж ажиллахын зэрэгцээ Сүлжээний гишүүн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг, семинарууд зохион байгуулж санал авах ажлыг хэрэгжүүлэв. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог хангах тухайлсан буюу ганцаарчилсан дэмжлэгийн тогтолцоог *тохирох хэрэглэгдэхүүн* гэсэн нэр томъёогоор 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд албан ёсоор суулгаж, тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүй байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчил гэж үзнэ хэмээн тодорхойлсон. Тохирох хэрэглэгдэхүүн, тохируулгыг төрийн болон хувийн салбарын үйлчилгээ, нийтийн гудамж талбайд нэвтрүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай орчин, арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагагүй болж, тэд нийтийн үйлчилгээ, зай талбайг ашиглан, нийтийн арга хэмжээнд бусдын хамтаар оролцох боломж бүрддэг.

Монголд шинэ тутам бүрэлдэж буй энэхүү ойлголт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог дэмжих материаллаг орчин, тоног төхөөрөмжөөс гадна программ хангамж, нэмэлт болон дэмжих үйлчилгээ, мөн бараа, үйлчилгээний зохион байгуулалтыг хөгжлийн

бэрхшээлтэй хүний оролцоог дэмжсэн байдлаар өөрчлөн тохируулахыг багтаана. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, тэгш оролцоог дэмжсэн чухал өөрчлөлт, хандлагыг төлөвшүүлэхэд боловсролын салбар манлайлж байгаа бөгөөд үүнд иргэний нийгмийн дээрх Сүлжээний байгууллагууд, их дээд сургуулийн багш нар хувь нэмрээ харамгүй оруулж, хамтран ажиллаж байна.

2020 онд ННФ нь тэгш хамруулах сургах боловсролын асуудлыг өргөн хүрээгээр харж, хөгжлийн бэрхшээлээс бусад шалтгаанаар албан боловсролын гадна үлдэх эрсдэлтэй бүлгийн хүүхэд, залуучуудын асуудлыг бодлого боловсруулагчдад хүргэх зорилго дэвшүүлэн ажиллав. Энэ зорилгоор “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн эвсэлтэй хамтран бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр эхлүүлээд байна. Хөтөлбөрт хамрагдаж байгаа 5 судлаач нь хөгжлийн бэрхшээл, хэлний цөөнх, жендерт суурилсан хүчирхийлэл, ядуурал, хүртээмжгүй амьдрах орчин зэрэг хүчин зүйлс боловсролын оролцоо, хүртээмжийг хязгаарлаж байгааг хэрхэн бодлогоор засаж сайжруулах асуудлыг судлан, бодлогын зөвлөмж боловсруулах юм.

## БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖСЭН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ нь байгуулагдсан цагаасаа гишүүн байгууллагуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхүйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж ирсэн. 2020 онд цар тахлын эрсдэлийн улмаас цугларалт, сургалт,

семинар зохион байгуулах боломж хумигдсан тул хэвлэмэл ном, гарын авлагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих ажлаа үргэлжлүүлэв. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх

тэгш байдал, эрх зүйн хамгаалалтыг тайлбарлан таниулсан сүүлийн үеийн мэдлэг, сургалтын материалуудыг нэгтгэн шүүж, системчлэн зохион байгуулан, шаардлагатай зарим агуулгыг шинээр боловсруулж, Сүлжээ нь “Хөгжлийн бэрхшээл ба хүний эрх” гарын авлагыг гаргалаа. Хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн хандлага, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын болон дотоодын эрх зүйн орчин, сурч боловсрох эрх гэсэн бие даасан 3 модуль бүхий уг сургалтын хөтөлбөр нь иргэний нийгэм, их дээд сургууль, төрийн байгууллага сургалтад ашиглах боломжтой эх сурвалж юм. Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх бодит туршлага ЕБС-ийн удирдлага, багш нарт дутагдаж байгааг тодорхой хэмжээнд нөхөх зорилгоор Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага, Монгол Улсын БСШУСЯ (хуучин нэрээр), ХНХЯ-ны хамтарсан төсөлд хамрагдан гадаад, дотоодын мэргэжилтнүүдийн зөвлөгөө, дэмжлэгтэйгээр 2015-2018 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамруулан сургах төсөл амжилттай хэрэгжүүлсэн Хөвсгөл аймагт энэхүү бодлогын хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж буйг тодорхой харуулсан гарын авлага гаргалаа. Энэхүү гарын авлагыг Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооноос ННФ-ын арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулан гаргав.

Тэгш хамруулан сургах бодлогын орчин эрчимтэй шинэчлэгдэж, багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо нь сургууль, багш нарт шаардлагатай мэдлэг, үр чадварыг эзэмшүүлэх туршлага, хөтөлбөр бий болгож байна. Иргэний нийгмийн байгууллагууд ч мөн бодлогын хэрэгжилтийг дэмжин, шууд аваад хэрэглэж болох системтэй мэдлэг, мэдээллийг сургууль, багш нарт хүргэхээр ажиллаж байна. Монголын Аутизмын холбоо нь ЕБС-д жирийн ангид аутизмтай хүүхдийг үр дүнтэй сургах Австрали

Улсын сайтар түршигдсэн сургалтын хөтөлбөр (*curriculum*)-т түшиглэн монгол хувилбарыг боловсруулан, ганцаарчилсан боловсролын төлөвлөгөөтэй уялдуулан ашиглах зааварчилгаа бүхий багшийн гарын авлагын хамтаар хэвлэн гаргаад байна. Уг жишиг хөтөлбөрийг аутизмтай хүүхэдтэй ажиллаж байгаа бага ангийн 4 багш түршиж, сайжруулах бөгөөд үүний дараа бусад багш нарт сургалт, зөвлөгөөний хамтаар хүргэх, цаашилбал багш бэлтгэх хөтөлбөрийн тэгш хамруулан сургах хичээлийн агуулгад тусгах зорилт дэвшүүлэн Монголын аутизмын холбооны сайн дурынхны баг ажиллаж байна. Хараагүй хүүхдийг тэгш хамруулан сургахад урьдчилсан бэлтгэл хангах шаардлагатай бөгөөд Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо нь бага ангийн багшийг брайль үсэг болон брайль заах арга зүйд сургах, хараагүй хүнтэй харилцах соёл төлөвшүүлэх, хараагүй хүүхдийг бичиг үсэг, тоо бодоход сургах арга зэрэг чиглэлээр сургалтын агуулга боловсруулав. Хараагүй хүн барилга, байгууламжийн дотоод болон гадаад орчин, зохион байгуулалтыг тогтоох шаардлагатай тул хараагүй хүүхдэд орон зайн баримжаа олгох жишиг хөтөлбөрийг уг байгууллага боловсруулан, хүртээмжтэй орчны зөвлөмжийн хамтаар ЕБС-иудад хүргэж байна.

2019 оноос нягт түншлэн ажиллаж байгаа Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) 2020 онд ННФ-ын тэтгэлгээр “Тэгш хамруулан сургахад багшид туслах арга зүйн гарын авлага” боловсруулж Улаанбаатар хот, 21 аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраар дамжуулан ЕБС бүрт хүргэлээ. БМДИ-ийн төслийн баг нь өөрийн байгууллагын вэбсайт болон пэйж хуудсаар дамжуулан гарын авлагын тухай мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллан, сайн туршлага бий болгож байна. Хамтарсан уг төслийн хүрээнд БМДИ нь үндэсний хэмжээнд тэгш хамруулах боловсролын хэрэгжилтийг судлах зорилгоор 6 чиглэл 45 асуулт бүхий судалгааны асуулга

бэлтгэн туршаад, бүх сургуулиас судалгаа авах ажлыг зохион байгуулж байна. Үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын нөхцөл байдлыг бүхэлд нь зураглан харуулах ач холбогдол бүхий уг судалгааны үр дүн 2021 оны эхээр гарна.

Тэгш хамруулах боловсролын чиглэлд ННФ нь багш бэлтгэх хамгийн том үндэсний их сургууль болох МУБИС-тай хамтран урт хугацааны хоёр төслийг амжилттай хэрэгжүүлж байна. МУБИС-ийн янз бүрийн тэнхимийн дидактикийн багш нар багаар ажиллан, оюутнуудад хичээл төлөвлөлт, сургалтын явцад олон янзын сургах аргыг хослуулан ашиглах мэргэжлийн мэдлэг, итгэл үнэмшлийг төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Уг төслийн хүрээнд дидактикийн 30 багш сурагчдын ялгаатай байдлыг харгалзсан хичээл төлөвлөлт, танхимын менежментийн үзэл баримтлалыг боловсруулж, үүндээ нийцүүлэн дидактикийн хичээлийн агуулгыг боловсруулан оюутнуудтай хамтран туршиж, бий болсон туршлагаа МУБИС-ийн хэмжээнд багш нартай семинар, бага хурлаар дамжуулан хуваалцаж байна. Багийн ажлын үр дүнд онол, арга зүйн гарын авлага, хичээл бүрээр ажиглалтын хуудас, англи хэлнээс орчуулсан эх сурвалж зэрэг материал гараад байна. Уг төслийн хүрээнд “Хүүхэд бүрийн өвөрмөц байдлыг харгалзсан сургалтын арга зүй”, “Суралцагч бүрийн суралцахуйг дэмжсэн танхимын менежментийн

арга зүй” зэрэг гарын авлага, орчуулсан унших материал, хичээл төлөвлөлт, хичээлийн явцад үнэлгээ хийх, сурагчдын зан үйл, сурах арга барилыг үнэлэх ажлын хуудас зэрэг нэмэлт хэрэглэгдэхүүн боловсруулан хэвлэн тараахын зэрэгцээ цахимаар байршуулан, орон даяар ажиллаж, сурч байгаа багш, оюутнуудад хүргэхийг зорьж байна. Эдгээр эх сурвалжийг МУБИС-ын вэб сайт, нийгмийн сүлжээн дэх хуудас, зайн сургалтын цахим хуудаснаас үзэж болно. Хичээл, сургалтын үйл явцыг уян хатан болгох замаар хүүхэд бүрт хүрч ажиллах арга хандлага, мэдлэгийг багшийн мэргэжлийн үр чадвар болгож төлөвшүүлэх энэхүү агуулгыг МУБИС-ийн сургалтын хөтөлбөрт албан ёсоор нэвтрүүлэх ажил хүлээгдэж байна.

МУБИС-ийн Боловсрол судлалын сургууль нь ННФ-ын дэмжлэгээр тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээт боловсролын хичээлийн агуулга, арга зүйг сайжруулах төсөл хэрэгжүүлж байна. 2020 онд тус сургуулийн Тусгай хэрэгцээт боловсрол, Сэтгэл судлал, Нийгмийн ажлын тэнхимийн багш нар тэгш хамруулах боловсролын асуудлаар олон улсын туршлага, дотоодын эрх зүйн орчныг судалж, оюутан, багш нарт зориулсан номын сангийн бүрдүүлэл хийж дууссан бөгөөд одоо 3 кредитийн сонгон судлах хичээлийн агуулгыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.

## СЭДВИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН



### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ ЭРХ

Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хэрэгжилтийг хянахад хэрхэн оролцох талаарх мэдээллийг энэ гарын авлагад багтаажээ. Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн байр сууринаас ойлгох нь, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин, Сурч боловсрох эрх гэсэн сургалтын 3 модулиар оролцооны хэлбэрүүдийг сонирхолтойгоор танилцуулсан байна.



### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮРШЛАГАД СУУРИЛСАН ГАРЫН АВЛАГА

Шинээр бүрдсэн тэгш хамруулах боловсролын тогтолцоог хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргааны манлайлал, аймгийн болон сургуулийн түвшний зохион байгуулалт, үйл ажиллагааг шат, алхам бүрээр нь танилцуулсан Хөвсгөл аймгийн түршлагыг уг гарын авлагад оруулжээ. Тэрчлэн боловсруулан ашиглаж байгаа баримт бичиг, маягт, хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын тэмдэглэл зэргийг жишээ болгон харуулжээ.

## НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ТЭТГЭЛГЭЭР ТҮНШ БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН БҮТЭЭГДЭХҮҮН

1. “Тэгш хамруулан сургах багшид туслах арга зүй” түршлагын эмхэтгэл (БМДИ)
2. “Хүүхэд бүрийн өвөрмөц байдлыг харгалзсан дифференциал сургалтын арга зүй” эх сурвалж материал (МУБИС)
3. “Суралцахуйг дэмжсэн танхимын менежментийн арга зүй” эх сурвалж материал (МУБИС)

## ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

ННФ нь үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлогын орчныг бий болгоход хувь нэмэр оруулахыг зорьж энэхүү хөтөлбөрийг 7 жилийн турш хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд сургууль, орон нутагт түшиглэн энэ төрлийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх чиглэлд түлхүү анхаарч ажиллалаа. Нийгмийн үйлчилгээний салбарт мэргэжилтний мэдлэг, чадварыг богино хугацаанд бүрдүүлэх зорилгоор нийгмийн үйлчилгээний мэргэжилтэн бэлддэг их дээд сургуулиудад сургалт, судалгааны хөтөлбөртөө шинэ хичээл, сэдэв тусгахад нь дэмжлэг үзүүлэх стратегийг баримтлан ажиллав. Өнгөрсөн хугацаанд АШУҮИС, ШУТИС, МУБИС-ийн нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн бакалавр, магистрын сургалтын хөтөлбөрт үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгад төвлөрсөн 2-3 кредитийн хичээл бий болж, Дотоод хэргийн их сургуулийн хөтөлбөрийн шинэчлэл эхэлсэн бөгөөд 3 сурах бичиг, дипломын болон магистрын түвшний судалгааны 23 ажил, эрдэм шинжилгээний 52 өгүүлэл, нийтлэл гарчээ. 2019 оноос үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгыг бакалаврын хөтөлбөрөөр судалсан сургууль, хороо, эмнэлгийн нийгмийн ажилтнууд төгсөн гарч байна.

2020 онд бид өмнөх жилүүдэд бий болгосон мэргэжлийн мэдлэг, чадавхыг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллалаа.

Мэргэжилтэн бэлтгэх түвшний сургалт, судалгааны хөтөлбөр хөгжүүлэн, хэрэгжүүлэх мэдлэг, туршлагыг орон нутгийн их дээд сургууль, коллежуудад дамжуулах төслийг Нийгмийн ажлын багш, сургагчдын холбоо ТББ-тай хамтран эхлүүллээ. Орон нутагт нийгмийн ажилтан, цэцэрлэг болон бага ангийн багш бэлтгэж байгаа их сургуулийн сургалтын хөтөлбөрт үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх 2-3 кредит цагийн хичээл бий болгох төсөлд өөрийн болон хил залгаа аймгуудыг төрийн захиргаа, төрийн үйлчилгээний хүний нөөцөөр хангадаг Ховд их сургууль, түүний Баян-Өлгий аймаг дахь салбар, Дорнод их сургууль, Архангай аймаг дахь МУБИС-ийн харьяа Багшийн коллеж оролцож байна. Нийгмийн ажлын багш, сургагчдын холбооны чиглүүлэг, дэмжлэгтэйгээр орон нутгийн их сургууль, коллежийн багш нараас бүрдсэн 4 баг өөрийн орон нутаг дахь нөхцөл байдлыг судлан тус тусын сургуулийн сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийж байна.

### ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТ, ХҮЧИРХИЙЛЭЛ

Үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл нь үеийн залуучууд нэг дор байдаг газарт их гардаг бөгөөд асуудал, зөрчлийг шийдэх зорилгогүй, харин илүү байгаагаа мэдрүүлэх сэдэлтэй, бие махбод, сэтгэл санааны, заримдаа бэлгийн түрэмгийлэл юм. Сургууль, дотуур байр, цэргийн анги, зуны зуслан, спорт клуб зэрэг газар үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл гарах өндөр эрсдэлтэй ба оршин суугаа

орон нутагт ч мөн гардаг байна. Танихгүй хүмүүсийн хооронд гарах нь бага, голдуу сайн танил хүүхэд, залуусын хооронд тодорхой хугацаагаар тасралтгүй үргэлжилдэг үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл нь эрх мэдлээ тогтоох гэсэн сэдэл, зорилгоороо гэр бүлийн хүчирхийлэлтэй төстэй ч үе тэнгийн бусад хүүхэд, залуусын нүдэн дээр, гэрчтэй үйлдэгддэг онцлогтой.

Анхдагч урьдчилан сэргийлэлт нь дээрэлхэлт, хүчирхийлэл гарахаас сэргийлэх зорилготой, нийт хүн амд чиглэсэн бодлого бөгөөд хүчирхийлэл үйлдэхэд хүргэдэг эрсдэлт хүчин зүйлсийг багасгах, хүчирхийлэл үйлдэхээс хамгаалдаг хүчин зүйлсийг бэхжүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалтын үйл ажиллагаа хэлбэрээр хэрэгждэг. Голдуу сургууль, олон нийтийн хэвлэл мэдээллийн суваг зэрэг хувь хүн, нийтэд хүртээмжтэй сувгаар дээрэлхэлт, хүчирхийллийг таньж мэдэх мэдлэг өгөх, хүчирхийллээс татгалзах үнэт зүйл төлөвшүүлэх, нийгмийн харилцааны үр чадвар хөгжүүлэх, эрсдэлт нөхцөлд дэмжлэг авах зэрэг мэдээллийг хүргэх замаар хэрэгждэг.

Хоёрдогч урьдчилан сэргийлэлтэд бүрдээд байгаа нөхцөл байдал даамжран дээрэлхэлт, хүчирхийлэл болохоос сэргийлэх зорилготой бөгөөд үүнд цагдаа, хүүхдийн байгууллага, орон нутгаас эрсдэлт бүлгийн залуучуудын зан үйл, амьдралыг үзэх үзлийг өөрчлөх зорилгоор хэрэгжүүлдэг зорилтот хөтөлбөр, хяналт багтана.

Гуравдагч урьдчилан сэргийлэлтэд дээрэлхэлт, хүчирхийлэл давтагдахаас сэргийлэх зорилготой бөгөөд үүнд жишээлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагаас хэрэгжүүлэх хүчирхийлэл үйлдсэн хүнийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх хөтөлбөр, мөн бусад байгууллагаас хэрэгжүүлэх халамж, дэмжлэг багтана.

Цаашид багш нар сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийн зэрэгцээ орон нутагтаа хүчирхийллийг урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлж аймаг, сум, сургууль, багийн түвшний хөтөлбөр, үйл ажиллагаанд үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилт тусгах чиглэлээр нөлөөлөл хийн,

хэрэгжилтээ төлөвлөн, зохион байгуулахад мэдлэг, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах юм.

2020 онд Дотоод хэргийн их сургууль нь бакалаврын сургалтын хөтөлбөрт тусгах хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн агуулгыг тодорхойлж, хичээлийн төлөвлөгөө боловсруулан, 11 сараас бакалаврын оюутнуудад түршилтаар зааж эхлэв.



Түршилтын хөтөлбөрт хамрагдсан 10 сургуулийн багш нар өөрсдийн сургуульдаа түршин хэрэгжүүлсэн ололт, сургамжаа бусадтайгаа хуваалцаж байгаа нь, 23, 65-р сургуулийн сургагч багш нар.





Үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг дунд сургуульд түршин хэрэгжүүлэхэд нийслэлийн 10 сургуулийн ахлах ангийн багш нар оролцож сургагч багшаар бэлтгэгдлээ. Уг сургалтад МУБИС-ийн НААЗТ-ийн ахлах багш М.Нямдорж дээрэлхэлтийн талаарх үндсэн ойлголтыг танилцуулав.

КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хатуу хөл хорионы үеэр иргэдэд хяналт тавих ажилд сонсогч, багш нар дайчлагдан ажиллаж байгаагийн улмаас түршилтын хичээл тасалдах явдал гарч байгаа тул 2021 оны хаврын улиралд түршилтыг давтах хэрэгцээ гарах магадлалтай байна.

АШУУИС, ШУТИС, МУБИС нь 2016 оноос залуучуудын дундах дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгыг боловсруулан хэрэгжүүлж байгаа тул агуулгад үнэлгээ хийж, шинээр бүрдэж байгаа мэдлэг, арга зүйг тусгах шаардлага байгаа эсэхийг тодорхойлоход хангалттай хугацаа өнгөрсөн. Иймээс АШУУИС, ШУТИС-ийн хамтарсан баг байгуулагдаж, ННФ-ын түнш 4 их сургуулийн багш, оюутан, төгсөгч, практик ажилтнуудыг хамруулсан асуулга, ганцаарчилсан ярилцлага, мөн баримтын судалгаа зэрэг арга зүйг ашиглан хөтөлбөрийн үнэлгээг хийж гүйцэтгэв. Үнэлгээгээр нийгмийн ажилтан бэлтгэх хөтөлбөрт залуучуудын дундах хүчирхийлэл, тэр дундаа үе тэнгийнхний дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох мэргэжлийн чадавхыг бий болгох суурь тавигдсан



Түршилтын хөтөлбөрт оролцсон сургагч багш нар багаар ажиллан хийнгээ суралцаж, өөрийн сургуулийн бусад багш нарт мөн сургалт хийв, 35, 88, 60-р сургуулийн сургагч багш нар

бөгөөд одоо сургуулиуд энэхүү үр дүнг тогтворжуулж, холбогдох бүр мэргэжилтний заавал судлах хичээл болгох, магистр болон докторын сургалтад нэвтрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байгааг онцолжээ. Одоо сургалтын хөтөлбөрийн чанарт анхаарч, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх үр чадвар олгох, практик дээр шүүд хэрэгжүүлж болох сайн түршлагыг мэргэжилтнүүдэд эзэмшүүлэхэд чиглэсэн агуулгыг нэмэх шаардлага байгаа ажээ. Уг баг нь сургууль болгоны хичээлийн агуулгыг сайжруулах зөвлөмж боловсруулж, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн сайжруулахад зөвлөж ажиллах юм.

2020 онд Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ нь ЕБС-ийн Монгол хэл, Иргэний ёс зүй, Нийгэм судлал хичээлийн хөтөлбөр, сурах бичгийн агуулгад сэдэвчилсэн шинжилгээ хийж, үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх агуулгын интеграцчиллыг боловсруулах ажлыг удирдан хэрэгжүүллээ. Уг 3 хичээлийн анги тус бүрийн агуулгаас 3 сэдэв сонгож, одоо байгаа сэдэв, агуулгын хүрээнд үе тэнгийн дээрэлхэлтийг



ДХИС-ийн Бакалавр, магистр болон цагдаа бэлтгэх түр сургалтын хөтөлбөр дэх хүүхэд залуучуудын дундах хэрэг зөрчил, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгыг сайжруулах төслийн багийн үулзалт

урьдчилан сэргийлэхэд чиглэсэн амьдрах ухааны ур чадварын агуулгыг нэмж боловсруулан арга зүйн зөвлөмж, хичээлийн жишиг төлөвлөгөөний хамтаар багш нарт хүргэхээр бэлтгээд байна. 2020 онд уг төслийн хүрээнд 105 хичээлийн төлөвлөгөө, арга зүйн зөвлөмж боловсруулахдаа анги дэвших тутам агуулга гүнзгийрч байх арга хандлагаар үр дүнгийн үялдаа холбоог хангахад анхаарчээ. Төслийн багийн бүрэлдэхүүнд ЕБС-ийн багш, нийслэл болон дүүргийн Боловсролын газар, хэлтсийн мэргэжилтэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн мэргэжилтэн, сурах бичиг зохиогчдыг багтааж, боловсруулсан хичээлүүдээ нийслэлийн гурван ЕБС дээр туршин эцэслээд байна. Уг агуулгыг багш нарт хүргэх, арга зүйг тайлбарлах ажлыг БХАН нь Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

ННФ нь өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа их дээд сургууль, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжин харилцах суралцах, мэдээлэл солилцох ажлыг мөн зохион байгуулжирлээ. Сар бүр тодорхой асуудлаар семинар, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөсөн ч КОВИД-19-ийн улмаас тогтмол хэрэгжүүлж чадаагүй юм. 2020 онд сургалтын хөтөлбөрүүдийн үнэлгээг хэлэлцүүлэх, ДХИС-ийн сургалтын хөтөлбөрт шүүмж өгөх, ЕБС-ийн нийгмийн ухааны хичээлүүдийн агуулгад хийсэн шинжилгээг хэлэлцэх, сургалт семинар хийх зэрэг зорилгоор 4 арга хэмжээ зохион байгууллаа. 11 сард хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн үе тэнгийн дээрэлхэлтийн талаар мэдлэг бий болгох аян, багш, оюутны эрдэм шинжилгээний хурал нь цар тахлаас сэргийлэх хөл хорионы улмаас хэрэгжээгүй болно.

### 2020 ОНЫ 10 ДУГААР САРД ХИЙСЭН СУРГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь гудамжны хүүхэд, өнчин хүүхэд зэрэг тодорхой эрсдэлт бүлэг, эсвэл хүүхдийн хөдөлмөр, хүний наймаа зэрэг тодорхой асуудалд төвлөрч, хүчирхийлэл, мөлжлөг, зүй бус харьцаа гарах хамгийн их эрсдэлтэй нөхцөлд

анхаарлаа хандуулж ирсэн. Улмаар хүүхэд хамгааллын тодорхой асуудлыг салган авч үзэх хандлага ерөнхийдөө давамгайлж, урьдчилан сэргийлэх ажил орхигдоход хүрдэг.

## НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ТЭТГЭЛГЭЭР ТҮНШ БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН БҮТЭЭГДЭХҮҮН

1. НЭМС, ШУТИС, МУБИС, БХИС-ийн бакалаврын хөтөлбөрт оруулсан үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хичээлийн агуулга, чанарыг үнэлгээний тайлан, шинэчилсэн сурах бичиг (2021 онд хэвлэгдэх)
2. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хариуцан ажиллаж буй Залуучуудын хөгжлийн 32 төвийн мэргэжилтний чиг үүргийн шинжилгээ, түүнд суурилсан Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх санал зөвлөмж
3. Youth violence prevention methodology in the undergraduate social work program in Mongolia илтгэл (Москва хотод 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулагдах олон улсын нийгмийн ажлын хуралд хэлэлцүүлэх)
4. “Нийгмийн ажилтан бэлтгэх боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн асуудалд: Өсвөр насныхны дундах дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлын жишээн дээр” өгүүлэл (“Нийгмийн хөгжил: Асуудал, шийдэл” сэтгүүлд нийтлэдсэн)
5. “КОВИД-19-ийн цар тахлын үеийн хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагааны түршлага” тойм тайлан
6. “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх стратеги, арга ажиллагааны олон улсын INSPIRE аргачлал” тойм тайлан



# ЦАР ТАХЛЫН ХАРИУ ҮЙЛДЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 халдварын тархалтын үед Монгол Улс хүн амынхаа эрүүл мэндээс гадна нийгэм, эдийн засгаа хохирол багатай авч гарахын тулд Засгийн газрын зүгээс тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсээр ирлээ. Хэдий тийм боловч онцгой нөхцөл байдлын амаргүй энэ үед хүн амын нийгмийн үйлчилгээ авах эрх хязгаарлагдах, хууль сахиулах ажиллагаатай холбогдсон иргэдийн гомдол нэмэгдэх, хүүхдийн эрх зөрчигдөх, гэр бүлийн хүчирхийлэл өсөж далд хэлбэрт шилжих, тэрчлэн төсвийн нөөцийг зүй бусаар зарцуулсан байж болзошгүй зэрэг зөрчил доголдол цөөнгүй гарлаа. Үүнтэй холбогдуулан бидний зүгээс тодорхой хэмжээний хөрөнгө нөөцийг цар тахлын хариу үйлдэлд чиглэсэн үйл ажиллагаанд судалгаа, мониторинг хийж бодлого боловсруулагчид, төрийн болон иргэний нийгмийн ажилтнууд, олон нийтийг бодит мэдээллээр хангахад тус нэмэр оруулахыг зорилоо Тэрчлэн дохионы хэлний онлайн хичээлийн тасралтгүй байдлыг хангах болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй зарим байгууллага, мөн баривчлах байрны сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэг ажилд дэмжлэг үзүүлэхэд зарцууллаа.

## КОВИД-19 БА ХҮНИЙ ЭРХ

Хатуу хөл хорионы дэглэмийн үеэр хүний эрхийг хязгаарлах, зөрчих цөөнгүй тохиолдол бүртгэгдэж байгаа тул үүнд шуурхай хариу үзүүлэх, шаардлагатай тохиолдолд нөлөөллийн ажил хийх шаардлагатай байв. Тиймээс “Хөл хорио Монголд”, “Хөл хорио ба Гадаад дахь монгол иргэд” сэдвээр судалгааны ажлууд хийн үр дүнг бодлого боловсруулагчид болон олон нийтэд цаг тухайд нь хүргэж ирлээ. Үүний дүнд чөлөөтэй зорчих эрхийн талаар олон улсын хүний эрхийн эрх зүй болон Үндсэн хуулийн хүрээнд дэлгэрүүлэн судалсан шинэ эх сурвалж нэмэгдэж, иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдлэгт мөн тус нэмэр болов.

Тэрчлэн Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа зарим үйл ажиллагаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, тайван замаар жагсаал, цуглаан зохион байгуулах, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх эрхэд

## КОВИД-19 БА ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА

Хөл хорионы дэглэм сахиулахтай холбогдон иргэд, цагдаагийн алба хаагчдын хооронд багагүй зөрчил үүсэж байв. Иймд хууль сахиулах байгууллагыг хууль тогтоомжийн хүрээнд, хүний эрхийг зөрчихгүйгээр ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж гамшгаас сэргийлэх өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн

## КОВИД-19 БА БОЛОВСРОЛ

2020 онд КОВИД-19-ийн цар тахлыг урьдчилан сэргийлэх зорилгоор төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нэг нь боловсролын салбарыг бүхэлд нь зайн сургалтын горимд шилжүүлсэн явдал. Энэхүү үйл ажиллагаа нь боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт хэрхэн нөлөөлснийг үнэлж дүгнэх судалгааны ажлыг дэмжиж ажиллалаа. Уг судалгааг “Эрдэм” сургалт судалгааны хүрээлэнгийн баг хийж гүйцэтгэв. Судалгааны дүр дүнгээс харахад БШУЯ, БМДИ, Боловсролын хүрээлэн болон Үнэлгээний төв зэрэг байгууллагын 110 мэргэжилтэн, 428 багш 4,485 цагийн хичээл бэлтгэж 18 телевизийн сувгаар суралцагчдадаа хүргэж, мөн econtent.mn цахим санд байршуулжээ. Теле-хичээлд хамрагдалтын улсын дундаж 75 орчим хувь, харин Улаанбаатарт 88.4 хувь байна гэж албаны эх сурвалжид дурдсаныг судалгааны баг цахилгаан, интернэт, цахим төхөөрөмжийн хүртээмж, ухрааж үзэх боломж зэрэг дэд бүтцийн үзүүлэлттэй холбон судлахад теле-хичээл үзэх боломж Улаанбаатарт 85 орчим хувь, хөдөө орон нутагт 61 хувь буюу албан эх сурвалжийн тооцоолсноос бага гарчээ. Тэрчлэн хөгжлийн бэрхшээлтэй сурагчид сурлагаар хоцрох эрсдэл

хязгаарлалт тогтоож байгаа бөгөөд энэ хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хөндлөнгийн мониторинг хийх тэтгэлгийг Глоб интернэйшнл төв ТББ-д олголоо.

нөхцөлд хууль сахиулах байгууллагын мөрдөх дүрэм, журамд судалгаа хийж, шаардлагатай зөвлөмж, саналыг хүргэлээ. Тэрчлэн хөл хорионы дэглэмийн үеийн цагдаагийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийх тэтгэлгийг Монголын Эмнести Интернэйшнл ТББ-д олгоод байгаа бөгөөд үр дүнг 2021 онд олон нийтэд хүргэнэ.

нэмэгдэж, улмаар 2019 оноос шинээр хэрэгжиж эхэлсэн тэгш хамруулан сургах боловсролын бодлого орхигдох, хөгжлийн бэрхшээлтэй сурагчид олноор сургууль завсардах эрсдэл үүсэх магадлалтай байгааг судалгааны тайланд дурджээ.

Тэрчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхийн амьжиргаа, хүүхдийн сурлагад үзүүлж буй нөлөөг судалж, баримтжуулахад эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн идэвхтнүүдтэй хамтран ажиллалаа. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамтран Ковид-19-ийн цар тахлаас сэргийлэх зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь тэдний өрхийн эдийн засаг, хүүхдийн боловсрол, сэтгэцийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буйг баримтжуулах давтамжит мониторинг хийжээ. 2020 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Түгээмэл хөгжил төв, Сонсголгүйн боловсрол ТББ, Хараагүйчүүдийн үндэсний холбоо, Монголын Аутизмын холбоо, Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо зэрэг байгууллага цуврал мониторинг хийж гүйцэтгэн эхнээсээ үр дүнг олон нийтэд хүргээд байна.

Уг санаачилгын хүрээнд байгууллага, холбоод нь хоорондоо туршлага дамжуулан хамтран ажиллаж, чанарын судалгаа гүйцэтгэх арга зүйд хамтран суралцахын зэрэгцээ гишүүдээ сонсож, тэдний дуу хоолой болох замаар сэтгэл санааны дэмжлэг үзүүлэн, эв нэгдлээ бэхжүүлж ажиллалаа.

Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо ТББ-аас 2020 оны 3 дугаар сараас ажиллуулж эхэлсэн Дохионы хэлний видео дуудлагын үйлчилгээг дэмжиж 24 цагаар хоёр ээлжээр ажиллах нэг сарын үйл ажиллагааг санхүүжүүлэв. Интернэтэд суурилсан уг үйлчилгээнд холбогдсон сонсгол, хэл ярианы

## КОВИД-19 БА ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Цар тахлаас үүдэн зөвхөн манай улсад төдийгүй дэлхий нийтээр гэр бүлийн хүчирхийлэл өсөж байгаа үзүүлэлт байна. Тиймээс гадаад, дотоодын зээл тусламжийн тодорхой хэсгийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд чиглүүлж байгаа тул тус тусламж зорилтот бүлэгтээ хүрч буй эсэхийг үнэлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гадаад, дотоодын зээл тусламжийн үр нөлөө” сэдвээр судалгааны ажлыг эхлүүлээ. Үүний зэрэгцээ гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад нь Хүчирхийллийн эсрэг үндэсний төвдэмжлэг үзүүлж тэтгэлэг олголоо. Мөн 2008 оноос эхлэн бэлгийн хүчирхийллийн хохирогч насанд хүрээгүй хүүхдүүд болон тэдний асран хамгаалагч нарт нийгэм-сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа “Хөөрхөн зүрхнүүд” ТББ-д цар тахлын үед эрсдэлд өртөж буй бүлгүүдэд анхан шатны туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нь тогтвортой байлгах зорилгоор тэтгэлэг олголоо. 2020 оны хувьд Ковид 19 цар тахлын хүнд нөхцөл байдлын улмаас хохирогчдын тоо нэмэгдэх, нөгөөтээгүүр үйл ажиллагааны санхүүжилт босгоход хүндрэлтэй байдал үүссэн ажээ. Ингэснээр 2021 онд зорилтот бүлгийн хэрэгцээг хангах ажлыг тасралтгүй

бэрхшээлтэй хот, хөдөөгийн хүмүүс төр, орон нутгаас гаргасан шийдвэрийг лавлах, халдвар хамгааллын зөвлөгөө авах, мөн цагдаа, замын цагдаа, онцгой байдал, захиргааны байгууллага, эмнэлэг, түргэн тусламжийн ажилтантай харилцахдаа хэлмэрчийн үйлчилгээ авдаг юм. 2020 оны 11 дүгээр сард дотоодын халдвар илэрсний дараа мэдээлэл, зөвлөгөө авах, мөн хөл хорио, шинжилгээ, хөл хорионд орсон хүмүүсийн байнгын оршин суух орон нутаг руу зорчих боломжийг нэг удаа нээх шийдвэр зэрэг цаг үеийн асуудалтай холбоотой үг үйлчилгээний ачаалал эрс нэмэгдсэн юм.

хэрэгжүүлэх, цар тахлын нөлөөллийн судалгаа хийх боломжтой болж байна.

Тэрчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байр, Баривчлах төвд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгсдэд зориулсан Зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр боловсруулахад зориулж тэтгэлэг олголоо. Тус сургалтын хөтөлбөр боловсруулагдсанаар цаашид 21 аймагт тус хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулагдах юм. Манай улсын хувьд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил гаргахад 7-30 хоногийн баривчлах шийтгэл ногдуулдаг ба баривчлах шийтгэл авсан нийт хүний 70 гаруй хувийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил эзэлдэг ажээ. Уг шийтгэлийг нийслэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төв, Баривчлах байранд; орон нутагт Цагдаагийн газрын харьяа баривчлах байруудад хэрэгжүүлж байна. Баривчлах шийтгэлийг эдлэх хугацаанд Зан үйлд нөлөөлөх сургалтад тодорхой цагаар суухыг хуульд тусгасан боловч үр дүнтэй сургалтын хөтөлбөргүй явж ирсэн нь уг зохицуулалтын үр нөлөөг бууруулж байгаа болох нь ННФ-аас хэрэгжүүлсэн мониторингийн төслийн үр дүнгээс харагдаж байна.



нөлөөтэй байсныг судлах төсөлд тэтгэлэг олголоо. Уг судалгааг Улаанбаатар хотын худалдааны танхим (УБХХТ) хэрэгжүүлсэн бөгөөд Улаанбаатар хотын 4 дүүрэг, 5 аймгийн 1600 гаруй иргэнийг хамруулсан юм. Судалгааны дүнгээр Засгийн газраас авч

хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд эергээр нөлөөлөөгүй нь харагдсан болно. Судалгааны дүнг 2020 оны 11 дүгээр сард УБХХТ-аас нийтэд хүргэв.



### СЭДВИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН




### КОВИД-19 БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Ковид ба хөгжлийн бэрхшээл цувралын анхны дугаараар ННФ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд хэрхэн тусаж байгааг судлан үр дүнг олон нийтэд хүргэлээ. Судалгаанд оролцсон хот, хөдөөгийн 90 гаруй өрх 2020 оны 4 дүгээр сарын байдлаар мэдээлэл өгсөн тул уг тайланд 5 дугаар сараас хэрэгжсэн татварын хөнгөлөлт, бэлэн мөнгөний дэмжлэгийн нөлөө тусаагүй болно (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).

Ковид ба хөгжлийн бэрхшээл цувралын 2 дахь дугаараар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Монголын аутизмын холбоо хамтран КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл өрхөд хэрхэн тусаж байгааг судалсан дүнг олон нийтэд хүргэлээ. Өмнөх судалгаа 2020 оны 4 дүгээр сарын нөхцөл байдлыг хамарсан бол энэ удаагийнх 5 сарын нөхцөл байдлыг авч үзэв (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).






### ХӨЛ ХОРИО БА ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ АСУУДАЛ

2020 оны 11 сард улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдал зарлагдаж эрүүл мэндийн, албан, хувийн шалтгаанаар нийслэлд ирсэн орон нутгийн иргэдийн зорчих эрх хязгаарлагдан машиндаа хоноглох, бага насны хүүхэд эцэг, эхээсээ тусдаа үлдэх зэрэг олон сөрөг үр дагавар гарсан. Эдгээр иргэнд анхаарал хандуулж, яаралтай арга хэмжээ авах нь хүний эрхэд нийцэх талаар зөвлөмж гаргасан (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).




### ХӨЛ ХОРИО БА ЭХ ОРОНДОО БУЦАЖ ИРЭХ ЭРХ

Ковидын халдвар дотоодод тархсаны улмаас Монгол Улс Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин тусгай үүргийн нислэг зогсож, гадаадад байгаа иргэдийн эх орондоо ирэх боломж тодорхойгүй хугацаагаар хойшлон орон байр, хоол хүнсний гагцдалд орсон. Уг нөхцөл байдлыг судлан үр дүнг энэхүү цувралд нийтлэв (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ХӨЛ ХОРИО БА ДОТУУР БАЙРАНД БҮЙ ОЮУТНЫ ЗОРЧИХ ЭРХ

Хатуу хөл хорионы үед Улаанбаатар хотод дотуур байранд амьдарч байгаа их дээд сургуулийн оюутнуудын нөхцөл байдлыг судлах зорилгоор оюутнуудаас ярилцлагын аргаар судалгаа авахад наад захын эрхийн зөрчлүүд байгаа нь тодорхой болсон. Тэдний хоол хүнсээр хангагдах, орон гэртээ харих зэрэг асуудлууд тулгамдаж байв (бүрэн эхээр нь [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ИРГЭНИЙГ ГЭРТ НЬ ЛАЦДАХ, ТҮГЖИХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НЬ ХУУЛЬ БУС БОЛОХ ТУХАЙ

Коронавируст цар тахлын халдварыг хязгаарлах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын Онцгой комисс мэдэгдэл гаргаж түүнд туссан шаардлагыг зөрчсөн тохиолдолд хүний эрхийг ноцтой зөрчихүйц шийтгэл оногдуулахаар тусгажээ. Тухайлбал, ...шаардлагатай тохиолдолд тухайн өрхийн хаалгыг лацдах хүртэл арга хэмжээ авах тухай мэдэгджээ (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).




### ХӨЛ ХОРИОНЫ ҮЕ ДЭХ АМЬД ЯВАХ, ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тавьсан үед иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх зөрчигдөж, эсхүл зөрчигдөж болзошгүй байгаа нөхцөл байдлыг судлан зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагуудад хүргэв. Тухайлбал, амь нас эрсдэж болзошгүй тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламж авахад нотлох баримт шаардалгүй нэвтрүүлэх гэх мэт иргэдэд тулгарч буй асуудлыг анхааруулахыг зорьжээ (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Цар тахлын дэгдэлтийг зогсоход технологи ашигласан зарим орны туршлагаас энэ дугаарт танилцуулжээ. Энэхүү туршлагыг шууд нэвтрүүлэх гэхээс илүүтэй технологи ашиглахдаа хүний эрхийг хамгийн бага хязгаарлах, эрх мэдлийг урвуулан ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн оновчтой шийдэл сонгохыг зөвлөв (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



### ХӨЛ ХОРИО БА ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ

Ковид-19 вирус халдварын нөхцөл байдлаас хүндэрч, амаргүй цаг үед ажиллаж байгаа хэдий ч төр засгийн зүгээс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцэж явагдах учиртай. Энэхүү хөндлөнгийн шинжилгээгээр үүсээд буй тохиолдлыг шинжлэх замаар гарц шийдэл санал болгохыг зорилоо ([www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## БОЛОВСРОЛЫН САЛБАРТ КОРОНАВИРУСТ ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨЛӨЛ: ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ҮР ДҮН, НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

“Эрдэм” сургалт судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль баталж хэрэгжүүлэхээс өмнөх болон баталснаас хойш Засгийн газар, Улсын онцгой комисс, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан шийдвэр, зөвлөмж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг эрчим хүч, мэдээлэл харилцаа холбоо, зам тээвэр зэрэг дэд бүтцийн хүртээмжтэй уялдуулан судлав. Уг судалгаа нь холбогдох байгууллагуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүртээмж, үр нөлөөний талаар мэдээлэх зорилготой хөндлөнгийн мониторингийн үр дүн юм (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## ХӨЛ ХОРИО БА ЭХ ОРОНДОО ИРЭХ ЭРХ

Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан Монгол Улсын иргэний “эх орондоо буцаж ирэх” үндсэн эрхийн хэрэгжилтийг уг судалгаанд авч үзсэн ба түүний дотор “Ковид-19” цар тахлын онцгой үед хэрэгжиж буй дотоодын хууль, тогтоомжид хүний эрхийн хязгаарлалт, түүнд тавигдах шаардлага, үндэслэлийн талаар хэрхэн зааж тусгасныг шинжилж, бодит байдалд тэдгээр шаардлага, үндэслэл нь хангагдаж байгаа эсэхэд үнэлгээ хийв. Тэрчлэн цар тахал дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хилийн хориг, түүнийг тусгасан хууль тогтоомжийн үндэслэл, хэрэгжилтийг хөндлөнгөөс үнэлж, дүгнэх үүднээс Япон Улс болон Европын холбооноос “Ковид 19” цар тахлын дэгдэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн хилийн хоригийн арга хэмжээ, татан авах ажиллагаа, түүнтэй холбоотой шийдвэр, туршлагыг харьцуулан судалжээ (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



## “БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДАЛ”-ЫН ҮЕД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧИЙН МӨРДӨЖ АЖИЛЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ БА ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Ж.Ганбаатар ахлагчтай судалгааны баг цар тахлын онцгой нөхцөл байдлын үед Цагдаагийн байгууллага, түүний алба хаагчийн мөрдөж ажиллах хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг энэ судалгаагаар үнэлж гаргахыг зорьжээ. Цар тахалтай тэмцэх ажилд, алба хаагчид ямар хууль эрх зүйн актыг голлон мөрдөж, ямар үүрэгтэй оролцож байгааг, мөн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хуульд зааснаас гадна нэмэлт эрх эдлэх үү, алба хаагчдын ажлын ачаалал нь үүрэг гүйцэтгэхэд нөлөөлж байна уу гэх зэрэг асуудлыг судалгааны баг сонгож хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд дүн шинжилгээ хийлээ (бүрэн эхээр [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү).



# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2020 онд нийт 1,800,900 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$1,776,800 нь Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$21,000 IDEA; \$3,100 бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг доор хүснэгтээр харуулав.

## НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ</b>			
Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх нь	76,582	68,691	145,273
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох нь	81,915	99,194	181,109
Төсвийн хариуцлагыг сайжруулах	51,800	97,503	149,303
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих нь	65,193	125,175	190,368
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ</b>			
Хүний эрх		54,138	54,138
Эрүүгийн эрх зүйн шинэчлэл	74,421	93,540	167,961
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	48,033	95,572	143,605
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	25,912	28,370	54,281
<b>БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО</b>			
Тэгш хамруулах боловсрол	66,266	51,820	118,086
Залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх	23,808	48,617	72,425
<b>ЦАР ТАХЛЫН ХАРИУ ҮЙЛДЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	158,886	6,292	165,178
<b>ЗАХИРГАА</b>	-	279,157	279,157
<b>НИЙТ ДҮН</b>	672,815	1,048,068	1,720,883

## НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт тэтгэлгийн зардал
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ</b>			
Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх нь	76,582	-	76,582
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох нь	81,915	-	81,915
Төсвийн хариуцлагыг сайжруулах	51,800	-	51,800
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих нь	54,277	10,916	65,193
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ</b>			
Хүний эрх	-	-	-
Эрүүгийн эрх зүйн шинэчлэл	61,221	13,200	74,421
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	32,380	15,653	48,033
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	25,912	-	25,912
<b>БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО</b>			
Тэгш хамруулах боловсрол	66,266	-	66,266
Залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх	23,808	-	23,808
<b>ЦАР ТАХЛЫН ХАРИУ ҮЙЛДЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>158,886</b>	<b>-</b>	<b>158,886</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>633,047</b>	<b>39,768</b>	<b>672,815</b>

## 2020 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, Иргэн	Төрөл	Тэтгэлгийн дүн	
				төгрөг	ам.доллар
1	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	12,555,000	4,561
2	Улаанбаатар	Мидас	ТББ	11,821,875	4,267
3	Улаанбаатар	Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд	ТББ	39,982,000	14,435
4	Улаанбаатар	Глоб интернэшнл төв	ТББ	26,732,000	9,651
5	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	45,350,000	16,367
6	Улаанбаатар	Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв	ТББ	15,725,000	5,671
7	Улаанбаатар	ШУТИС, Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	Төрийн байгууллага	42,826,300	15,399
8	Улаанбаатар	Монголын аутизмын холбоо	ТББ	12,400,000	4,447
9	Улаанбаатар	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	ТББ	24,000,000	8,607
10	Улаанбаатар	А.Түвшинтөгс	Иргэн	6,000,000	2,152
11	Улаанбаатар	Б.Ананд	Иргэн	5,000,000	1,793
12	Улаанбаатар	Б.Амарсанаа	Иргэн	4,612,000	1,654
13	Улаанбаатар	Хөгжлийн академи	ТББ	7,000,000	2,510
14	Улаанбаатар	Б.Анхзаяа	Иргэн	7,270,000	2,607
15	Улаанбаатар	Ц.Цэлмэг	Иргэн	4,750,000	1,703
16	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	12,050,000	4,323
17	Улаанбаатар	Монголын криминологичдын холбоо	ТББ	30,885,000	11,081
18	Баянхонгор	Амьд хууль төв	ТББ	5,676,150	2,022
19	Улаанбаатар	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо	ТББ	10,590,000	3,772
20	Завхан	Өрнөх хөгжил	ТББ	7,280,000	2,593
21	Багануур	Залуус манлайлал төв	ТББ	5,110,000	1,820
22	Булган	Булганы мэдээ сонин	ТББ	2,573,500	917
23	Өвөрхангай	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	6,552,000	2,334
24	Өвөрхангай	Орон нутгийн санаачилга	ТББ	6,279,050	2,236
25	Өмнөговь	Нийгмийн дэвшлийн эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	3,169,000	1,129
26	Улаанбаатар	Транспэрэнси Интернэшнл- Монгол	ТББ	35,250,000	12,555
27	Улаанбаатар	Б.Баярмаа	Иргэн	16,620,000	5,920
28	Улаанбаатар	Нийгмийн ажлын багш сургагчдын холбоо	ТББ	66,841,880	23,808

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, Иргэн	Төрөл	Тэтгэлгийн дүн	
				төгрөг	ам.доллар
29	Улаанбаатар	Түгээмэл хөгжил Төв	ТББ	2,600,000	926
30	Улаанбаатар	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо	ТББ	1,600,000	570
31	Улаанбаатар	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	ТББ	2,600,000	926
32	Улаанбаатар	Монголын аутизмын холбоо	ТББ	1,600,000	570
33	Улаанбаатар	Монголын дауны холбоо	ТББ	1,600,000	570
34	Улаанбаатар	Б.Баярмаа	Иргэн	12,353,396	4,400
35	Улаанбаатар	М.Үнэнбат	Иргэн	12,353,396	4,400
36	Улаанбаатар	Г.Гантулга	Иргэн	12,353,396	4,400
37	Улаанбаатар	Эрдэм сургалт судалгааны хүрээлэн	ТББ	4,800,000	1,701
38	Ховд	Ховдын толь сонин	ТББ	13,034,000	4,620
39	Орхон	Төр иргэн түншлэл	ТББ	11,103,500	3,936
40	Дархан-Уул	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	6,722,000	2,383
41	Сэлэнгэ	Цэнгэг ерөө	ТББ	5,027,750	1,782
42	Улаанбаатар	Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо	ТББ	15,267,125	5,412
43	Булган	Байгаль орчныг хамгаалах нөхөн үржүүлэх иргэдийн нөхөрлөл бүлгүүдийн холбоо	ТББ	4,334,000	1,536
44	Орхон	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл	ТББ	3,074,800	1,090
45	Төв	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	4,845,500	1,718
46	Говьсүмбэр	Хотол чойр	ТББ	10,304,400	3,653
47	Дорнод	Буйрнуур халх гол нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	7,288,100	2,583
48	Өвөрхангай	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	9,150,000	3,243
49	Дорнод	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо	ТББ	4,886,000	1,732
50	Багануур	Залуус манлайлал төв	ТББ	6,328,500	2,243
51	Улаанбаатар	Жавхлант гэрэлт ирээдүй	ТББ	9,925,000	3,518
52	Булган	Булганы өнгө	ТББ	7,450,100	2,641
53	Булган	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	2,000,000	709
54	Дархан-Уул	МҮХАҮТ-ын Дархан-Уул аймаг дахь салбар танхим	ТББ	5,775,000	2,047
55	Увс	Сайнтус төв	ТББ	7,719,500	2,736

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, Иргэн	Төрөл	Тэтгэлгийн дүн	
				төгрөг	ам.доллар
56	Багануур дүүрэг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	7,886,000	2,795
57	Архангай	Даацтай хөгжлийн ирээдүй	ТББ	6,170,000	2,187
58	Өвөрхангай	Түмний түүчээ	ТББ	5,525,000	1,958
59	Улаанбаатар	Зургаан буудлын оршин суугчдын эрх ашгийг хамгаалагчдын холбоо	ТББ	5,315,250	1,884
60	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	13,981,000	4,956
61	Өвөрхангай	Эх нутаг хөгжил төв	ТББ	5,410,000	1,918
62	Улаанбаатар	Улаанбаатар хотын худалдааны танхим	ТББ	9,609,700	3,406
63	Улаанбаатар	Байгаль орчин эрүүл мэнд төв	ТББ	13,485,000	4,766
64	Улаанбаатар	Монголын эмнести интернэшнл	ТББ	102,000,000	35,882
65	Төв	Энэрэнгүй хүсэл	ТББ	4,087,500	1,449
66	Орхон	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл	ТББ	7,822,800	2,773
67	Улаанбаатар	Ил тод байдал сан	ТББ	9,173,660	3,266
68	Улаанбаатар	Тэгш хүртээмж бие даан амьдрах төв	ТББ	8,326,000	2,917
69	Сэлэнгэ	Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо	ТББ	4,972,000	1,742
70	Улаанбаатар	Ардчиллын боловсрол төв	ТББ	20,970,800	7,351
71	Улаанбаатар	Глоб интернэшнл төв	ТББ	114,114,000	40,000
72	Говь-Алтай	Арвайн хан тайшир	ТББ	4,704,600	1,649
73	Улаанбаатар	Н.Баярмаа	Иргэн	14,237,500	4,996
74	Улаанбаатар	Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо	ТББ	2,600,000	926
75	Улаанбаатар	Сонсголгүйн боловсрол	ТББ	1,600,000	570
76	Улаанбаатар	Б.Хонгорзул	Иргэн	5,365,000	1,882
77	Улаанбаатар	Б.Баялагмаа	Иргэн	5,000,000	1,755
78	Улаанбаатар	Өмгөөллийн эл би партнерс	ХХН	6,000,000	2,106
79	Улаанбаатар	Алисон энд кэйт партнерс	ХХН	7,947,250	2,789
80	Улаанбаатар	Д.Ганхүрэл	Иргэн	6,000,000	2,106
81	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	11,324,500	3,975
82	Улаанбаатар	Их бага баяншарга сан	ТББ	18,893,200	6,631
83	Улаанбаатар	Бүх нийт боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл	ТББ	21,100,000	7,405
84	Улаанбаатар	Түгээмэл хөгжил	ТББ	120,050,000	42,134



Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, Иргэн	Төрөл	Тэтгэлгийн дүн	
				төгрөг	ам.доллар
85	Улаанбаатар	Ангир нүдэн мөндөөхэй хөдөлгөөн	ТББ	6,845,600	2,403
86	Ховд	Шинэ эвлэл	ТББ	4,600,000	1,614
87	Дорнод	Буйрнуур халх гол нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	2,770,000	972
88	Баянхонгор	Хонгор нутгийн дуудлага	ТББ	1,580,000	555
89	Говьсүмбэр	Хотол чойр	ТББ	3,497,500	1,227
90	Дорноговь	Эх орон хамтын хүч	ТББ	6,317,500	2,217
91	Ховд	Жавхлант гэрэлт ирээдүй	ТББ	4,405,000	1,546
92	Баянхонгор	Амьд хууль төв	ТББ	1,580,000	555
93	Улаанбаатар	Монголын криминологичдын холбоо	ТББ	28,309,000	9,935
94	Улаанбаатар	Тува ээж	ТББ	10,465,500	3,673
95	Улаанбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа баривчлах байр	Төрийн байгууллага	99,110,000	34,782
96	Улаанбаатар	Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо	ТББ	6,195,000	2,174
97	Улаанбаатар	Хөөрхөн зүрхнүүдийн аян	ТББ	56,784,000	19,929
98	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	94,270,000	33,083
99	Улаанбаатар	Монголын олон нийтийн медиа контент	ТББ	15,279,000	5,362
100	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн иргэний нийгмийн нэгдсэн зөвлөл	ТББ	8,252,500	2,896
101	Улаанбаатар	Тува ээж	ТББ	15,880,000	5,572
102	Улаанбаатар	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо	ТББ	34,700,000	12,177
103	Баян-Өлгий	Гэрэлт хөгжлийн тэмүүлэл	ТББ	22,210,920	7,794
104	Улаанбаатар	Мидас	ТББ	30,950,575	10,861
105	Улаанбаатар	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ	15,000,000	5,264
106	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	103,500,000	36,320
107	Улаанбаатар	Монголын эмнести интернэшнл	ТББ	30,090,000	10,559
108	Улаанбаатар	Хөөрхөн зүрхнүүдийн аян	ТББ	1,050,000	368
109	Улаанбаатар	Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо	ТББ	31,560,200	11,076
110	Улаанбаатар	Хүүхдийн оюуны боловсролыг дэмжих төв	ТББ	28,280,000	9,925
111	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	15,000,000	5,422
<b>ДҮН</b>				<b>1,903,149,273</b>	<b>672,815</b>

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

### Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

---

О.Мөнхсайхан	Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн ХЗС-ийн профессор, Хууль зүйн доктор
Г.Уранцоож	Удирдах зөвлөлийн гишүүн, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж.Үнэнбат	Удирдах зөвлөлийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын зөвлөх
Ч.Лодойравсал	Удирдах зөвлөлийн гишүүн, МУИС-ын Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан Дэд захирал
П.Наранбаяр	Удирдах зөвлөлийн гишүүн, Сайн сургуулийг таны дэргэд ТББ-ын тэргүүн
Д.Энхжаргал	Удирдах зөвлөлийн гишүүн, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний Ерөнхий зохицуулагч
Ч.Болортуяа	Удирдах зөвлөлийн гишүүн, ikon.mn Ерөнхий редактор

### Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

---

П. Эрдэнэжаргал

### Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

---

П.Бадамрагчаа	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
А.Гэрэлмаа	Боловсрол, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн менежер
Д.Оюунбадам	Засаглалын хөтөлбөрийн менежер
Б.Хишигсайхан	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
Д.Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
Д.Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
О.Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б.Ундармаа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б.Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Д.Балжид	Мэдээллийн менежер
Б.Мөнхгэрэл	Мэдээллийн ажилтан
Д.Жавхлан	Захиргаа, Санхүүгийн захирал
Ж.Алтанчимэг	Тэтгэлгийн менежер
Б.Лхагвацэрэн	Тэтгэлгийн менежер
В.Халиунцэцэг	Нягтлан бодогч
Э.Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч
Б.Амгалан	Захиргааны ажилтан
Б.Баатар	Захиргааны туслах ажилтан
Г.Цэдэвхүү	Захиргааны туслах ажилтан
Б.Бат-Эвлэл	Захиргааны туслах ажилтан

---

Нийтлэг И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

---



## ЖИЛИЙН ТАЙЛАН 2020

---

Нээлттэй Нийгэм Форум

Жамьян гүний гудамж - 5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240, Монгол Улс

Утас: 76113207

<http://www.forum.mn>

<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>

[http://www.instagram.com/open\\_society\\_forum](http://www.instagram.com/open_society_forum)

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.